# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 33 (462)

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- *Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай*

## МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

- *Гаалийн бүрдүүлэлтийн горимыг хялбарчлах, уялдуулах тухай олон улсын конвенц*

Улсын Их Хурлын Тамгын газар
Улаанбаатар хот
2006 он

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ
Долоо хоног тутмын

Улаанбаатар хот | 2006 оны есдүгээр сарын 7 | №33 (462)


## Гарчиг


**Нэг. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

552. Чулуунгомбын Цэрэндуламд Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай — Дугаар 272 — 973
553. Балдангийн Алтанцэцэгт Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай — Дугаар 273 — 973
554. Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай — Дугаар 274 — 974

**Хоёр. МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ**

555. Гаалийн бүрдүүлэлтийн горимыг хялбарчлах, уялдуулах тухай олон улсын конвенц — 974


## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2006 оны 8 дугаар сарын 25-ны өдөр** | **Дугаар 272** | **Улаанбаатар хот**

### Чулуунгомбын Цэрэндуламд Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай

Хүүхэд, залуучууд, боловсролын байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж, хүүхэд залуучуудын байгууллагын соёл хүмүүжлийн орчинг бүрдүүлэн материаллаг баазыг бэхжүүлэх, залуу үеийг амьдрах ухаанд сургахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Монголын хүүхэд залуучуудын хөгжлийн төвийн зөвлөх Чулуунгомбын Цэрэндуламд Монгол Улсын гавьяат багш цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ** **Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2006 оны 8 дугаар сарын 25-ны өдөр** | **Дугаар 273** | **Улаанбаатар хот**

### Балдангийн Алтанцэцэгт Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай

Соёл урлагын байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж Монголын бүжгийн урлагт орчин үеийн бүжгийн төрлийг үүсгэн хөгжүүлэх, бүжгийн дээд шатны сургалтын тогтолцоог бий болгож олон улсын түвшинд хүргэх, мэргэжлийн боловсон хүчин бэлтгэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж СУИС-ийн Бүжгийн урлагийн тэнхмийн эрхлэгч, дэд профессор Балдангийн Алтанцэцэгт Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ** **Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 8 дугаар сарын 25-ны өдөр | Дугаар 274 | Улаанбаатар хот

### Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай

Монголын залуучуудын хөдөлгөөн үүсч хөгжсөний 85 жилийн ойг тохиолдуулан дор дурьдсан залуучуудын байгууллагын ажилтан, идэвхтэн дэмжигчид, залуу авьяастан, уран бүтээлчдийг одон, медалиар шагнасугай.

**ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:**

1. Хаймчигийн Оюунчимэг - Гэрлэх ёслолын ордны дарга
2. Ядамсүрэнгийн Санжмятав - Улсын Их Хурлын гишүүн
3. Ойдовжамцын Энхтуул - Улсын драмын эрдмийн театрын жүжигчин

**"АЛТАН ГАДАС" ОДОНГООР:**

1. Дамдинсүрэнгийн Гантулга - Говь-Алтай аймгийн Залуучуудын холбооны тэргүүлэгч
2. Магсаржавын Дүүриймаа - Монголын залуучуудын холбооны эдийн засгийн албаны ажилтан
3. Намнангийн Наранбаатар - Улсын драмын эрдмийн театрын жүжигчин
4. Даваасамбуугийн Одонгоо - Нийслэлийн үсчин, гоо сайхны "Видал" төвийн захирал
5. Баатарын Отгонбат - Олон улсын хүүхдийн "Найрамдал" төвийн дэд захирал
6. Довдонбалжирын Оюунцэцэг - Улаанбаатар хотын Залуучуудын холбооны тэргүүн
7. Бэгзсүрэнгийн Оюунчимэг - Монголын залуучуудын холбооны Гүйцэтгэх хорооны нарийн бичгийн дарга
8. Цэрэндоржийн Саранцэцэг - "Шри шри" амьдрах ухаан бясалгалын төвийн тэргүүн

**ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:**

1. Найдангийн Ганбаатар - Монголын залуучуудын холбооны Багануур дүүрэг дэх салбар зөвлөлийн тэргүүлэгч
2. Наранбямбын Ганболд - Орхон аймгийн Залуучуудын холбооны тэргүүлэгч
3. Очирбатын Доржхад - Монголын залуучуудын холбооны ажилтан
4. Жамъян-Осорын Эрдэнэчимэг - Монголын залуучуудын холбооны ажилтан

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР

## МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

### ГААЛИЙН ГОРИМЫГ ХЯЛБАРЧЛАХ, УЯЛДУУЛАХ ТУХАЙ ОЛОН УЛСЫН КОНВЕНЦИД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ПРОТОКОЛ*

**(1999 оны 6 дугаар сарын 26-ны өдөр Брюссель хотноо үйлдэв)**

Гаалийн хамтын ажиллагааны Зөвлөл (цаашид "Зөвлөл" гэнэ)-ийн ивээлээр байгуулагдсан Гаалийн горимыг хялбарчлах, уялдуулах тухай олон улсын Конвенц (1973 оны 5 дугаар сарын 18-ны өдөр Киото хотноо үйлдсэн бөгөөд 1974 оны 9 дүгээр сарын 25-ны өдөр хүчин төгөлдөр болсон цаашид "Конвенц" гэнэ)-ийн Хэлэлцэн тохирогч Талууд,

Дараах зорилтод хүрэхийн тулд Конвенцид нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай гэж ҮЗЭЖ:

- Олон улсын худалдаа болон олон улсын бусад арилжаа солилцоонд саад учруулж болох Хэлэлцэн тохирогч Талуудын мөрдөж буй гаалийн горим, практик ажиллагааны хоорондын зөрүүг арилгах,

- гаалийн горим, практик ажиллагааг хөнгөвчлөх, хялбарчлах, уялдуулах болон олон улсын худалдаа, гаалийн албаны хэрэгцээ шаардлагыг хангах,

- гаалийн хяналтын зохих стандартыг баталгаажуулах, болон

- бизнес, захиргааны арга ажиллагаанд гарсан томоохон өөрчлөлттэй гааль зохицон ажиллах чадвартай байх нөхцлийг хангах,

Нэмэлт өөрчлөлт оруулсан Конвенц нь түүнчлэн:

- тийнхүү хялбарчлах, уялдуулах ажлын тулгуур зарчмууд нь нэмэлт өөрчлөлт оруулсан Конвенцийн Хэлэлцэн тохирогч Талуудын заавал баримтлах үүрэг гэдгийг заах ёстой,

- гаалийн албанд тохиромжтой бөгөөд үр дүнтэй хяналтын аргад түшиглэсэн эрчимтэй үйл ажиллагааг нэвтрүүлэх ёстой.

**Гаалийн бүрдүүлэлтийн горимыг хялбарчлах , уялдуулах тухай олон улсын конвенцид нэгдэн орох тухай Монгол Улсын хууль-"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2006 оны 23 дугаарт нийтлэгдсэн.*

- мөн Зөвлөлийн нэн чухал зорилт болох гаалийн горим, практик ажиллагааг дээд зэрэгт хүртэл хялбарчлах, уялдуулах нөхцлийг бүрдүүлж, ингэснээр олон улсын худалдааг хөнгөвчлөхөд чухал хувь нэмэр үзүүлнэ гэж ҮЗЭЖ,

Дараахь зүйлийг хэлэлцэн тохиролцов:

**1 дүгээр зүйл**

Конвенцийн удиртгал болон зүйлүүдэд түүний Зүүлт 1-д заасан бичвэрт нэмэлт өөрчлөлт оруулав.

**2 дугаар зүйл**

Конвенцийн хавсралтууд нь түүний Зүүлт 2-ын Ерөнхий хавсралт, Зүүлт 3-ын Тусгай хавсралтаар солигдов.

**3 дугаар зүйл**

1. Конвенцийн Хэлэлцэн тохирогч аливаа Тал түүний 1 дүгээр болон 2 дугаар Зүүлтийг оролцуулан энэхүү Протоколыг дагаж мөрдөхөө дараахь байдлаар илэрхийлж болно:

(a) соёрхон батлах тухай тайлбар хийхгүйгээр түүнд гарын үсэг зурах,

(b) соёрхон батлахаар түүнд гарын үсэг зурсны дараа соёрхон баталсан тухай баримт бичгээ хадгалуулахаар өгөх, эсхүл

(c) түүнд нэгдэн орох.

2. Энэхүү Протокол нь Брюссель хотноо байрладаг Зөвлөлийн төв байранд 2000 оны 6 дугаар сарын 30-ныг хүртэл Конвенцийн Хэлэлцэн тохирогч Талууд гарын үсэг зурахад нээлттэй байна. Түүнээс хойш түүнд нэгдэн ороход нээлттэй болно.

3. Түүний 1 дүгээр болон 2 дугаар Зүүлтийг оролцуулан энэхүү Протокол нь Хэлэлцэн тохирогч дөчин Тал соёрхон батлах тайлбаргүйгээр түүнд гарын үсэг зурсан, эсхүл түүнийг соёрхон баталсан буюу түүнд нэгдэн орсон тухай баримт бичгээ хадгалуулахаар өгснөөс хойш гурван сарын дараа хүчин төгөлдөр болно.

4. Хэлэлцэн тохирогч дөчин Тал 1 дүгээр хэсгийн дагуу энэхүү Протоколыг дагаж мөрдөхөө илэрхийлсний дараа Конвенцийн Хэлэлцэн тохирогч Тал Конвенцид оруулсан нэмэлт өөрчлөлтийг зөвхөн энэхүү Протоколын тал болсноор хүлээн зөвшөөрнө. Хэлэлцэн тохирогч тийм Талын хувьд энэхүү Протокол нь тухайн Тал соёрхон батлах тайлбаргүйгээр уг Протоколд гарын үсэг зурсан, эсхүл соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай баримт бичгээ хадгалуулахаар өгснөөс хойш гурван сарын дараа хүчин төгөлдөр болно.

**4 дүгээр зүйл**

Конвенцийн Хэлэлцэн тохирогч аливаа Тал энэхүү Протоколыг дагаж мөрдөхөө илэрхийлэхдээ түүний 1 дүгээр Зүүлтэд оруулсан аль нэг Тусгай хавсралт, эсхүл түүний аль нэг Бүлгийг хүлээн зөвшөөрч болох бөгөөд тийнхүү хүлээн зөвшөөрсөн тухай болон тайлбар хийж буй Зөвлөмж болгосон жишгийн талаар Зөвлөлийн Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэнэ.

**5 дугаар зүйл**

Энэхүү Протокол хүчин төгөлдөр болсны дараа Зөвлөлийн Ерөнхий нарийн бичгийн дарга Конвенцийг соёрхон баталсан буюу түүнд нэгдэн орсон тухай аливаа баримт бичгийг хүлээн авахгүй.

**6 дугаар зүйл**

Талуудын хоорондын харилцаанд энэхүү Протокол, Зүүлтүүдийнхээ хамт Конвенцийг орлоно.

**7 дугаар зүйл**

Зөвлөлийн Ерөнхий нарийн бичгийн дарга энэхүү Протоколын эх хадгалагч байх бөгөөд энэхүү Протоколын Зүүлт 1-ийн 19 дүгээр зүйлд заасан үүргийг гүйцэтгэнэ.

**8 дугаар зүйл**

Энэүү Протокол нь Брюссель хотноо байрладаг Зөвлөлийн төв байранд 1999 оны 6 дугаар сарын 26-наас эхлэн Конвенцийн Хэлэлцэн тохирогч Талууд гарын үсэг зурахад нээлттэй байна.

**9 дүгээр зүйл**

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дүрмийн 102 дугаар зүйлийн дагуу энэхүү Протокол болон түүний Зүүлтүүдийг Зөвлөлийн Ерөнхий нарийн бичгийн даргын хүсэлтээр Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга нарын газар бүртгүүлнэ.

Дээр дурдсаныг нотолж, зохих ёсоор эрх олгогдсон дор дурдсан гарын үсэг зурагсад энэхүү Протоколд гарын үсэг зурав.

Энэхүү Протоколыг нэг мянга есөн зуун ерэн есөн оны зургаадугаар сарын хорин зургааны өдөр Брюссель хотноо англи, франц хэлээр үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд нь адил хүчинтэй байх ба нэг эх хувийг түүний баталгаат хуулбарыг энэхүү Протоколын Зүүлт 1-ийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан бүх байгууллагуудад явуулах Зөвлөлийн Ерөнхий нарийн бичгийн дарга хадгална.

**ЗҮҮЛТ 1**

**ГААЛИЙН ГОРИМЫГ ХЯЛБАРЧЛАХ, УЯЛДУУЛАХ ТУХАЙ ОЛОН УЛСЫН КОНВЕНЦ**

(Нэмэлт өөрчлөлтийг тусгав)

**УДИРТГАЛ**

Гаалийн хамтын ажиллагааны зөвлөлийн ивээлээр байгуулагдсан энэхүү Конвенцийн Хэлэлцэн тохирогч Талууд,

Олон улсын худалдаа болон олон улсын бусад солилцоонд саад учруулж болох Хэлэлцэн тохирогч Талуудад мөрдөж буй гаалийн горим, практик ажиллагааны хоорондын зөрөөг арилгахыг ЭРМЭЛЗЭЖ,

Гаалийн горим, практик ажиллагааг хялбарчлах, уялдуулах, түүнчлэн олон улсын хамтын ажиллагааг хөхүүлэн дэмжих замаар дээрх худалдаа, солилцоог хөгжүүлэхэд үр дүнтэй хэлбэрээр дэмжлэг үзүүлэхийг ХҮСЧ,

Олон улсын худалдааг хөнгөвчилснөөр гаалийн хяналтын зохих стандартыг хүндрүүлэлгүй мэдэгдэхүйц амжилт олж болохыг ТЭМДЭГЛЭН,

Гаалийн горимыг хялбарчлах, уялдуулах ажлыг ялангуяа, дараахь зарчмуудыг баримтлан сайжруулж болно гэдгийг ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРЧ,

- гаалийн горим, практик ажиллагааг байнга шинэчлэн өөрчлөх зорилтот хөтөлбөр хэрэгжүүлэх, ингэснээр эрчимтэй байдал, үр ашгийг дээшлүүлэх

- гаалийн горим, практик ажиллагааг урьдчилан мэдэх боломжтой, тогтвортой, ил тод байдлаар нэвтрүүлэх,

- сонирхогч талуудыг гаалийн хууль, дүрэм, журам, заавар, горим, практик ажиллагаатай холбогдох шаардлагатай бүхий л мэдээллээр хангах

- эрсдэл тооцолт, аудитад түшиглэсэн хяналт зэрэг орчин үеийн арга техник нэвтрүүлэх, мэдээллийн технологийг практикт өргөн ашиглах,

- зүйтэй гэж үзвэл, бусад улсын байгууллагууд, гаалийн бусад байгууллагууд болон худалдааны хүрээнийхэнтэй хамтран ажиллах,

- олон улсын холбогдох стандартыг хэрэгжүүлэх,

- захиргааны болон шүүхийн хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох энгийн боломжийг холбогдох талуудад олгох,

Дээрх зорилго, зарчмуудыг тусгасан Хэлэлцэн тохирогч Талууд дагаж мөрдөхөөр амлалт авсан олон улсын хэрэгсэл нь Гаалийн хамтын ажиллагааны зөвлөлийн нэн чухал зорилт болох гаалийн горим, практик ажиллагааг дээд зэрэгт хүртэл хялбарчлах, уялдуулахад тус дөхөм болох бөгөөд ингэснээр олон улсын худалдааг хөнгөвчлөхөд чухал хувь нэмэр үзүүлнэ гэдэгт ИТГЭЖ,

Дараахь зүйлийг тохиролцов:

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

### 1 дүгээр зүйл

### Тодорхойлолт

Энэхүү Конвенцийн зорилгоор:

(a) **"Стандарт"** гэж гаалийн горим, практик ажиллагааг хялбарчлах, уялдуулахад зайлшгүй шаардлагатай хэрэгжилтийн заалтыг ойлгоно.

(b) **"Шилжилтийн стандарт"** гэж Ерөнхий хавсралтад заасан бөгөөд хэрэгжилтийн хугацааг нь арай урт тогтоосон Стандартыг ойлгоно.

(c) **"Практик зөвлөмж"** гэж гаалийн горим, практик ажиллагааг хялбарчлах, уялдуулахад чиглэсэн дэвшилттэй хэлбэр бөгөөд аль болох өргөнөөр нэвтрүүлбэл зохих Тусгай хавсралтад заасан заалтыг ойлгоно.

(d) **"Үндэсний хууль тогтоомж"** гэж Хэлэлцэн тохирогч аль нэг Талын эрх бүхий байгууллагаас тогтоосон, Хэлэлцэн тохирогч тухайн Талын нутаг дэвсгэрт нийтээр дагаж мөрдөх хууль, дүрэм журам, бусад арга хэмжээг, эсхүл тухайн Талаас үүрэг хүлээсэн бөгөөд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй гэрээг ойлгоно.

(e) **"Ерөнхий хавсралт"** гэж энэхүү Конвенцид заасан гаалийн бүх горим, практик ажиллагаанд хэрэглэх багц заалтыг ойлгоно.

(f) **"Тусгай хавсралт"** гэж энэхүү Конвенцид заасан гаалийн нэг буюу хэд хэдэн горим, практик ажиллагаанд хэрэглэх багц заалтыг ойлгоно.

(g) **"Заавар"** гэж Стандарт, Шилжилтийн стандарт болон Практик зөвлөмжийг хэрэгжүүлэхэд дагаж мөрдвөл зохих боломжийн зарим арга хэмжээ, ялангуяа, нэлээд чухал ач холбогдол бүхий тэргүүн туршлага, тодорхой жишээг тусгасан Ерөнхий хавсралт, Тусгай хавсралтын заалтууд болон Бүлгүүдийн багц тайлбарыг ойлгоно.

(h) **"Техникийн байнгын хороо"** гэж Зөвлөлийн байнгын хороог ойлгоно.

(i) **"Зөвлөл"** гэж 1950 оны 12 дугаар сарын 15-ны өдөр Брюссель хотноо байгуулсан Гаалийн хамтын ажиллагааны зөвлөл байгуулах тухай Конвенциор байгуулагдсан Байгууллагыг ойлгоно.

(j) **"Гаалийн буюу Эдийн засгийн холбоо"** гэж хэд хэдэн улс орнуудын байгуулсан бөгөөд тэдгээрийг эгнээндээ багтаасан, энэхүү Конвенциор зохицуулсан асуудалтай холбогдуулан тэдгээр улс орнуудад заавал мөрдөх өөрийн журмыг батлах эрх бүхий, мөн түүнчлэн өөрийн дотоод журмын дагуу энэхүү Конвенцид гарын үсэг зурах, түүнийг соёрхон батлах, эсхүл түүнд нэгдэн орох шийдвэр гаргах эрх бүхий Холбоог ойлгоно.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ

## ҮЙЛЧЛЭХ ХҮРЭЭ, БҮТЭЦ

### 2 дугаар зүйл

### Конвенцийн үйлчлэх хүрээ

Хэлэлцэн тохирогч Тал бүр гаалийн горимыг хялбарчлах, уялдуулах ажлыг хөхүүлэн дэмжих, энэ зорилгоор энэхүү Конвенцийн заалтад нийцүүлэн, энэхүү Конвенцийн хавсралтад заасан Стандарт, Шилжилтийн стандарт, Практик Зөвлөмжийг дагаж мөрдөх үүрэг авч байна. Гэвч Хэлэлцэн тохирогч аль нэг Тал тэдгээрт зааснаас илүү хөнгөлөлт үзүүлэхэд саад болох зүйлгүй бөгөөд Хэлэлцэн тохирогч Тал бүр тийм илүү хөнгөлөлтийг аль болох өргөнөөр үзүүлбэл зохино.

### 3 дугаар зүйл

Энэхүү Конвенцийн заалт хориглосон буюу хязгаарласан бараанд гаалийн хяналт тавихтай холбогдсон үндэсний хууль тогтоомжийг хэрэглэхэд саад болохгүй.

### 4 дүгээр зүйл

### Конвенцийн бүтэц

1. Энэхүү Конвенц нь Үндсэн хэсэг, Ерөнхий хавсралт болон Тусгай хавсралтаас бүрдэнэ.

2. Энэхүү Конвенцийн Ерөнхий хавсралт, Тусгай хавсралт тус бүр зарчмын хувьд Бүлгүүдэд хуваагдах бөгөөд Бүлгүүд нь дараахь зүйлээс бүрдэнэ:

А. тодорхойлолт болон

В. Стандарт, Ерөнхий хавсралтад заасан зарим стандарт нь Шилжилтийн стандарт болно.

3. Тусгай хавсралт бүр түүнчлэн Практик зөвлөмжтэй байна.

4. Хавсралт бүр Заавартай байх ба түүний эх бичвэрийг Хэлэлцэн тохирогч Талууд дагаж мөрдөхгүй.

### 5 дугаар зүйл

Энэхүү Конвенцийн зорилгоор, Хэлэлцэн тохирогч Талын дагаж мөрдөх аливаа Тусгай хавсралт буюу түүний Бүлгүүд нь энэхүү Конвенцийн салшгүй хэсэг болох бөгөөд Хэлэлцэн

тохирогч тухайн Талын хувьд энэхүү Конвенциос хийсэн аливаа ишлэлийг дээрх Хавсралт эсхүл Бүлэгт хамааралтай гэж үзнэ.

**ГУРАВДУГААР БҮЛЭГ**
**КОНВЕНЦИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

**6 дугаар зүйл**
**Гүйцэтгэх Хороо**

1. Энэхүү Конвенцийн хэрэгжилт, түүнийг нэг мөр тайлбарлах, хэрэглэх талаар авах аливаа арга хэмжээ, түүнд оруулах нэмэлт өөрчлөлтийг авч үзэх үүрэг бүхий Гүйцэтгэх Хороо байгуулагдана.

2. Хэлэлцэн тохирогч Талууд Гүйцэтгэх Хорооны гишүүд байна.

3. 8 дугаар зүйлийн заалтын дагуу энэхүү Конвенцийн Хэлэлцэн тохирогч Талын аливаа мэргэшсэн байгууллагын, эсхүл Дэлхийн худалдааны байгууллагын аливаа Гишүүний эрх бүхий байгууллага Гүйцэтгэх Хорооны чуулганд ажиглагчаар оролцох эрхтэй байна. Тийм ажиглагчдын статус болон эрхийг Зөвлөлийн шийдвэрээр тодорхойлно. Өмнө дурдсан эрхийг тухайн шийдвэр хүчин төгөлдөр болохоос өмнө хэрэгжүүлж үл болно.

4. Гүйцэтгэх Хороо олон улсын засгийн газар хоорондын болон засгийн газрын бус байгууллагын төлөөлөгчдийг Гүйцэтгэх Хорооны чуулганд ажиглагчаар оролцохыг урьж болно.

5. Гүйцэтгэх Хороо:

А. Хэлэлцэн тохирогч Талуудад дараахь зүйлийг санал болгоно:

I. энэхүү Конвенцийн үндсэн хэсэгт нэмэлт өөрчлөлт оруулах,

II. Ерөнхий хавсралт, Тусгай хавсралт болон түүний Бүлэгт нэмэлт өөрчлөлт оруулах, Ерөнхий хавсралтад шинэ Бүлэг нэмэх, болон

III. Шинээр Тусгай хавсралт нэмэх, Тусгай хавсралтад шинэ Бүлэг оруулах.

В. 16 дугаар зүйлийн дагуу Практик зөвлөмжид нэмэлт өөрчлөлт оруулах, эсхүл Тусгай хавсралт эсхүл түүний Бүлэгт Практик зөвлөмж шинээр оруулах шийдвэр гаргаж болно;

С. 13 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн дагуу энэхүү Конвенцийн заалтын хэрэгжилтийг авч үзнэ;

D. Зааврыг хянан үзэж, шинэчилнэ;

Е. энэхүү Конвенцид хамааралтай бөгөөд түүнд үндэслэж болох аливаа бусад асуудлыг авч үзнэ;

F. өөрийн гаргасан шийдвэрийн талаар Техникийн байнгын хороо болон Зөвлөлд мэдэгдэнэ.

6. Хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий байгууллагад энэхүү зүйлийн 5 (а), (b), (с), эсхүл (d) хэсгийн дагуу холбогдох санал, үндэслэлийг Гүйцэтгэх Хорооны чуулганы хэлэлцэх асуудалд асуудал оруулах аливаа хүсэлтийн хамт Зөвлөлийн нарийн бичгийн даргад хүргүүлнэ. Зөвлөлийн нарийн бичгийн дарга энэхүү зүйлийн 2, 3 болон 4 дэх хэсэгт заасан Хэлэлцэн тохирогч Тал болон ажиглагчийн эрх бүхий байгууллагын сонорт саналыг хүргэнэ.

7. Гүйцэтгэх Хороо жилд нэгээс доошгүй удаа хуралдана. Уг Хороо нь дарга, дэд даргаа жил бүр сонгоно. Зөвлөлийн нарийн бичгийн дарга урилга болон хэлэлцэх асуудлын төслийг энэхүү зүйлийн 2, 3 болон 4 дэх хэсэгт заасан Хэлэлцэн тохирогч Тал болон ажиглагчийн эрх бүхий байгууллагад Гүйцэтгэх Хороо хуралдахаас зургаан долоо хоногийн өмнө тараана.

8. Гүйцэтгэх Хорооны өмнө тавигдсан асуудлыг зөвшилцлийн замаар шийдэх боломжгүй бол хуралдаанд оролцсон Хэлэлцэн тохирогч Талуудын саналаар шийднэ. Энэхүү зүйлийн 5(а), (b), эсхүл (с) хэсгийн дагуу саналыг санал өгөгсдийн гуравны хоёрын саналаар батална. Бусад бүх асуудлыг Гүйцэтгэх Хороо санал өгөгсдийн олонхийн саналаар батална.

9. Хэрэв энэхүү Конвенцийн 8 дугаар зүйлийн 5 дахь хэсгийг хэрэглэх бол Хэлэлцэн тохирогч Талууд болох Гааль буюу эдийн засгийн холбоо Хэлэлцэн тохирогч Талууд болох Гишүүн орнуудад хуваарилагдсан нийт саналын тоотой тэнцэх хэмжээний саналын эрхтэй байна.

10. Гүйцэтгэх Хороо чуулганаа хаахын өмнө тайлангаа батална. Уг тайланг Зөвлөл болон 2, 3 болон 4 дэх хэсэгт заасан Хэлэлцэн тохирогч Тал болон ажиглагчидад хүргүүлнэ.

11. Энэхүү зүйлд заагдаагүй асуудлыг хэрэв Гүйцэтгэх Хороо өөрөө шийдээгүй бол Зөвлөлийн Дотоод журмын дагуу зохицуулна.

**7 дугаар зүйл**

Гүйцэтгэх Хороонд санал авах зорилгоор Тусгай хавсралт бүрээр болон аль нэг Тусгай хавсралтын Бүлэг бүрээр тус тусад нь санал хураана.

А. Хэлэлцэн тохирогч Тал бүр энэхүү Конвенцийн Үндсэн хэсэг болон Ерөнхий хавсралтыг тайлбарлах, хэрэглэх эсхүл нэмэлт өөрчлөлт оруулахтай холбогдсон асуудлаар санал өгөх эрхтэй;

В. Хүчин төгөлдөр болсон Тусгай хавсралт эсхүл Тусгай хавсралтын Бүлэгтэй холбогдсон асуудлын хувьд зөвхөн Тусгай хавсралт буюу түүний Бүлгийг хүлээн зөвшөөрсөн тухайн Хэлэлцэн тохирогч Тал санал өгөх эрхтэй;

С. Хэлэлцэн тохирогч Тал бүр шинэ Тусгай хавсралт буюу Тусгай хавсралтын шинэ Бүлгийн төсөлд санал өгөх эрхтэй.

**ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ**
**ХЭЛЭЛЦЭН ТОХИРОГЧ ТАЛ**

**8 дугаар зүйл**
**Конвенцийг соёрхон батлах**

1. Зөвлөлийн аливаа Гишүүн болон Нэгдсэн Үндэстний Байгууллагын буюу түүний төрөлжсөн байгууллагын аливаа Гишүүн дараахь замаар энэхүү Конвенцийн Хэлэлцэн тохирогч Тал болж болно:

А. соёрхон батлах тухай тайлбар хийгүйгээр гарын үсэг зурах;

B. соёрхон батлахаар түүнд гарын үсэг зурсны дараа соёрхон баталсан тухай баримт бичгээ хадгалуулахаар өгөх; эсхүл

C. түүнд нэгдэн орох.

2. Энэхүү Конвенц энэхүү зүйлийн 1 дэх хэсэгт заасан Гишүүн орнууд Брюссель хотноо байрладаг Зөвлөлийн байранд түүнд гарын үсэг зурахад 1974 оны 6 дугаар сарын 30-ыг хүртэл нээлттэй байна. Түүнээс хойш уг Гишүүн орнууд түүнд нэгдэн ороход нээлттэй болно.

3. Хэлэлцэн тохирогч аливаа Тал энэхүү Конвенцид гарын үсэг зурах, соёрхон батлах, эсхүл нэгдэн ороходоо хэрэв аль Тусгай хавсралт буюу Бүлгийг хүлээн зөвшөөрч байгаа бол түүнийг зааж өгнө. Хэлэлцэн тохирогч аливаа Тал нэг буюу хэд хэдэн Тусгай хавсралт, эсхүл Бүлгийг хүлээн зөвшөөрч байгаа тухай эх хадгалагчид дараа нь мэдэгдэж болно.

4. Аливаа шинэ Тусгай хавсралт буюу Тусгай хавсралтын аливаа шинэ Бүлгийг хүлээн зөвшөөрч буй Хэлэлцэн тохирогч Тал энэхүү зүйлийн 3 дахь хэсгийн дагуу эх хадгалагчид мэдэгдэнэ.

5. (a) Гаалийн буюу эдийн засгийн аливаа холбоо нь энэхүү зүйлийн 1, 2 болон 3 дугаар хэсгийн дагуу энэхүү Конвенцийн Хэлэлцэн тохирогч Тал болж болно. Тийм Гаалийн буюу эдийн засгийн холбоо энэхүү Конвенциор зохицуулах асуудалд хамаарах өөрийн эрх хэмжээг хадгалах тухай мэдэгдэнэ.

(b) энэхүү Конвенцийн Хэлэлцэн тохирогч Тал болох Гаалийн буюу эдийн засгийн холбоо уг холбооны гишүүн улсд энэхүү Конвенциор олгогдсон эрхийг өөрийн эрх хэмжээний хүрээнд өөрийн нэрийн өмнөөс хэрэгжүүлж, хариуцлага хүлээнэ. Энэ тохиолдолд уг холбооны гишүүд санал өгөх эрхийг оролцуулан дээрх эрхийг ганцаарчилсан байдлаар хэрэгжүүлэх эрхгүй.

**9 дүгээр зүйл**

1. Энэхүү Конвенцийг соёрхон баталсан, эсхүл түүнд нэгдэн орсон Хэлэлцэн тохирогч аливаа Тал өөрийн соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай баримт бичгийг хадгалуулахаар өгсөн өдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Ерөнхий хавсралт болон энэхүү Конвенцид орсон аливаа нэмэлт өөрчлөлтийг дагаж мөрдөнө.

2. Тусгай хавсралт, эсхүл түүний Бүлгийг хүлээн зөвшөөрч буй Хэлэлцэн тохирогч аливаа Тал өөрийн хүлээн зөвшөөрсөн тухай баримт бичгийг эх хадгалагчид өгсөн өдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж буй тухайн Тусгай хавсралт буюу Бүлэгт заасан Стандартад орсон аливаа нэмэлт өөрчлөлтийг дагаж мөрдөнө. Тусгай хавсралт, эсхүл түүний Бүлгийг хүлээн зөвшөөрч буй Хэлэлцэн тохирогч аливаа Тал, энэхүү Конвенцийн 12 дугаар зүйлийн дагуу нэг буюу хэд хэдэн Практик зөвлөмжийн эсрэг тайлбар хийгээгүй бол, өөрийн хүлээн зөвшөөрсөн тухай баримт бичгийг эх хадгалагчид өгсөн өдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Тусгай хавсралт буюу Бүлгийн Практик Зөвлөмжид орсон аливаа нэмэлт өөрчлөлтийг дагаж мөрдөнө.

**10 дугаар зүйл**

**Конвенцийг хэрэглэх**

1. Хэлэлцэн тохирогч аливаа Тал олон улсын харилцааг нь хариуцдаг өөрийн бүх буюу аливаа нутаг дэвсгэрт энэхүү Конвенц мөрдөгдөнө гэдгийг соёрхон батлах тухай тайлбар хийхгүйгээр энэхүү Конвенцид гарын үсэг зурахдаа, эсхүл соёрхон батлах буюу нэгдэн орох тухай баримт бичгээ хадгалуулахаар өгөхдөө, эсхүл түүнээс хойш аль ч үед эх хадгалагчид мэдэгдэл өгөх замаар зарлан тунхаглаж болно. Тийм мэдэгдэл нь түүнийг эх хадгалагч хүлээн авсан өдрөөс хойш гурван сарын дараа хүчин төгөлдөр болно. Гэвч, Хэлэлцэн тохирогч холбогдох Талын хувьд энэхүү Конвенц хүчин төгөлдөр болохоос өмнө мэдэгдэлд дурдсан нутаг дэвсгэрт энэхүү Конвенцийг хэрэглэхгүй.

2. Олон улсын харилцааг нь хариуцдаг өөрийн аливаа нутаг дэвсгэрт энэхүү Конвенцийг хамааруулан энэхүү зүйлийн 1 дэх хэсгийн дагуу мэдэгдэл хийсэн Хэлэлцэн тохирогч аливаа Тал тухайн нутаг дэвсгэрт энэхүү Конвенцийг хэрэглэхгүй болсныг энэ Конвенцийн 19 дүгээр зүйлийн журмын дагуу эх хадгалагчид мэдэгдэж болно.

**11 дүгээр зүйл**

Энэхүү Конвенцийг хэрэглэхийн тулд Хэлэлцэн тохирогч Тал болох Гаалийн буюу эдийн засгийн холбоо уг Гаалийн буюу эдийн засгийн холбоог бүрдүүлж буй нутаг дэвсгэрийн талаар Зөвлөлийн Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэх бөгөөд эдгээр нутаг дэвсгэрийг нэг нутаг дэвсгэр гэж үзнэ.

**12 дугаар зүйл**

**Заалт хүлээн зөвшөөрөх, тайлбар хийх**

1. Хэлэлцэн тохирогч бүх Тал үүгээр Ерөнхий хавсралтыг дагаж мөрдөнө.

2. Хэлэлцэн тохирогч Тал нэг буюу хэд хэдэн Тусгай хавсралт, эсхүл түүний нэг буюу хэд хэдэн Бүлгийг хүлээн зөвшөөрч болно. Тусгай хавсралт буюу түүний Бүлгийг хүлээн зөвшөөрч буй Хэлэлцэн Тохирогч Тал тэдгээрт заасан бүх Стандартыг дагаж мөрдөнө. Тусгай хавсралт буюу түүний Бүлгийг хүлээн зөвшөөрч буй Хэлэлцэн тохирогч Тал өөрийн үндэсний хууль тогтоомж болон Практик зөвлөмжийн зөрөөг зааж, тайлбар хийж байгаа Практик зөвлөмжийн талаар тухайн Тусгай хавсралт буюу Бүлгийг хүлээн зөвшөөрөх үедээ, эсхүл түүнээс хойш аль ч эх хадгалагчид мэдэгдээгүй бол тэдгээрт заасан бүх Практик зөвлөмжийг дагаж мөрдөнө. Тайлбар хийсэн Хэлэлцэн тохирогч аливаа Тал эх хадгалагчид мэдэгдэх замаар түүнийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн хэзээ ч цуцалж болох бөгөөд чингэхдээ цуцлалт хүчин төгөлдөр болох өдрийг заана.

3. Тусгай хавсралт буюу Бүлгийг дагаж мөрдөх Хэлэлцэн тохирогч Тал бүр 2 дахь хэсгийн нөхцлийн дагуу Практик зөвлөмжид хийсэн аливаа

тайлбараа цуцлах боломжийг судалж, түүний үр дүнг энэхүү Конвенц Хэлэлцэн тохирогч тухайн Талын хувьд хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн гурван жил тутам Зөвлөлийн Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэж, тухайн Талын бодлоор, уг тайлбарыг цуцлахад зөрчилдөж буй өөрийн үндэсний хууль тогтоомжийн заалтыг дурдана.

**13 дугаар зүйл**

**Заалтыг хэрэгжүүлэх**

1. Хэлэлцэн тохирогч Тал бүр Хэлэлцэн тохирогч тухайн Талын хувьд Ерөнхий Хавсралт буюу Бүлэг хүчин төгөлдөр болсноос хойш 36 сарын дотор хүлээн зөвшөөрсөн тийм Хавсралтын болон Тусгай хавсралт буюу түүний Бүлгийн стандартыг хэрэгжүүлнэ.

2. Хэлэлцэн тохирогч Тал бүр Ерөнхий хавсралт нь Хэлэлцэн тохирогч тухайн Талын хувьд хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 60 сарын дотор Ерөнхий хавсралтын Шилжилтийн стандартыг хэрэгжүүлнэ.

3. Хэлэлцэн тохирогч Тал бүр өөрийн хүлээн зөвшөөрсөн Тусгай хавсралт буюу Бүлгийн Практик зөвлөмжийг, хэрэв нэг буюу хэд хэдэн Практик зөвлөмжид тайлбар хийгээгүй бол уг Тусгай хавсралт буюу Бүлэг Хэлэлцэн тохирогч тухайн Талын хувьд хүчин төгөлдөр болсноос хойш 36 сарын дотор хэрэгжүүлнэ.

4. (a) Хэрэв энэхүү зүйлийн 1 буюу 2 дахь хэсэгт заасан хугацаа Хэлэлцэн тохирогч аливаа Талын хувьд Ерөнхий хавсралтын заалтыг хэрэгжүүлэхэд практик үүднээс хангалтгүй байвал Хэлэлцэн тохирогч тухайн Тал энэхүү зүйлийн 1 буюу 2 дахь хэсэгт заасан хугацаа дуусахаас өмнө уг хугацааг сунгаж өгөхийг Гүйцэтгэх Хорооноос хүсч болно. Хэлэлцэн тохирогч Тал, тийм хүсэлт тавихдаа хугацааг нь сунгах шаардлагатай байгаа Ерөнхий хавсралтын заалт болон тийм хүсэлтийг тавих болсон нөхцлийг дурдана.

(b) Онцгой тохиолдолд, Гүйцэтгэх Хороо түүнийг сунгах шийдвэр гаргаж болно. Тийм хугацаа сунгах тухай Гүйцэтгэх Хорооны аливаа шийдвэрт уг шийдвэрийг гаргах болсон онцгой тохиолдлыг дурдсан байх бөгөөд сунгалт ямар ч тохиолдолд нэг жилээс илүү хугацаатай байж болохгүй. Сунгалтын хугацаа дуусах үед Хэлэлцэн тохирогч Тал хугацаа сунгасан заалтын хэрэгжилтийн талаар эх хадгалагчид мэдэгдэнэ.

**14 дүгээр зүйл**

**Маргаан шийдвэрлэх**

1. Энэхүү Конвенцийг тайлбарлах эсхүл хэрэглэхтэй холбогдуулан Хэлэлцэн тохирогч хоёр буюу хэд хэдэн Талуудын хооронд үүссэн аливаа маргааныг тэдний хооронд аль болох хэлэлцээний замаар шийдвэрлэнэ.

2. Маргаанд оролцогч Хэлэлцэн тохирогч Талууд хэлэлцээний замаар шийдэгдээгүй аливаа маргааныг Гүйцэтгэх Хороонд уламжлах бөгөөд тус Хороо нь маргааныг хянан үзэж, өөрийн шийдвэрлэсэн тухай зөвлөмж гаргана.

3. Маргаанд оролцогч Хэлэлцэн тохирогч Талууд Гүйцэтгэх Хорооны заавал биелүүлэх зөвлөмжийг хүлээн зөвшөөрөх талаар урьдчилан тохирч болно.

**15 дугаар зүйл**

**Конвенцид оруулах нэмэлт өөрчлөлт**

1. 6 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн (a) (i) ба (ii) заалтын дагуу Гүйцэтгэх Хорооноос Хэлэлцэн тохирогч Талуудад санал болгосон аливаа нэмэлт өөрчлөлтийн эх бичвэрийг Зөвлөлийн Ерөнхий нарийн бичгийн дарга Хэлэлцэн тохирогч бүх талууд болон Хэлэлцэн тохирогч Тал биш боловч Зөвлөлийн Гишүүдэд тараана.

2. Конвенцийн Үндсэн хэсэгт оруулсан нэмэлт өөрчлөлт тийм нэмэлт өөрчлөлтийг тараасан өдрөөс хойш арван хоёр сарын дотор Хэлэлцэн тохирогч аливаа Тал татгалзсан тухай хариу ирүүлээгүй бол Гүйцэтгэх Хорооны тухайн нэмэлт өөрчлөлтийг санал болгосон чуулганд оролцсон Хэлэлцэн тохирогч Талууд хүлээн зөвшөөрсөн тухай баримт бичгээ хадгалуулснаас хойш арван хоёр сарын дараа Хэлэлцэн тохирогч бүх Талуудын хувьд хүчин төгөлдөр болно.

3. Ерөнхий хавсралт, эсхүл Тусгай хавсралт буюу Бүлэгт оруулахаар санал болгосон аливаа нэмэлт өөрчлөлт, дор дурдсанаас бусад тохиолдолд түүнийг Хэлэлцэн тохирогч Талуудад тараасан өдрөөс хойш зургаан сарын дараа хүлээн зөвшөөрөгдсөн гэж үзнэ:

А. Хэлэлцэн тохирогч Тал татгалзсан хариу өгсөн, эсхүл Тусгай хавсралт буюу Бүлгийн хувьд, тухайн Тусгай хавсралт буюу Бүлгийг дагаж мөрдөх ёстой Хэлэлцэн тохирогч Тал татгалзсан хариу өгсөн; эсхүл

В. Хэлэлцэн тохирогч Тал санал болгосон нэмэлт өөрчлөлтийг хүлээн зөвшөөрөх бодолтой байгаа боловч тийнхүү хүлээн зөвшөөрөхөд шаардлагатай нөхцөл хараахан бүрдээгүй байгаа талаар Зөвлөлийн Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдсэн.

4. Хэрэв Хэлэлцэн тохирогч Тал энэхүү зүйлийн 3 дахь хэсгийн (b) заалтад заасны дагуу Зөвлөлийн Ерөнхий нарийн бичгийн даргад албан тоот илгээсэн бөгөөд санал болгосон тухайн нэмэлт өөрчлөлтийг хүлээн зөвшөөрсөн тухайгаа Зөвлөлийн Ерөнхий нарийн бичгийн даргад нэгэнт мэдэгдээгүй бол энэхүү зүйлийн 3 дахь хэсэгт заасан зургаан сарын хугацаа дууссаны дараа арван найман сарын дотор уг нэмэлт өөрчлөлтийг хүлээн зөвшөөрөхөөс татгалзсан тухай хариу ирүүлж болно.

5. Хэрэв санал болгосон нэмэлт өөрчлөлтийг энэхүү зүйлийн 3 (a) буюу 4 дэх хэсэгт заасан нөхцлийн дагуу татгалзсан тухай мэдэгдсэн бол тухайн нэмэлт өөрчлөлт нь хүлээн зөвшөөрөгдөөгүй гэж үзэх бөгөөд хүчингүйд тооцогдоно.

6. Хэрэв Хэлэлцэн тохирогч аливаа Тал энэхүү зүйлийн 3 дахь хэсгийн (b) заалтын дагуу албан тоот илгээсэн бол тухайн нэмэлт өөрчлөлтийг

дараахь хоёр өдрийн аль түрүүчээр нь хүлээн зөвшөөрсөн гэж үзнэ:

A. тийм албан тоот илгээсэн Хэлэлцэн тохирогч бүх Тал санал болгосон тухайн нэмэлт өөрчлөлтийг хүлээн зөвшөөрсөн тухай Зөвлөлийн Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдсэн өдөр, хэрэв тийнхүү хүлээн зөвшөөрсөн тухайгаа энэхүү зүйлийн 3 дахь хэсэгт заасан зургаан сарын хугацаа дуусахаас өмнө бүгд мэдэгдсэн бол уг өдөр нь дээрх зургаан сарын хугацаа дуусан өдөр байна;

B. энэхүү зүйлийн 4 дэх хэсэгт заасан арван найман сарын хугацаа дууссан өдөр.

7. Хүлээн зөвшөөрөгдсөн гэж үзсэн Ерөнхий хавсралт, эсхүл Тусгай хавсралт буюу Бүлэгт оруулсан аливаа нэмэлт өөрчлөлтийг тийнхүү хүлээн зөвшөөрсөн гэж үзэж буй өдрөөс хойш зургаан сарын дараа, эсхүл санал болгосон тухайн нэмэлт өөрчлөлтөд өөр хугацаа заасан бол тийнхүү хүлээн зөвшөөрсөн гэж үзэж буй өдрөөс хойш уг хугацаа дууссан өдөр хүчин төгөлдөр болно.

8. Зөвлөлийн Ерөнхий нарийн бичгийн дарга санал болгосон тухайн нэмэлт өөрчлөлтийг энэхүү зүйлийн 3 дахь хэсгийн (a) заалтын дагуу хүлээн зөвшөөрөхөөс татгалзсан аливаа тохиолдлын талаар болон 3 дахь хэсгийн (b) заалтын дагуу хүлээн авсан аливаа албан тоотын талаар энэхүү Конвенцийн Хэлэлцэн тохирогч Талуудад аль болох түргэн хугацаанд мэдэгдэнэ. Зөвлөлийн Ерөнхий нарийн бичгийн дарга тийм албан тоот илгээсэн Хэлэлцэн тохирогч Тал буюу Талууд санал болгосон тухайн нэмэлт өөрчлөлтийг хүлээн зөвшөөрөхөөс татгалзсан, эсхүл хүлээн зөвшөөрсөн эсэхийг Хэлэлцэн тохирогч Талуудад нэн даруй мэдэгдэнэ.

**16 дугаар зүйл**

1. Гүйцэтгэх Хороо, энэхүү Конвенцийн 15 дугаар зүйлд заасан нэмэлт өөрчлөлт оруулах журмыг үл харгалзан, аливаа Практик зөвлөмжид өөрчлөлт оруулах, эсхүл аливаа тусгай хавсралт буюу Бүлэгт Практик зөвлөмж шинээр нэмж оруулах шийдвэрийг 6 дугаар зүйлийн дагуу гаргаж болно. Зөвлөлийн Ерөнхий нарийн бичгийн дарга Хэлэлцэн тохирогч бүх Талыг Гүйцэтгэх Хорооны хэлэлцүүлэгт урина. Зөвлөлийн Ерөнхий нарийн бичгийн дарга тийнхүү шийдсэн аливаа нэмэлт өөрчлөлт буюу шинэ Практик Зөвлөмжийн бичвэрийг Хэлэлцэн тохирогч Талууд болон энэхүү Конвенцийн Хэлэлцэн тохирогч Тал биш боловч Зөвлөлийн Гишүүн бусад улсуудад тараана.

2. Энэхүү зүйлийн 1 дэх хэсгийн дагуу шийдсэн аливаа нэмэлт өөрчлөлт буюу шинээр оруулах Практик зөвлөмж нь Зөвлөлийн Ерөнхий нарийн бичгийн дарга тэдгээрийг тарааснаас хойш зургаан сарын дараа хүчин төгөлдөр болно. Тийм нэмэлт өөрчлөлт буюу шинээр оруулах Практик зөвлөмжид хамаарах нэг Тусгай хавсралт буюу Бүлгийг дагаж мөрдөх ёстой Хэлэлцэн тохирогч Тал бүр энэхүү Конвенцийн 12 дугаар зүйлд заасан журмын дагуу тайлбар хийгээгүй бол тэдгээр нэмэлт, өөрчлөлт, шинэ Практик зөвлөмжийг хүлээн зөвшөөрсөн гэж үзнэ.

**17 дугаар зүйл**

**Нэгдэн орох хугацаа**

1. Энэхүү Конвенц нь хугацаагүй байгуулагдсан боловч Хэлэлцэн тохирогч аливаа Тал түүнийг 18 дугаар зүйлийн дагуу хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш хэдийд ч цуцалж болно.

2. Цуцлах тухай баримт бичгийг бичгээр үйлдэж, эх хадгалагчид хадгалуулах замаар мэдэгдэнэ.

3. Цуцлалт нь цуцлах тухай баримт бичгийг эх хадгалагч хүлээн авснаас хойш зургаан сарын дараа хүчин төгөлдөр болно.

4. Энэхүү зүйлийн 2 болон 3 дахь хэсгийн заалтууд Хэлэлцэн тохирогч аливаа Тал өөрийн хүлээн зөвшөөрсөн шийдвэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш хэдийд ч цуцалж болох Тусгай хавсралт буюу түүний Бүлэгт бас хамаарна.

5. Ерөнхий хавсралтыг хүлээн зөвшөөрсөн шийдвэрээ цуцалсан Хэлэлцэн тохирогч аливаа Тал энэхүү Конвенцийг цуцалсан гэж үзнэ. Энэ тохиолдолд 2 болон 3 дахь хэсгийн заалтууд бас хамаарна.

## ТАВДУГААР БҮЛЭГ
## ТӨГСГӨЛИЙН ЗААЛТ

**18 дугаар зүйл**

**Конвенц хүчин төгөлдөр болох**

1. Энэхүү Конвенц түүний 8 дугаар зүйлийн 1 болон 5 дахь хэсэгт заасан Хэлэлцэн тохирогч таван тал соёрхон батлах тухай тайлбар хийхгүйгээр энэхүү Конвенцид гарын үсэг зурсан, эсхүл соёрхон буюу нэгдэн орсон тухай баримт бичгийг хадгалуулахаар өгснөөс хойш гурван сарын дараа хүчин төгөлдөр болно.

2. Энэхүү Конвенц нь Хэлэлцэн тохирогч аливаа Тал 8 дугаар зүйлийн дагуу Хэлэлцэн тохирогч Тал болсноос хойш гурван сарын дараа тэдгээрийн хувьд хүчин төгөлдөр болно.

3. Энэхүү Конвенцийн аливаа Тусгай хавсралт буюу Бүлэг Хэлэлцэн тохирогч таван Тал тухайн Тусгай хавсралт буюу түүний Бүлгийг хүлээн зөвшөөрснөөс хойш гурван сарын дараа хүчин төгөлдөр болно.

4. Аливаа Тусгай хавсралт буюу Бүлэг энэхүү зүйлийн 3 дахь хэсгийн дагуу хүчин төгөлдөр болсон бол тухайн Тусгай хавсралт буюу түүний Бүлэг Хэлэлцэн тохирогч аливаа Тал түүнийг хүлээн зөвшөөрсөн тухайгаа мэдэгдсэнээс хойш гурван сарын дараа тэдгээрийн хувьд хүчин төгөлдөр болно. Гэвч ямар ч Тусгай хавсралт буюу түүний Бүлэг Хэлэлцэн тохирогч холбогдох Талын хувьд энэхүү Конвенц хүчин төгөлдөр болоогүй байхад Хэлэлцэн тохирогч аль нэг Талын хувьд хүчин төгөлдөр болохгүй.

**19 дүгээр зүйл**

**Конвенцийн эх хадгалагч**

1. Энэхүү Конвенц, соёрхон батлах тухай тайлбар хийсэн буюу хийгээгүй бүх гарын үсэг зурсан, соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай

бүх баримт бичиг Зөвлөлийн Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалагдана.

2. Эх хадгалагч:

A. энэхүү Конвенцийн үндсэн эх бичвэрийг хүлээн авч, хадгална;

B. энэхүү Конвенцийн үндсэн эх бичвэрийн баталгаат хуулбарыг хийж, Хэлэлцэн тохирогч Талууд болон Хэлэлцэн тохирогч Тал биш боловч Зөвлөлийн Гишүүд, мөн Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хүргүүлнэ;

C. энэхүү Конвенцийг соёрхон батлах тухай тайлбар хийсэн буюу хийгдээгүй аливаа гарын үсэг, соёрхон баталсан буюу нэгдэн орсон байдал, мөн түүнтэй холбоотой аливаа баримт бичиг, мэдэгдэл, албан тоотыг хүлээн авч, хадгална;

D. гарын үсэг, эсхүл энэхүү Конвенцид холбогдох аливаа баримт бичиг, мэдэгдэл буюу албан тоот нь зохих ёсоор, зохих хэлбэрээр үйлдэгдсэн эсэхийг шалгаж, хэрэв шаардлагатай бол холбогдох асуудлыг Хэлэлцэн тохирогч тухайн Талд уламжилнад

E. Хэлэлцэн тохирогч Талууд, Хэлэлцэн тохирогч Тал биш боловч Зөвлөлийн Гишүүд, мөн Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад дараахь зүйлсийн талаар мэдэгдэнэ:

- энэхүү Конвенцийн 8 дугаар зүйлийн дагуу гарын үсэг зурсан, соёрхон баталсан буюу нэгдэн орсон, Хавсралт болон Бүлгийг хүлээн зөвшөөрсөн байдал;

- Гүйцэтгэх Хорооноос энэхүү Конвенцид оруулахаар санал болгон шийдвэрлэсэн шинэ Тусгай хавсралт буюу түүний Бүлэг болон Ерөнхий хавсралтын шинэ Бүлэг;

- энэхүү Конвенцийн 18 дугаар зүйлийн дагуу энэхүү Конвенц, Ерөнхий хавсралт болон Тусгай хавсралт буюу түүний Бүлэг тус бүр хүчин төгөлдөр болсон өдөр;

- энэхүү Конвенцийн 8, 10, 11, 12 болон 13 дугаар зүйлийн дагуу хүлээн авсан мэдэгдэл;

- Хэлэлцэн тохирогч Талууд Хавсралт/Бүлгийг хүлээн зөвшөөрсөн шийдвэрээ цуцалсан байдал;

- энэхүү Конвенцийн 17 дугаар зүйлийн дагуу хийсэн цуцлалт; болон

- энэхүү Конвенцийн 15 дугаар зүйлийн дагуу хүлээн зөвшөөрсөн аливаа нэмэлт өөрчлөлт, түүний хүчин төгөлдөр болсон өдөр.

3. Хэрэв Хэлэлцэн тохирогч Тал болон эх хадгалагчийн хооронд эх хадгалагчийн үүргийн биелэлттэй холбогдсон аливаа маргаан үүсвэл эх хадгалагч буюу Хэлэлцэн тохирогч тухайн Тал уг асуудлыг Хэлэлцэн тохирогч бусад Тал болон гарын үсэг зурахдаа, эсхүл тухайн тохиолдлоос шалтгаалан Гүйцэтгэх Хороо буюу Зөвлөлд уламжилна.

**20 дугаар зүйл**
**Бүртгэх болон адил хүчинтэй эх бичвэрүүд**

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дүрмийн 102 дугаар зүйлийн дагуу, энэхүү Конвенцийг Зөвлөлийн Ерөнхий нарийн бичгийн даргын хүсэлтээр Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга нарын газарт бүртгэнэ.

Дээр дурдсаныг нотолж, зохих ёсоор эрх олгогдсон дор дурдсан гарын үсэг зурагсад энэхүү Конвенцид гарын үсэг зурав.

Энэхүү Конвенцийг нэг мянга есөн зуун далан гурван оны тав дугаар сарын арван наймны өдөр Киото хотноо англи, франц хэлээр үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд нь адил хүчинтэй байх ба нэг эх хувийг түүний баталгаат хуулбарыг энэхүү Протоколын Зүүлт 1-ийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан бүх байгууллагуудад явуулах Зөвлөлийн Ерөнхий нарийн бичгийн дарга хадгална.

**ЗҮҮЛТ 2**

**ЕРӨНХИЙ ХАВСРАЛТ**

АГУУЛГА


1 дүгээр бүлэг Нийтлэг зарчим

2 дугаар бүлэг Тодорхойлолт

3 дугаар бүлэг Бүрдүүлэлт, гаалийн ёс журмын ажиллагаа

4 дүгээр бүлэг Гаалийн болон бусад татвар

A. Гаалийн болон бусад татварыг тооцох, барагдуулах, ногдуулах хураах

Б. Гаалийн болон бусад татварыг хойшлуулах

B. Гаалийн болон бусад татварыг буцаан олгох

5 дугаар бүлэг Баталгаа

6 дугаар бүлэг Гаалийн хяналт

7 дугаар бүлэг Мэдээллийн технологийг ашиглах

8 дугаар бүлэг Гаалийн байгууллага болон гуравдагч этгээд хоорондын харилцаа

9 дүгээр бүлэг Гаалийн байгууллагаас өгөх мэдээлэл гаргах шийдвэр, журам

A. Нийтлэг хэрэгцээний мэдээлэл

Б. Тусгай мэдээлэл

B. Шийдвэр болон журмууд

10 дугаар бүлэг Гаалийн асуудлаар давж заалдах

A. Давж заалдах эрх

Б. Давж заалдах үндэслэл, хэлбэр

B. Давж заалдсан асуудлыг хянан шийдвэрлэх


**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ**
**НИЙТЛЭГ ЗАРЧИМ**

1.1 Стандарт

Энэхүү Хавсралтын тодорхойлолт, стандарт болон шилжилтийн стандарт нь энэхүү хавсралтад дурдсан гаалийн горим болон практик ажиллагаанд хамаарах бөгөөд холбогдолтой гэж үзвэл Тусгай Хавсралтуудад заасан горим болон практик ажиллагаанд нэгэн адил хамаарна.

1.2 Стандарт

Энэхүү Хавсралт болон Тусгай Хавсралтад заасан горим, практик ажиллагааны болон нөхцөлүүд болон гаалийн ёс журмыг үндэсний хууль тогтоомжид заах бөгөөд тэдгээр нь аль болох энгийн, ойлгомжтой байна.

1.3 Стандарт

Гаалийн байгууллага олон улсын хэлэлцээр болон үндэсний хууль тогтоомжийн заалтад нийцсэн хамгийн үр дүнтэй ажлын аргыг нэвтрүүлэхэд худалдааны хамтын ажиллагаагаа өргөжүүлэх болон оролцоог хөхүүлэн дэмжих, тэдэнтэй зөвлөлдөх албан ёсны харилцааг бий болгож хөгжүүлнэ.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ
## ТОДОРХОЙЛОЛТ

Энэ конвенцийн Хавсралтуудын зорилгод:

E1./F23.

**"давж заалдах"** гэж гаалийн байгууллагын шийдвэр буюу эс үйлдлийн нөлөөгөөр өөрийгөө хохирсонд тооцож буй аливаа этгээд хохирлоо нөхөн төлүүлэх үүднээс эрх бүхий байгууллагад хандах үйл ажиллагааг хэлнэ.

E2./F19.

**"гаалийн болон бусад татварыг тооцох"** гэж төлбөл зохих гаалийн болон бусад татварын хэмжээг тодорхойлохыг хэлнэ.

E3./F4.

**"аудитад суурилсан хяналт"** гэж холбогдох этгээдийн худалдааны мэдээлэл, бизнесийн систем, санхүүгийн баримт, бүртгэлийг шалгах замаар мэдүүлгийн үнэн зөвийг гаалийн байгууллага нотлох үүднээс авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг хэлнэ.

E4./F15.

**"барааны мэдүүлгийг шалгах"** гэж гаалийн мэдүүлгийг үнэн зөв бүрдүүлсэн, мөн дагалдах бичиг баримтууд нь заасан нөхцлүүдийг хангасан эсэхийг шалгах үүднээс гаалийн байгууллагаас явуулж байгаа үйл ажиллагааг хэлнэ;

E5./F9.

**"бүрдүүлэлт"** гэж барааг дотоодод ашиглахаар оруулах, гаргах, эсхүл гаалийн өөр горимоор оруулахыг зөвшөөрөх гаалийн ёс журмын ажиллагааг хэлнэ.

E6./F10.

**"гаалийн байгууллага"** гэж гаалийн хуулийн хэрэгжилтийг хангуулах, гаалийн болон бусад татварыг хураан авах, мөн импорт, экспорт болон барааны хадгалалт, хөдөлгөөнтэй холбогдолтой бусад хууль, журмуудыг мөрдөх чиг үүрэг бүхий Засгийн газрын үйлчилгээний албыг хэлнэ.

E7./F3.

**"гаалийн хяналт"** гэж гаалийн хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор гаалийн байгууллагаас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг хэлнэ.

E8./F11.

**"гаалийн татвар"** гэж гаалийн нутаг дэвсгэрт орж байгаа буюу гарч байгаа бараанд гаалийн тарифын дагуу ногдуулах татварыг хэлнэ.

E9./F16.

**"гаалийн журам"** гэж гаалийн хуулийг хэрэгжүүлэх зорилгоор гаалийн байгууллага болон холбогдох этгээдэээс явуулах ёстой бүхий л үйл ажиллагааг хэлнэ.

E10./F18.

**"гаалийн хууль"** гэж бараа импортлох, экспортлох, барааны хөдөлгөөн, хадгалалтад хамаарах бөгөөд зохион байгуулалтын асуудлыг гаалийн байгууллагад тусгайлан олгосон хуулийн болон журмын заалтууд, мөн гаалийн байгууллагаас хуулийн хүрээнд гаргасан журмуудыг хэлнэ.

E11./F2.

**"гаалийн газар"** гэж гаалийн ёс журмыг гүйцэтгэх эрх бүхий гаалийн зохион байгуулалтын нэгж болон эрх бүхий байгууллагаас дээрх зорилгоор зөвшөөрсөн барилга байгууламж эсвэл бусад талбайг хэлнэ.

E12./F25.

**"гаалийн нутаг дэвсгэр"** гэж Хэлэлцэн тохирогч Талын гаалийн хууль үйлчлэх нутаг дэвсгэрийг хэлнэ.

E13./F6.

**"шийдвэр"** гэж гаалийн хуульд холбогдох асуудлаар гаалийн байгууллагаас гаргаж байгаа бие даасан актыг хэлнэ.

E14./F7.

**"мэдүүлэгч"** гэж барааны мэдүүлгийг бөглөж өгч байгаа эсхүл түүний нэр дээр мэдүүлэг хийгдэж байгаа этгээдийг хэлнэ.

E15./F5.

**"тогтоосон өдөр"** гэж гаалийн болон бусад татварыг төлөх өдрийг хэлнэ;

E16./F12.

**"гаалийн болон бусад татвар"** гэж импортын гаалийн болон бусад татвар экспортын гаалийн болон бусад татварыг хэлнэ.

E17./F27.

**"барааг шалгах"** гэж тухайн мэдүүлэгт заасантай барааны үнэ, тоо хэмжээ, нөхцөл байдал гарал үүсэл мөн чанар нийцэж буй эсэхийг тогтоохоор гаалийн байгууллагаас явуулж байгаа биет үзлэгийг хэлнэ.

E18./F13.

**"экспортын гаалийн болон бусад татвар"** гэж барааг экспортлох үед эсхүл экспортлохтой холбогдуулан экпортлоход хураах гаалийн болон бусад бүх татвар, төлбөрийг хэлнэ. Гэвч үүнд үндэсний бусад байгууллагын өмнөөс гаалийн байгууллагаас хураасан эсхүл үзүүлсэн үйлчилгээний баралцаалсан өртөгтэй тэнцэх аливаа төлбөрийг оролцуулахгүй.

E19./F8.

**"барааны мэдүүлэг"** гэж холбогдох этгээд барааг гаалийн аль горимд оруулахыг заасан болон уг горимыг хэрэглэхэд гаалийн байгууллагаас

шаардагдах мэдээллийг тусгаж, гаалийн байгууллагаас тогтоосон маягтын дагуу үйлдсэн мэдэгдлийг хэлнэ.

E20./F14.

**"импортын гаалийн болон бусад татвар"** гэж барааг импортлохтой холбогдуулан бусад байгууллагын өмнөөс гаалийн байгууллагын хураах эсхүл үзүүлсэн үйлчилгээний барагцаалсан өртгийн хэмжээнд хязгаарласан аливаа хураамжаас бусад барааг импортлоход хураах гаалийн болон бусад бүх татвар хураамжийг хэлнэ.

E21./F1.

**"байгууллага хоорондын харилцан туслалцаа"** гэж өөр гаалийн байгууллагатай хамтран эсхүл түүний нэрийн өмнөөс гаалийн хуулийг зөв мөрдөх болон гаалийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнийг мөрдөн шалгах, таслан зогсоох зорилгоор гаалийн байгууллагаас явуулж буй үйл ажиллагааг хэлнэ.

E22./F21.

**"эс үйлдэл"** гэж зохих ёсоор тавьсан асуудлаар гаалийн байгууллага гаалийн хуулийн дагуу боломжийн хугацаанд арга хэмжээ аваагүй эсхүл шийдвэр гаргаагүй эс үйлдлийг хэлнэ.

E23./F22.

**"этгээд"** гэж тухайн заалтад өөрөөр хэрэглэгдээгүй бол хуулийн этгээд болон хувь хүний аль алиныг нь хэлнэ.

E24./F20.

**"барааг олгох"** гэж бүрдүүлэлт хийгдэж буй барааг холбогдох этгээдийн мэдэлд шилжүүлэх гаалийн байгууллагын үйл ажиллагааг хэлнэ.

E25./F24.

**"буцаан олгох"** гэж бараанд төлсөн гаалийн болон бусад татварыг бүхлээр нь эсхүл хэсэгчлэн буцааж олгох, болон төлөгдөөгүй татварыг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн бууруулан багасгахыг хэлнэ.

E26./F17.

**"баталгаа"** гэж гаалийн байгууллагын өмнө хүлээх үүрэг биелэгдэх нөхцөлийг бүрдүүлж гаалийн байгууллагын шаардлага хангахыг хэлнэ. Хэд хэдэн үйл ажиллагаанаас үүсэх үүргийн биелэлтийг хангасан баталгааг "ерөнхий" баталгаа гэнэ.

E27./F26.

**"гуравдагч этгээд"** гэж барааг импортлох, экспортлох, хадгалах болон барааны хөдөлгөөнтэй холбоотой асуудлаар аль нэг этгээдийн төлөө буюу түүний нэрийн өмнөөс гаалийн байгууллагатай шууд харьцах этгээдийг хэлнэ.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ
## БҮРДҮҮЛЭЛТ БОЛОН ГААЛИЙН БУСАД ЖУРМУУД

### Эрх бүхий гаалийн газар

3.1 Стандарт

Гаалийн байгууллага нь барааг гаальд шалгуулах буюу бүрдүүлэлт хийлгэх, зориулалт бүхий гаалийн газруудыг байгуулна. Тэдгээр газрын байршил, ажиллах цаг болон эрхийн хэмжээг тодорхойлоход анхаарах хүчин зүйлүүдэд худалдааны нөхцөл байдлыг оруулж үзнэ.

3.2 Стандарт

Холбогдох этгээдийн хүсэлтээр эсхүл гаалийн байгууллага шаардлагатай гэж үзвэл, гаалийн байгууллага нь өөрийн нөөц бололцооны хүрээнд, гаалийн газрын ажиллах цагаас гадуур, гаалийн газраас өөр газарт гаалийн горим, практик ажиллагааны зорилгоор заагдсан үйл ажиллагаа явуулна. Гаалийн байгууллагаас хураан авах хураамжийн хэмжээ үзүүлсэн үйлчилгээний барагцаалсан өртгийн хэмжээгээр хязгаарлагдана.

3.3 Стандарт

Гаалийн газрууд нь ердийн хилийн нэг гарц дээр байгаа тохиолдолд холбогдох гаалийн байгууллагууд тэдгээрийн ажиллах цаг болон эрхийн хэмжээг уялдуулна.

3.4 Шилжилтийн стандарт

Хилийн ердийн гарц дээр байгаа холбогдох гаалийн байгууллагууд аль болох боломжийн хэмжээнд хамтарсан хяналтыг тавина.

3.5 Шилжилтийн стандарт

Хэрэв гаалийн байгууллага нь шинэ гаалийн газар байгуулах эсхүл хилийн ердийн гарц дээр байгаа гаалийн газрыг өөрчлөх бол аль болох боломжийн хэмжээнд хөрш гаалийн байгууллагатай хамтран ажиллаж нэгдсэн хяналт тавих боломжийг хангах үүднээс холимог бүрэлдэхүүнтэй гаалийн нэг газар байгуулна.

### Мэдүүлэгч

**(а) Мэдүүлэх эрх бүхий этгээд**

3.6 Стандарт

Үндэсний хууль тогтоомжид мэдүүлэгч эрх бүхий этгээдийн нөхцөлүүдийг заасан байна.

3.7 Стандарт

Барааг захиран зарцуулах эрх бүхий этгээд нь мэдүүлэгч байх эрхтэй.

**(б) Мэдүүлэгчийн үүрэг**

3.8 Стандарт

Мэдүүлэгч нь барааны мэдүүлгэд байгаа барааны мэдээллүүдийн үнэн зөвийг хангах, мөн гаалийн болон бусад татварыг төлөх үүргийг гаалийн өмнө хүлээнэ.

**(в) Мэдүүлэгчийн эрх**

3.9 Стандарт

Гаалийн байгууллагаас гаргасан нөхцөлийн дагуу барааг мэдүүлэхээс өмнө мэдүүлэгч нь

(а) барааг шалгах; болон

(б) дээж авах эрхтэй байна.

3.10 Стандарт

Гаалийн байгууллага нь гаалийн хяналтын дор авсан дээжид тусгай барааны мэдүүлэг шаардахгүй бөгөөд дээж нь холбогдох ачилтын барааны мэдүүлэгт хамаарна.

### Барааны мэдүүлэг

**(а) Барааны мэдүүлгийн хэлбэр болон агуулга**

3.11 Стандарт

Барааны мэдүүлгийн агуулгыг гаалийн байгууллага батална. Барааны мэдүүлгийн маягт

нь НҮБ-ын загвартай тохирч байна.

Гаалийн автоматжуулсан бүрдүүлэлтийн хувьд электрон сүлжээгээр мэдүүлэх барааны мэдүүлгийн хэлбэр нь Гаалийн Хамтын Ажиллагааны Зөвлөлийн мэдээллийн технологийн зөвлөмжид заасан электрон мэдээлэл дамжуулах олон улсын стандартад тохирсон байна.

3.12 Стандарт

Гаалийн байгууллага нь барааны мэдүүлгэд шаардагдах мэдээллийг гаалийн хуулийг хэрэгжүүлэх, статистик мэдээ гаргах, гаалийн болон бусад татвар ногдуулахад шаардлагатай мэдээллүүдийг авах хэмжээнд хязгаарлана.

3.13 Стандарт

Хэрэв гаалийн байгууллага шаардлагатай гэж үзвэл мэдүүлэгчид барааны мэдүүлэгт шаардлагатай бүх мэдээлэл байхгүй тохиолдолд урьдчилсан эсхүл бүрэн бус мэдүүлгээр гаалийн байгууллагад мэдүүлэхийг зөвшөөрөх ба энэхүү мэдүүлэгт гаалийн байгууллагаас чухал шаардлагатай гэж үзсэн гол мэдээллийг оруулсан байх бөгөөд мэдүүлэгч нь тодорхой заасан хугацаанд мэдүүлгийг бүрэн болгож өгнө.

3.14 Стандарт

Хэрэв Гаалийн байгууллага урьдчилсан эсхүл бүрэн бус мэдүүлгийг бүртгэж авсан бол уг бараанд ногдох тарифын хэмжээ нь үнэн зөв бүрэн мэдүүлгээр мэдүүлсэн барааны тарифын хэмжээтэй ижил байна.

Холбогдох гаалийн болон бусад татварыг төлөхөд шаардагдах аливаа баталгааг гаргасан тохиолдолд барааг олгохыг хойшлуулахгүй.

3.15 Стандарт

Гаалийн байгууллага нь барааны мэдүүлгийн эх хувийг болон зөвхөн шаардлагатай хамгийн цөөн хувийг шаардана.

**(б) Барааны мэдүүлэгт дагалдах бичиг баримтууд**

3.16 Стандарт

Гаалийн байгууллага нь барааны мэдүүлэгт хавсралт болгож гаалийн хяналт тавих үйл ажиллагаанд шаардлагатай, мөн гаалийн хууль тогтоомжийг дагаж мөрдөхтэй холбоотой бүх шаардлагуудыг хангахад дагалдах бичиг баримтыг шаардана.

3.17 Стандарт

Гаалийн байгууллага шаардлагатай гэж үзвэл дагалдах бичиг баримтыг барааны мэдүүлэгт хавсаргах боломжгүй бол бичиг баримтыг тодорхой заасан хугацаанд гаргаж өгөхийг зөвшөөрнө.

3.18 Шилжилтийн стандарт

Гаалийн байгууллага нь дагалдах бичиг баримтыг электрон сүлжээгээр явуулахыг зөвшөөрнө.

3.19 Стандарт

Гаалийн байгууллага нь барааны мэдүүлгийг хянахад чухал шаардлагатай бичиг баримтаас бусад дагалдах бичиг баримтыг орчуулсан байхыг шаардахгүй.

**Барааны мэдүүлгийг хүлээн авах, бүртгэх, шалгах**

3.20 Стандарт

Гаалийн байгууллага нь барааны мэдүүлгийг аливаа томилогдсон гаалийн газарт хүлээн авахыг зөвшөөрнө.

3.21 Шилжилтийн стандарт

Гаалийн байгууллага нь барааны мэдүүлгийг электрон сүлжээгээр хүлээн авахыг зөвшөөрнө.

3.22 Стандарт

Барааны мэдүүлгийг гаалийн газраас тогтоосон цагийн хуваарьт багтаан хүлээн авна.

3.23 Стандарт

Хэрэв үндэсний хууль тогтоомжид барааны мэдүүлгийг хүлээн авах хугацааг заасан бол энэхүү хугацааг мэдүүлэгч барааны мэдүүлгийг бөглөх, мөн шаардлагатай дагалдах бичиг баримтыг бүрдүүлэхэд хангалттай байхаар заасан байна.

3.24 Стандарт

Мэдүүлэгчийн хүсэлтээр болон гаалийн байгууллага шаардлагатай гэж үзвэл гаалийн байгууллага барааны мэдүүлгийг хүлээн авахад заасан хугацааг сунгана.

3.25 Стандарт

Үндэсний хууль тогтоомжид барааг ирэхээс өмнө барааны мэдүүлгийг хүлээн авах, бүртгэх, шалгах тухай заалтыг оруулсан байна.

3.26 Стандарт

Хэрэв гаалийн байгууллага барааны мэдүүлгийг бүртгэх боломжгүй бол гаалийн байгууллага нь шалтгааныг мэдүүлэгчид тодорхой гаргаж өгнө.

3.27 Стандарт

Гаалийн байгууллага нь мэдүүлэгт өөрчлөлт хийх тухай хүсэлтийг хүлээн авах үед барааны мэдүүлгийг болон барааг шалгаж эхлээгүй бол уг барааны мэдүүлэгт өөрчлөлт хийхийг мэдүүлэгчид зөвшөөрнө.

3.28 Шилжилтийн Стандарт

Гаалийн байгууллага хэрэв барааны мэдүүлгийг шалгаж эхэлсний дараа хүсэлт гаргасан, мэдүүлэгчийн өгсөн шалтгааныг гаалийн байгууллага шаардлагатай гэж үзвэл мэдүүлэгчид барааны мэдүүлгээ өөрчлөхийг зөвшөөрнө.

3.29 Шилжилтийн стандарт

Мэдүүлэгч нь барааг олгохоос өмнө гаалийн байгууллагад хүсэлтээ гаргасан, мөн гаалийн байгууллага шаардлагатай гэж үзвэл барааны мэдүүлгээ буцаан авч, гаалийн өөр журам сонгохыг зөвшөөрнө.

3.30 Стандарт

Барааны мэдүүлгийг бүртгэх үед эсхүл бүртгэлийн дараа нэн даруй барааны мэдүүлгийг шалгана.

3.31 Стандарт

Барааны мэдүүлгийг шалгах зорилгоор гаалийн байгууллага нь зөвхөн гаалийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангахад чухал шаардлагатай гэж үзсэн тийм арга хэмжээг авна.

**Эрх бүхий этгээдэд хамаарах тусгай журам**

3.32 Шилжилтийн стандарт

Гаалийн шаардлагыг зохих ёсоор биелүүлж ирсэн, өөрийн худалдааны үйл ажиллагаагаар сайн зохион байгуулсан зэрэг гаалийн байгууллагаас гаргасан шалгууруудыг хангасан эрх бүхий этгээдийн хувьд гаалийн байгууллага нь:

- барааг таних аль болох бага мэдээлэлд үндэслэн бараагаа олгох бөгөөд барааны мэдүүлгийг дараа нь бүрэн бүрдүүлэхийг зөвшөөрөх;

- барааны бүрдүүлэлтийг мэдүүлэгчийн байранд эсхүл гаалийн зөвшөөрөлтэй газарт хийхийг зөвшөөрөх; болон үүнээс гадна, дараахь бусад тусгай журмыг боломжтой хэмжээгээр мөрдөх:

- нэг этгээд бараагаа заасан хугацаанд хэд хэдэн удаа экспортлох буюу импортлох бол экспорт буюу импортын бүх бараанд барааны нэгдсэн мэдүүлэг бичихийг зөвшөөрөх;

- эрх бүхий этгээд гаалийн болон бусад татварыг өөрөө тооцохын тулд өөрийн худалдааны бүртгэлийг ашиглах, шаардлагатай бол гаалийн байгууллагаас тавих бусад шаардлагыг хангах;

- барааны мэдүүлгийг эрх бүхий этгээдийн бүртгэлд орсноор хүлээн авч дараа нь нэмэлт мэдүүлгээр холбогдох мэдээллийг бүрэн гүйцээж авах.

**Бараагаа шалгах**

(a) Бараагаа шалгахад шаардагдсан хугацаа

3.33 Стандарт

Хэрэв гаалийн байгууллага мэдүүлсэн бараагаа шалгах шийдвэр гаргавал энэхүү шалгалтыг барааны мэдүүлэг бүртгэгдсэний хойш аль болох богино хугацаанд хийнэ.

3.34 Стандарт

Шалгалтын хугацааг товлохдоо амьд амьтан, түргэн муудах бараа болон бусад яаралтай бүрдүүлэлт хийх шаардлагатай бараанд давуу эрх олгоно.

3.35 Шилжилтийн стандарт

Хэрэв бараагаа бусад эрх бүхий байгууллага шалгах шаардлагатай бол гаалийн байгууллага тэдгээр шалгалтыг харилцан уялдуулах, хэрэв боломжтой бол тэдгээр шалгалтыг хамт хийх арга хэмжээг авна.

(b) Бараагаа шалгахад мэдүүлэгчийг байлцуулах

3.36 Стандарт

Гаалийн байгууллага нь мэдүүлэгчээс гаргасан бараагаа шалгахад байлцах эсхүл төлөөлөгчөө байлцуулах хүсэлтийг хүлээн авна. Онцгой нөхцөл байдлаас бусад тохиолдолд тэдгээр хүсэлтийг хүлээн зөвшөөрнө.

3.37 Стандарт

Хэрэв гаалийн байгууллага шаардлагатай гэж үзвэл бараанд хийх шалгалтыг хөнгөвчлөх шаардлагатай аливаа туслалцааг авах зорилгоор мэдүүлэгчийг байлцуулах эсхүл төлөөлөгчөө оролцуулахыг шаардаж болно.

(c) Гаалийн байгууллага дээж авах

3.38 Стандарт

Гаалийн байгууллага шаардлагатай гэж үзвэл мэдүүлсэн барааны тариф эсхүл үнийг тодорхойлох болон үндэсний хууль тогтоомжийн бусад заалтуудын хэрэгжилтийг хангах зорилгоор дээж авч болно. Дээжийг аль болох бага хэмжээгээр авна.

**Алдаа**

3.39 Стандарт

Хэрэв алдаа нь санамсаргүй хийгдсэн, зөрчил гаргах зорилгогүй болох нь тогтоогдсон бол гаалийн байгууллага их хэмжээний шийтгэл ногдуулахгүй. Хэрэв тэдгээр алдааг дахин гаргуулахгүй байх үүднээс арга хэмжээ авах шаардлагатай гэж үзвэл шийтгэл ногдуулахдаа энэхүү зорилгод тохирсон хэмжээнээс илүүгүй байна.

**Бараагаа олгох**

3.40 Стандарт

Гаалийн байгууллага нь мэдүүлсэн бараагаа шалгасны дараа эсхүл шалгах шаардлагагүй гэж үзсэн бол дараахь нөхцлүүд бүрдсэн тохиолдолд бараагаа олгоно. Үүнд:

- ямар нэг зөрчил илрээгүй,
- импортын эсхүл экспортын лиценз болон бусад шаардлагатай бичиг баримтыг бүрэн бүрдүүлсэн,
- горимтой холбоотой холбогдох бүх зөвшөөрлийг авсан, болон
- гаалийн болон бусад бүх татвар төлөгдсөн эсхүл татвар төлөх талаар ямар нэгэн арга хэмжээг авсан.

3.41 Стандарт

Хэрэв мэдүүлэгч нь барааны гол мэдээллүүд бүхий худалдааны эсхүл албан ёсны бичиг баримтыг өгсөн бөгөөд тэдгээрийг гаалийн байгууллага хүлээн зөвшөөрсөн, мөн аливаа хамаарах гаалийн болон бусад татварыг барагдуулах баталгаа гаргасан нь бараагаа олгосны дараа гаалийн бүрдүүлэлтийг нөхөж бүрэн хийхэд хангалттай гэж үзвэл гаалийн байгууллага бараагаа олгоно.

3.42 Стандарт

Хэрэв гаалийн байгууллага дээжинд лабораторийн шинжилгээ хийх, тодорхой заасан техникийн бичиг баримт буюу мэргэжилтний зөвлөлгөө шаардлагатай гэж шийдвэр гаргасан бол тэдгээр шинжилгээний хариу гарахаас өмнө, шаардлагатай баталгаа гаргасан болон тэдгээр бараа нь хориглосон эсхүл хязгаарласан бараанд хамаарахгүй бол гаалийн байгууллага бараагаа олгож болно.

3.43 Стандарт

Зөрчил илэрсэн тохиолдолд гаалийн байгууллага нь захиргааны болон хуулийн дагуу арга хэмжээг авахыг хүлээхгүйгээр уг бараагаа хураах шаардлагагүй эсхүл дараагийн шатанд эд мөрийн баримт болохгүй бөгөөд мэдүүлэгч гаалийн болон бусад татвар төлсөн, мөн нэмэлт гаалийн болон

бусад татвар, торгууль төлөх баталгаа гаргасан бол барааг олгоно.

**Барааг хүлээн авахаас татгалзах буюу барааг устгах**

3.44 Стандарт

Барааг бүрмөсөн оруулахаар олгоогүй эсхүл гаалийн бусад горимоор орсон бөгөөд зөрчил илрээгүй бол холбогдох этгээд нь дараахь нөхцлүүдэд гаалийн болон бусад татварыг төлөхгүй байх эсхүл нөхөн төлбөр авах эрхтэй байна. Үүнд:

- түүний хүсэлтээр гаалийн хяналтын дор тэдгээр бараа улсын орлого болгох буюу устгах эсхүл арилжааны үнэгүй болгохоор гаалийн байгууллага шийдвэр гаргаж болно. Үүнтэй холбогдон гарах бүх зардлыг холбогдох этгээд төлнө;
- тэдгээр бараа нь устгагдсан эсхүл давагдашгүй хүчин зүйлийн улмаас эсхүл ослоос болж нөхөгдөшгүй эвдэрсэн бөгөөд тэдгээр эвдрэл буюу алдагдлыг гаалийн байгууллага хүлээн зөвшөөрсөн;
- барааны шинж чанарын алдагдал, хэрэв тийм алдагдал нь гаалийн байгууллагын шаардлагаар зохих ёсоор тогтоогдсон бол.

Хэрэв эвдрэлийн дараахь хаягдал болон үлдэгдэлийг бүрмөсөн оруулах эсхүл экспортлох бол тэдгээрийг тухайн улсад хаягдал бараа экспортлох эсхүл импортлоход ногдуулах гаалийн болон бусад татварт хамааруулна.

3.45 Шилжилтийн стандарт

Зөвшөөрсөн хугацаанд мэдүүлээгүй, зөрчил илрээгүй боловч олгох боломжгүй тохиолдолд гаалийн байгууллага барааг худалдсан бол худалдсанаас орсон орлогоос бүх татвар, хураамж, гарсан зардлыг хасч барааг хариуцах эрх бүхий этгээдэд олгох, эсхүл олгох боломжгүй бол тодорхой хугацаанд уг этгээдийн нэр дээр хадгална.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ
## ГААЛИЙН БОЛОН БУСАД ТАТВАР

### А. ГААЛИЙН БОЛОН БУСАД ТАТВАРЫГ ТООЦОХ, ХУРААН АВАХ БОЛОН ТӨЛӨХ

4.1 Стандарт

Үндэсний хууль тогтоомжид гаалийн болон бусад татвар төлөх нөхцлийг тодорхойлсон байна.

4.2 Стандарт

Гаалийн болон бусад татвар тооцох хугацааг үндэсний хууль тогтоомжид заасан байна. Барааны мэдүүлгийг хүлээн авсны дараа эсхүл татвар төлөх үүрэгтэй бол аль болох богино хугацаанд татварыг тооцно.

4.3 Стандарт

Үндэсний хууль тогтоомжид гаалийн болон бусад татварыг тооцох хүчин зүйлүүд болон тэдгээрийг тодорхойлох нөхцлүүдийг заасан байна.

4.4 Стандарт

Гаалийн болон бусад татварын хувь хэмжээг албан ёсны хэвлэлд гаргана.

4.5 Стандарт

Үндэсний хууль тогтоомжид гаалийн болон бусад татварын хувь хэмжээг тодорхойлох хугацааг заасан байна.

4.6 Стандарт

Үндэсний хууль тогтоомжид гаалийн болон бусад татварыг төлөхөд хэрэглэх аргыг заасан байна.

4.7 Стандарт

Үндэсний хууль тогтоомжид гаалийн болон бусад татвар төлөх этгээдийг заасан байна.

4.8 Стандарт

Үндэсний хууль тогтоомжид татварын төлбөрийг хийх тогтоосон өдөр болон төлбөр хийх газрыг тодорхойлсон байна.

4.9 Стандарт

Үндэсний хууль тогтоомжид тогтоосон өдрийг барааг олгосны дараа зааж болох ба энэ өдөр нь барааг олгосноос хойш доод тал нь 10 өдөр байна. Барааг олгосон өдөр болон тогтоосон өдрийн хоорондох хугацаанд хүү тооцохгүй.

4.10 Стандарт

Үндэсний хууль тогтоомжид тогтоосон хугацаанд төлөөгүй татварыг барагдуулах талаар гаалийн байгууллагаас хуулийн дагуу авах арга хэмжээний хугацааг заасан байна.

4.11 Стандарт

Үндэсний хууль тогтоомжид тогтоосон хугацаанд төлөөгүй гаалийн болон бусад татварт ногдуулах хүүгийн хувь хэмжээ болон тэдгээрийн хүүг бодох нөхцлийг тодорхойлсон байна.

4.12 Стандарт

Гаалийн болон бусад татварыг төлсөн тохиолдолд татвар төлснийг нотлох өөр төрлийн баримт байхгүй бол татвар төлснийг нотлох тасалбарыг татвар төлөгчид олгоно.

4.13 Шилжилтийн стандарт

Үндэсний хууль тогтоомжид гаалийн болон бусад татвар тооцохгүй байх гаалийн болон бусад татварын хамгийн бага хэмжээ эсхүл үнийг заасан байна.

4.14 Стандарт

Хэрэв гаалийн байгууллага барааны мэдүүлэгт эсхүл гаалийн болон бусад татвар тооцоход алдаа гаргасныг илрүүлсэн, уг алдаа нь хуулийн дагуу ногдуулах татварын хэмжээнээс доогуур, гаалийн болон бусад татварыг хураан авахад нөлөөлсөн эсхүл нөлөөлж болзошгүй бол гаалийн байгууллага тэрхүү алдааг засч дутуу төлөгдсөн татварыг хураан авна. Гэвч хураан авсан татварын хэмжээ нь үндэсний хууль тогтоомжид заасан хамгийн бага хэмжээнээс доогуур бол гаалийн байгууллага тэрхүү татварыг хураах эсхүл дахин төлүүлэхгүй.

### В. ГААЛИЙН БОЛОН БУСАД ТАТВАРЫН ТӨЛБӨРИЙГ ХОЙШЛУУЛАХ

4.15 Стандарт

Үндэсний хууль тогтоомжид гаалийн болон бусад татварын төлбөрийг хойшлуулах тухай заасан бол тэдгээр татварыг хойшлуулах нөхцлийг заасан байна.

4.16 Стандарт

Төлбөрийг хойшлуулахдаа аль болох хүү тооцохгүй байна.

4.17 Стандарт

Гаалийн болон бусад татварын төлбөрийг хойшлуулах хугацаа нь доод тал нь 14 хоног байна.

**C. ГААЛИЙН БОЛОН БУСАД ТАТВАРЫГ БУЦААН ОЛГОХ**

4.18 Стандарт

Гаалийн болон бусад татварыг буруу тооцсоноос татварыг илүү авсан тохиолдолд татварыг буцаан олгоно.

4.19 Стандарт

Барааг импортлох эсхүл экспортлох үед гэмтсэн эсхүл гэрээний нөхцөлтэй тохирохгүйн улмаас уг барааг илгээгчид эсхүл илгээгчийн томилсон этгээдэд буцаасан бөгөөд дараахь нөхцлүүдийг хангаж байвал татварыг буцаан олгоно. Үүнд:

- бараа нь импортлогч улсад ашиглагдаагүй, үйлдвэрлэгдээгүй эсхүл засвар хийгдээгүй, зохих хугацаанд буцаан экспортлогдсон,
- бараа нь экспортлогдож байгаа улсад ашиглагдаагүй, үйлдвэрлэгдээгүй эсхүл засвар хийгдээгүй, зохих хугацаанд буцаан импортлогдсон.

Барааг хэрэглэсэн байдал нь барааны гэмтлийг тогтооход эсхүл барааг буцаан импортлох эсхүл буцаан экспортлох бусад нөхцлүүд нь татвар буцаан олгоход саад болохгүй.

Барааг буцаан импортлох эсхүл буцаан экспортлох боломжгүй бол гаалийн хяналтын дор улсын орлого болгох буюу устгах эсхүл арилжааны үнэгүй болгохыг гаалийн байгууллагын шийдвэрлэж болно. Улсын орлогод оруулах буюу устгахад гарах зардлыг улсын төсвөөс гаргахгүй.

4.20 Шилжилтийн стандарт

Гаалийн болон бусад татвар төлөх горимоор анх мэдүүлсэн барааг гаалийн байгууллагаас өгсөн зөвшөөрлийн дагуу гаалийн өөр горимд шилжүүлэхэд шинэ горимд ногдох татвараас илүү гарсан татварыг буцаан олгоно.

4.21 Стандарт

Буцаан олгох нэхэмжлэлийн талаарх шийдвэрийг хугацаа хойшлуулахгүйгээр холбогдох этгээдэд бичгээр мэдэгдэх бөгөөд нэхэмжлэлийг баталгаажуулсны дараа аль болох богино хугацаанд илүү тооцсон хэмжээг буцаан олгоно.

4.22 Стандарт

Гаалийн байгууллагаас гаалийн болон бусад татварыг тооцохдоо гаалийн байгууллагын хэсэгт алдаа гарган илүү тооцсон бол тэрхүү илүү тооцсон татварыг нэн тэргүүнд буцаан олгоно.

4.23 Стандарт

Татвар буцаан олгох нэхэмжлэлийг хүлээн авахгүй байх хугацааг тогтоохдоо нөхөн төлбөр авах тохиолдол тус бүрт холбогдох нөхцөл байдлыг харгалзан хангалттайгаар тогтооно.

4.24 Стандарт

Хэрэв хамаарах хэмжээ нь үндэсний хууль тогтоомжид заасан хамгийн бага хэмжээнээс доогуур байгаа тохиолдолд татварыг буцаан олгохгүй.

**ТАВДУГААР БҮЛЭГ**
**БАТАЛГАА**

5.1 Стандарт

Үндэсний хууль тогтоомжид баталгаа шаардах нөхцлүүдийн жагсаалтыг болон баталгаа гаргах хэлбэрийг заасан байна.

5.2 Стандарт

Гаалийн байгууллага баталгааны хэмжээг тодорхойлно.

5.3 Стандарт

Баталгаа гаргах этгээд нь гаалийн байгууллагаас хүлээн зөвшөөрсөн баталгааны аль ч хэлбэрийг сонгож болно.

5.4 Стандарт

Үндэсний хууль тогтоомжид заасназр гаалийн байгууллагын өмнө хүлээх үүргийг бүрэн биелүүлсэн бол гаалийн байгууллага баталгаа шаардахгүй.

5.5 Стандарт

Гаалийн байгууллагаас гаалийн горимын дагуу хүлээх үүргийг бүрэн хангуулах үүднээс баталгаа шаардах бол ерөнхий баталгаа гаргахыг хүлээн зөвшөөрөх бөгөөд ялангуяа гаалийн нутаг дэвсгэрт өөр өөр гаалийн газарт барааг тогтмол мэдүүлдэг мэдүүлэгчид уг баталгааг гаргахыг зөвшөөрнө.

5.6 Стандарт

Баталгаа шаардах тохиолдолд баталгааны хэмжээ нь аль болох бага байх бөгөөд төлбөл зохих гаалийн болон бусад татварын хэмжээнээс хэтрэхгүй байна.

5.7 Стандарт

Гаалийн байгууллагаас баталгаа шаардсан үүргийг бүрэн биелүүлсэн гэж үзвэл уг баталгааг нэн даруй буцаан олгоно.

**ЗУРГАДУГААР БҮЛЭГ**
**ГААЛИЙН ХЯНАЛТ**

6.1 Стандарт

Гаалийн нутаг дэвсгэрт орж байгаа эсхүл гаалийн нутаг дэвсгэрээс гарч байгаа бүх бараа, тээврийн хэрэгслийг гаалийн болон бусад татварт хамаарах эсэхийг харгалзахгүйгээр гаалийн хяналтанд хамруулна.

6.2 Стандарт

Гаалийн хяналтыг гаалийн хуулийн хэрэгжилтийг хангахад шаардлагатай хэмжээнд хязгаарлана.

6.3 Стандарт

Гаалийн байгууллага нь гаалийн хяналтыг явуулахдаа эрсдлийг тооцох аргыг хэрэглэнэ.

6.4 Стандарт

Гаалийн байгууллага нь эрсдлийг тооцох, дүн шинжилгээг ашиглаж ямар этгээд, ямар барааг болон ямар тээврийн хэрэгслийг шалгалтад хамруулах, шалгалтыг ямар хэмжээнд хийхийг тодорхойлно.

6.5 Стандарт

Гаалийн байгууллага нь эрсдлийн менежментийг дэмжих зорилгоор хуулийн хэрэгжилтийг тогтоох стратегийг авч хэрэгжүүлнэ.

6.6 Стандарт

Гаалийн хяналтын системд аудитад суурилсан хяналт багтана.

6.7 Стандарт

Гаалийн байгууллага нь бусад гаалийн байгууллагатай хамтран ажиллах бөгөөд гаалийн хяналтыг сайжруулах зорилгоор захиргааны талаар харилцан туслах тухай хэлэлцээрийг байгуулахыг эрмэлзэнэ.

6.8 Стандарт

Гаалийн байгууллага нь худалдааны байгууллагатай хамтран ажиллах бөгөөд гаалийн хяналтыг сайжруулах зорилгоор Харилцан Ойлголцох Санамж Бичгийг байгуулахыг эрмэлзэнэ.

6.9 Стандарт

Гаалийн байгууллага нь гаалийн хяналтыг сайжруулах зорилгоор мэдээллийн технологи, электрон худалдааг аль болох боломжтой хэмжээнд ашиглана.

6.10 Стандарт

Худалдаа эрхлэгчдийн арилжааны үйл ажиллагааны тогтолцоо нь гаалийн үйл ажиллагаанд нөлөөлөхөөр бол гаалийн байгууллага өөрийн тавьсан шаардлагыг хангуулах үүднээс уг тогтолцоонд үнэлэлт дүгнэлт өгнө.

**ДОЛДУГААР БҮЛЭГ**

**МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙГ АШИГЛАХ**

7.1 Стандарт

Мэдээллийн технологи нь гаалийн байгууллага болон худалдаа эрхлэгчдийн хувьд зардал хэмнэсэн, үр дүнтэй бол гаалийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор мэдээллийн технологийг ашиглана. Гаалийн байгууллага нь мэдээллийн технологийг ашиглах нөхцлийг заасан байна.

7.2 Стандарт

Гаалийн байгууллага нь компьютерийн программыг нэвтрүүлэхдээ холбогдох олон улсын стандартыг хэрэглэнэ.

7.3 Стандарт

Мэдээллийн технологийг нэвтрүүлэхдээ шууд харилцах бүх холбогдох талуудтай аль болох боломжийн хэмжээнд зөвлөлдөнө.

7.4 Стандарт

Шинээр гарсан эсхүл шинэчилсэн үндэсний хууль тогтоомжид дараахь нөхцлүүдийг заана:

- цаасанд суурилсан бичиг баримтын шаардлагыг орлох электрон худалдааны арга,
- электрон болон цаасанд суурилсан баталгаажуулалтын арга,
- гаалийн байгууллага мэдээллийг өөрийн хэрэгцээнд ашиглах, боломжтой бол тэдгээр мэдээллийг бусад гаалийн байгууллагуудад болон хууль ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн талуудад электрон худалдааны аргаар дамжуулах эрх.

**НАЙМДУГААР БҮЛЭГ**

**ГААЛИЙН БАЙГУУЛЛАГА БОЛОН ГУРАВДАГЧ ЭТГЭЭД ХООРОНДЫН ХАРИЛЦАА**

8.1 Стандарт

Холбогдох этгээд нь гаалийн байгууллагатай өөрөө шууд харилцах эсхүл өөрийн нэрийн өмнөөс гуравдагч этгээдээр дамжуулан харилцах эсэхийг сонгож болно.

8.2 Стандарт

Бусад этгээдийн өмнөөс гаалийн байгууллагатай харилцах гуравдагч этгээдийн нөхцлийг үндэсний хууль тогтоомжид заасан байх бөгөөд гаалийн болон бусад татварыг барагдуулах болон явцын дунд гарах аливаа хариуцлагын талаар хүлээх үүргийг заасан байна.

8.3 Стандарт

Холбогдох этгээд өөрөө гаалийн бүрдүүлэлт хийх тохиолдолд гаалийн байгууллага нь гуравдагч этгээдээр дамжуулан гаалийн бүрдүүлэлт хийхэд тавих шаардлагаас илүү хатуу шаардлага тавих, тааламжтай бус хандахгүй байна.

8.4 Стандарт

Гуравдагч этгээдээр итгэмжлэгдсэн этгээд нь түүнийг өөрийн нэрийн өмнөөс гаалийн бүрдүүлэлт хийхээр итгэмжилсэн этгээдийн эдлэх эрхийг мөн адил эдэлнэ.

8.5 Стандарт

Гаалийн байгууллага нь гуравдагч этгээдийг худалдааны талаарх өөрийн албан ёсны зөвлөлгөөнд оролцуулна.

8.6 Стандарт

Гаалийн байгууллага нь гуравдагч этгээдтэй гаалийн бүрдүүлэлт хийхгүй байх нөхцлийг заасан байна.

8.7 Стандарт

Гаалийн байгууллага нь гаалийн бүрдүүлэлт хийхгүй байх шийдвэрээ гуравдагч этгээдэд бичгээр өгнө.

**ЕСДҮГЭЭР БҮЛЭГ**

**ГААЛИЙН БАЙГУУЛЛАГААС ГАРГАХ МЭДЭЭЛЭЛ, ШИЙДВЭР БОЛОН ЖУРАМ**

**А. НИЙТЛЭГ ХЭРЭГЦЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ**

9.1 Стандарт

Гаалийн хуультай холбоотой ерөнхий мэдээллийг сонирхсон этгээд авах боломжтой байх нөхцлийг гаалийн байгууллага бүрдүүлсэн байна.

9.2 Стандарт

Гаалийн хуульд орсон нэмэлт өөрчлөлтүүд болон захиргааны арга хэмжээ эсхүл шаардлагуудад хийсэн өөрчлөлтүүдийн талаар нийтэд ил тод болгосон мэдээлэлд нэмэлт өөрчлөлт хийх бөгөөд тэдгээр шинэчилсэн мэдээллийг хүчин төгөлдөр болохоос өмнө урьдчилж гаргах хэрэв боломжгүй бол тэдгээрийг сонирхсон этгээд өөрийн үйл ажиллагаанд хэрэглэх боломжтой байх хугацаанд гаргана.

9.3 Стандарт

Гаалийн байгууллага мэдээллийн нөхцөлийг сайжруулах зорилгоор мэдээллийн технологийг ашиглана.

**В.ТУСГАЙ ШИНЖ БҮХИЙ МЭДЭЭЛЭЛ**

9.4 Стандарт

Сонирхсон этгээдийн хүсэлтээр, гаалийн байгууллага нь гаалийн хуулийн дагуу тусгай зориулалттай мэдээг аль болох хурдан хугацаанд, үнэн зөв, боломжийн хэмжээнд гаргаж өгнө.

9.5 Стандарт

Гаалийн байгууллага нь зөвхөн тусгайлан хүссэн мэдээллээс гадна бусад сонирхсон этгээдтэй холбогдолтой мэдээллийг гаргаж өгнө.

9.6 Стандарт

Гаалийн байгууллага нь мэдээллээр хангахдаа үндэсний хууль тогтоомжоор ил тод болгохыг шаардсан буюу зөвшөөрсөнөөс бусад тохиолдолд гаалийн байгууллага эсхүл гуравдагч этгээдтэй холбоотой хувийн эсхүл нууц бүхий мэдээллийг ил тод зарлахгүй.

9.7 Стандарт

Хэрэв гаалийн байгууллага мэдээллийг үнэ төлбөргүйгээр хангах боломжгүй бол төлбөр нь үзүүлсэн үйлчилгээний зохих зардлаар хязгаарлагдсан байна.

C. ШИЙДВЭР БОЛОН ЖУРАМ

9.8 Стандарт

Гаалийн байгууллага нь холбогдох этгээдийн бичгээр гаргасан хүсэлтийн талаарх өөрийн шийдвэрийг үндэсний хууль тогтоомжид заасан хугацаанд багтаан бичгээр мэдэгдэнэ. Хэрэв татгалзсан шийдвэр гаргасан бол холбогдох этгээдэд татгалзсан шалтгааныг болон давж заалдах эрхийг мэдэгдэнэ.

9.9 Стандарт

Гаалийн байгууллагад шаардлагатай гэж үзсэн бүх мэдээлэл байгаа бол сонирхсон этгээдийн хүсэлтээр гаалийн байгууллагаас заавал дагаж мөрдөх шийдвэрийг гаргана.

АРАВДУГААР БҮЛЭГ

ГААЛИЙН АСУУДЛААР ДАВЖ ЗААЛДАХ

A. ДАВЖ ЗААЛДАХ ЭРХ

10.1 Стандарт

Үндэсний хууль тогтоомжоор гаалийн асуудлаар давж заалдах эрхийг олгоно.

10.2 Стандарт

Гаалийн байгууллагын шийдвэр эсхүл эс үйлдэл нь ямар нэгэн этгээдэд шууд нөлөөлсөн бол тэрхүү этгээд нь давж заалдах эрхтэй.

10.3 Стандарт

Гаалийн байгууллагын шийдвэр эсхүл эс үйлдэл нь шууд нөлөөлсөн этгээд гаалийн байгууллагад хүсэлт гаргасны дараа гаалийн байгууллага өөрийн гаргасан шийдвэр эсхүл эс үйлдлийн шалтгааныг үндэсний хууль тогтоомжид заасан хугацаанд гаргаж өгнө. Энэ нь давж заалдахад нөлөөлөх эсхүл нөлөөлөхгүй байж болно.

10.4 Стандарт

Үндэсний хууль тогтоомжид гаалийн байгууллагад эхэлж давж заалдах эрхийг заасан байна.

10.5 Стандарт

Хэрэв гаалийн байгууллагад давж заалдсан нь хэрэгсэхгүй болсон тохиолдолд давж заалдагч этгээд дараагийн шатанд гаалийн байгууллагаас бусад хөндлөнгийн байгууллагад давж заалдах эрхтэй байна.

10.6 Стандарт

Давж заалдсан этгээд нь сүүлийн шатанд шүүхэд давж заалдах эрхтэй байна.

B. ДАВЖ ЗААЛДАХ ҮНДЭСЛЭЛ БОЛОН ХЭЛБЭР

10.7 Стандарт

Давж заалдах тухай гомдлыг бичгээр гаргах бөгөөд давж заалдах үндэслэлийг гаргасан байна.

10.8 Стандарт

Гаалийн байгууллагын шийдвэрийг давж заалдах хугацааг тогтоох ба энэ нь давж заалдагч этгээдэд шийдвэрийг эсэргүүцэх талаар судлах, давж заалдахад бэлтгэх хангалттай хугацаа олгосон байна.

10.9 Стандарт

Гаалийн байгууллагад давж заалдах гомдол гаргасан үед зарчмын хувьд аливаа нотолгоог давж заалдах гомдлын хамт шаардахгүй боловч тэдгээр нотолгоог гаргах боломжтой хугацаа олгоно.

C. ДАВЖ ЗААЛДСАН АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ

10.10 Стандарт

Гаалийн байгууллага нь давж заалдсан гомдлын талаар шийдвэрээ гаргах бөгөөд шийдвэрээ давж заалдагч этгээдэд нэн даруй бичгээр мэдэгдэнэ.

10.11 Стандарт

Гаалийн байгууллага нь давж заалдсаныг хэрэгсэхгүй болгосон бол тийм үндэслэлийг давж заалдагч этгээдэд бичгээр мэдэгдэх бөгөөд тухайн шийдвэрийг захиргааны эсхүл хөндлөнгийн байгууллагад цаашид давж заалдах эрх болон уг давж заалдах гомдлыг гаргах хугацааны талаар зөвлөнө.

10.12 Стандарт

Хөндлөнгийн эсхүл шүүхийн байгууллагаас гаргасан давж заалдсан гомдлыг хүлээн зөвшөөрсөн шийдвэрийг гаалийн байгууллага давж заалдахгүй бол нэн даруй хэрэгжүүлнэ.

ТУСГАЙ ХАВСРАЛТУУД

**1. Хавсралт A – Бараа гаалийн нутаг дэвсгэрт орж ирэх**

I бүлэг. Барааг гаальд мэдүүлэхээс өмнөх ажиллагаа

II бүлэг. Барааг түр хадгалах

**2. Хавсралт B – Импорт**

I бүлэг. Дотоодын хэрэглээнд зориулан бүрдүүлэлт хийх

II бүлэг. Барааг өөрчлөлт оруулалгүй буцаан оруулах

III бүлэг. Импортын гаалийн болон бусад татвараас чөлөөлөх

**3. Хавсралт C – Экспорт**

I бүлэг. Бүрмөсөн гаргах

**4. Хавсралт D – Гаалийн агуулах болон чөлөөт бүс**

I бүлэг. Гаалийн агуулах

II бүлэг. Чөлөөт бүс

5. **Хавсралт E – Дамжин өнгөрөх**

I бүлэг. Гаалийн хилээр дамжин өнгөрөх

II бүлэг. Шилжүүлэн ачих

III бүлэг. Барааг эргийн дагуу тээвэрлэх

6. **Хавсралт F – Бараанд боловсруулалт хийх**

I бүлэг. Дотоодод боловсруулах

II бүлэг. Гадаадад боловсруулах

III бүлэг. Татвар буцаан олгох

IV бүлэг. Барааг дотоодын хэрэглээнд зориулан боловсруулах

7. **Хавсралт G – Түр хугацаагаар оруулах**

I бүлэг. Түр хугацаагаар оруулах

8. **Хавсралт H – Зөрчил**

I бүлэг. Гаалийн зөрчил

9. **Хавсралт J – Тусгай горимууд**

I бүлэг. Зорчигч

II бүлэг. Шуудан

III бүлэг. Арилжааны зориулалтын тээврийн хэрэгсэл

IV бүлэг. Татваргүй бараа

V бүлэг. Тусламжийн бараа

10. **Хавсралт K – Гарал үүсэл**

I бүлэг. Гарал үүслийн дүрэм

II бүлэг. Гарал үүслийг баримтаар нотлох

III бүлэг. Гарал үүслийн нотлох баримтыг шалгах

**ТУСГАЙ ХАВСРАЛТ А**
**ГААЛИЙН НУТАГ ДЭВСГЭРТ БАРАА ОРЖ ИРЭХ**

**1 дүгээр бүлэг**
**БАРААГ ГААЛЬД МЭДҮҮЛЭХЭЭС ӨМНӨХ АЖИЛЛАГАА**

**Хүчин төгөлдөр болсон:**

**Тодорхойлолт**

Энэхүү бүлгийн зорилгоор:

E1./F1.

**"ачааны мэдүүлэг"** гэдэгт гаалийн нутаг дэвсгэрт оруулсан, гаргасан ачаанд холбогдох гаальд шаардагдах мэдээлэл бүхий арилжааны зориулалттай тээврийн хэрэгслийг ирэх буюу явахаас өмнө эсхүл ирэх, явах үед өгөх мэдээллийг;

E2./F3.

**"тээвэрлэгч"** гэдэгт барааг тээвэрлэж байгаа буюу тээврийн хэрэгслийн үйл ажиллагааг хариуцаж байгаа этгээдийг;

E3./F2.

**"Барааг гаальд мэдүүлэхээс өмнөх ажиллагаа"** гэдэгт бараа гаалийн нутаг дэвсгэрт орж ирсэн цагаас уг бараа гаалийн бүрдүүлэлтийн горим сонгох хүртэлх холбогдох этгээд болон гаалийн явуулж байгаа бүх ажиллагааг тус тус ойлгоно.

**Зарчим**

**1. Стандарт**

Барааг гаальд мэдүүлэхээс өмнөх гаалийн ажиллагааг энэ бүлгийн заалт болон тохиромжтой бол Ерөнхий хавсралтын заалтаар зохицуулна.

**2. Практик зөвлөмж**

Барааг гаальд мэдүүлэхээс өмнөх гаалийн ажиллагааг барааны гарал үүслийн улс буюу барааны ирсэн орноос үл хамааран бараанд адил тэгш хэрэглэнэ.

**Барааг гаалийн нутаг дэвсгэрт оруулах**

(а) Барааг гаалийн нутаг дэвсгэрт оруулж болох газрууд

**3. Стандарт**

Барааг гаалийн нутаг дэвсгэрт оруулж болох газрыг үндэсний хууль тогтоомжоор тодорхойлно. Зөвхөн хяналтын зорилгоор шаардлагатай гэж үзэх тохиолдолд барааг шууд холбогдох гаалийн газар буюу гаалийн бусад газарт хүргэхдээ явах замыг гааль тогтооно. Эдгээр газар болон замыг тогтоохдоо худалдааны тодорхой хэрэгцээг хангах ёстой хүчин зүйлийг анхааралдаа авна.

Энэ стандартыг тухайн гаалийн нутаг дэвсгэрт байгаа далайн боомт, нисэх онгоцны буудал, гаалийн нутаг дэвсгэрээр дамжин гарахдаа зогсохгүй усан онгоцны тавцан буюу буухгүй гарах агаарын хөлгийн бүхээгт байгаа бараанд хэрэглэхгүй.

(b) Тээвэрлэгчийн үүрэг

**4. Стандарт**

Тээвэрлэгч нь бүх барааг ачааны мэдүүлэгт тусгасан буюу өөр зөвшөөрөгдсөн байдлаар гаальд мэдэгдэх явдлыг хангахад гаалийн өмнө хариуцлага хүлээнэ.

**5. Стандарт**

Барааг гаалийн нутаг дэвсгэрт оруулснаар тээвэрлэгчид барааг шаардлагатай тохиолдолд тогтоосон замаар явуулан, холбогдох гаалийн газар, эсхүл гаалийн тогтоосон бусад газарт хугацаа алдалгүйгээр хүргэх үүрэг ногдоно. Ингэх явцад барааны шинж чанар, түүний савлалт, баглаа боодол болон түүнд тавьсан лац, ломбонд өөрчлөлт оруулахгүй.

Энэ стандартыг гаалийн нутаг дэвсгэрт байгаа далайн боомт, нисэх онгоцны буудал, гаалийн нутаг дэвсгэрээр дамжин гарахдаа зогсохгүй усан онгоцны тавцан буюу буухгүй гарах агаарын хөлгийн бүхээгт байгаа бараанд хэрэглэхгүй.

**6. Стандарт**

Барааг гаалийн нутаг дэвсгэрт оруулсан газраас холбогдох гаалийн газар, бусад тогтоосон газарт зөөн тээвэрлэх ажиллагаа нь осол аваар буюу давагдашгүй хүчин зүйлийн улмаас тасалдсан бол тээвэрлэгч барааг зөвшөөрөгдөөгүй эргэлтэд орохоос урьдчилан сэргийлэхэд шаардлагатай арга хэмжээг авах ёстой бөгөөд гаалийн болон эрх бүхий бусад байгууллагад осол аваарын шинж чанар буюу аяллыг тасалдахад хүргэсэн бусад нөхцөл байдлын талаар мэдэгдэнэ.

**Барааг гаальд шалгуулах**

(а) Бичиг баримт

**7. Практик зөвлөмж**

Барааг шалгах ёстой гаалийн газар нь барааг гаалийн нутаг дэвсгэрт нэвтрүүлсэн газарт байрлаагүй бол гагцхүү хяналтын зорилгоор

шаардлагатай гэж гааль үзвэл тэр газрын гаальд бичиг баримтыг үзүүлэх шаардлагатай.

**8. Стандарт**

Барааг гаальд шалгуулах үүднээс бичиг баримт шаардагдвал гааль бараа, тээврийн хэрэгслийг ялгаж танихад шаардагдах мэдээллээс илүү мэдээллийг уг бичиг баримтад байхыг шаардахгүй.

**9. Практик зөвлөмж**

Гааль мэдээллийн шаардлагыг тээвэрлэгчийн жирийн бичиг баримтад байгаа мэдээллээр хязгаарлаж, эдгээр шаардлага нь олон улсын тээврийн холбогдох хэлэлцээрээр тогтоосон шаардлагад үндэслэнэ.

**10. Практик зөвлөмж**

Барааг шалгуулахад зөвхөн ачааны мэдүүлгийг шаардагдах бичиг баримт гэж гааль хүлээн авна.

**11. Практик зөвлөмж**

Барааг шалгахад шаардлагатай бичиг баримтыг хүлээн авч байгаа гаалийн газар мөн барааны мэдүүлгийг хүлээн авах эрхтэй байна.

**12. Практик зөвлөмж**

Гаальд шалгуулж байгаа бичиг баримт нь тухайн зорилгоор тогтоогдоогүй, эсхүл барааг оруулсан улсын бус хэлээр байвал эдгээр бичиг баримтад байгаа зүйлсийг заавал орчуулахыг шаардах ёсгүй.

(b) Ажлын бус цагаар ирэх

**13. Стандарт**

Ажлын бус цагаар гаалийн газарт ирсэн бараа гаалийн нутаг дэвсгэрт зөвшөөрөгдөөгүй эргэлтэд орохоос сэргийлэх зорилгоор гааль тээвэрлэгчид анхааруулга өгнө.

**14. Практик зөвлөмж**

Тээвэрлэгчийн хүсэлтээр болон гаалийн шаардлагатай гэж үзэх шалтгаанаар гаалийн тогтоосон ажлын бус цагт барааг гаальд мэдүүлэхээс өмнөх үйл ажиллагаа явуулахыг гааль боломжийн хирээр зөвшөөрнө.

**Барааг буулгах**

(a) Буулгах газар

**15. Стандарт**

Буулгах зөвшөөрөл бүхий газрыг үндэсний хууль тогтоомжоор тогтооно.

**16. Практик зөвлөмж**

Холбогдох этгээдийн хүсэлтээр болон гаалийн шаардлагатай гэж үзэх шалтгаанаар буулгах зөвшөөрөл бүхий газраас өөр газарт барааг буулгахыг гааль зөвшөөрч болно.

(b) Буулгах ажлыг эхлэх

**17. Стандарт**

Буулгах газар тээврийн хэрэгсэл ирснээс хойш аль болох түргэн хугацаанд буулгаж эхлэхийг зөвшөөрнө.

**18. Практик зөвлөмж**

Холбогдох этгээдийн хүсэлтээр болон гааль шаардлагатай гэж үзэх шалтгаанаар гаалийн тогтоосон ажлын бус цагт буулгах ажлыг үргэлжлүүлэхийг боломжийн хирээр зөвшөөрнө.

**Төлбөр**

**19. Стандарт**

Дараахь үйл ажиллагаатай холбогдон гарах аливаа зардал нь үзүүлсэн үйлчилгээний ойролцоогоор тооцсон өртгөөс хэтрэхгүй байна:

- бараag гаальд мэдүүлэхээс өмнөх гаалийн ажиллагааг гаалийн тогтоосон ажлын бус цагт хийх;
- буулгах зөвшөөрөл бүхий газраас өөр газарт барааг буулгах; эсхүл
- гаалийн байгууллагын тогтоосон ажлын цагаас гадуур барааг буулгах.

**2 дугаар бүлэг**

**БАРААГ ТҮР ХАДГАЛАХ**

**Тодорхойлолт**

Энэхүү бүлгийн зорилгоор:

E1./F1.

**"ачааны мэдүүлэг"** гэдэгт гаалийн нутаг дэвсгэрт оруулсан, гаргасан ачаанд холбогдох гаальд шаардагдах мэдээлэл бүхий арилжааны зориулалттай тээврийн хэрэгслийг ирэх буюу явахаас өмнө эсхүл ирэх, явах үед өгөх мэдээллийг;

E2./F2.

**"барааг түр хадгалах"** гэдэгт барааг мэдүүлэхээс өмнө гаалийн зөвшөөрөл бүхий агуулах, хаалттай эсхүл хаалтгүй улс зайд гаалийн хяналтын дор барааг хадгалахыг тус тус ойлгоно.

**Зарчим**

**1. Стандарт**

Барааг түр хадгалах ажиллагаа энэ бүлгийн заалт болон тохиромжтой бол Ерөнхий хавсралтын заалтаар зохицуулна.

**2. Стандарт**

Худалдааны хэрэгцээг хангахад шаардлагатай гэж үзсэн үед түр агуулах байгуулахыг гааль зөвшөөрнө.

**3. Практик зөвлөмж**

Барааны чанар, гарал үүслийн улс болон барааны ирсэн орноосүл хамааран бүх барааг түр хадгалахыг зөвшөөрнө. Гэхдээ аюултай, бусад бараанд муугаар нөлөөлөх эсхүл тусгай тохиргоо шаардах бараag тэдгээрийг хүлээн авах эрх бүхий байгууллагаас тогтоосон, тусгайлан тоноглосон түр агуулахад оруулна.

**Бичиг баримт**

**4. Стандарт**

Барааг түр агуулахад байрлуулахад зөвхөн барааг гаальд шалгуулахад барааг тодорхойлохоор ашигласан бичиг баримтыг л шаардана.

**5. Практик зөвлөмж**

Ачааны мэдүүлэг, худалдааны өөр бичиг баримтад дурдсан бүх барааг түр агуулахад оруулсан тохиолдолд зөвхөн ачааны мэдүүлэг буюу худалдааны өөр бичиг баримтыг барааг түр агуулахад байрлуулахад шаардагдах бичиг баримт болгон гааль хүлээн авна.

**Түр агуулахыг удирдах**

**6. Стандарт**

Түр агуулахын барилга, хийц болон удирдлага, агуулахад барааг хадгалах дэг журам,

барааны жагсаалт, нягтлан бодох бүртгэл болон гаалийн хяналтын шаардлагыг гааль тодорхойлно.

**Зөвшөөрөгдсөн ажиллагаа**

**7. Стандарт**

Гааль шаардлагатай гэж үзсэн шалтгаанаар түр агуулахад байгаа барааг өөрчлөлгүй хадгалахад шаардлагатай хэвийн ажиллагаанд оруулж болно.

**8. Практик зөвлөмж**

Гааль шаардлагатай гэж үзсэн шалтгаанаар түр агуулахад байгаа барааг түр агуулахаас гарган цаашид тээвэрлэхэд хялбар болгоход шаардлагатай хэвийн ажиллагаанд оруулж болно.

**Түр хадгалах хугацаа**

**9. Стандарт**

Үндэсний хууль тогтоомжоор түр хадгалах хугацааг тодорхойлохдоо тухайн хугацаа нь барааг гаалийн өөр горимд оруулахад шаардагдах үйл ажиллагааг дуусгах боломжийг импортлогчид олгоход хангалттай байна.

**10. Практик зөвлөмж**

Холбогдох этгээдийн хүсэлтээр болон гааль шаардлагатай гэж үзсэн шалтгаанаар анхлан тогтоосон хугацааг гааль сунгана.

**Муудсан, гэмтсэн бараа**

**11. Практик зөвлөмж**

Осол аваар, давагдашгүй хүчин зүйлийн улмаас түр агуулахаас гарахаас өмнө муудсан, эвдэрсэн, гэмтсэн барааг муудсан, эвдэрсэн, гэмтсэнийг нь гааль зохих ёсоор тогтоож байвал барааг муудсан, эвдэрсэн, гэмтсэн байдлаар импортлосоны адил бүрдүүлэлт хийхийг зөвшөөрнө.

**Түр агуулахаас гаргах**

**12. Стандарт**

Барааг шилжүүлэх эрх бүхий этгээд нь түр агуулахаас гаргах тохиолдол бүрийн нөхцөл, үйл ажиллагаанд нийцүүлж гаргах эрхтэй байна.

**13. Стандарт**

Зөвшөөрөгдсөн хугацаанд түр агуулахаас бараагаа гаргаагүй тохиолдолд мөрдөх журмыг үндэсний хууль тогтоомжоор тогтооно.

## ТУСГАЙ ХАВСРАЛТ B

## 1 дүгээр бүлэг

## ДОТООДЫН ХЭРЭГЛЭЭНД ЗОРИУЛЖ БҮРДҮҮЛЭЛТ ХИЙХ

**Тодорхойлолт**

Энэхүү бүлгийн зорилгоор:

E1./F2.

**"Дотоодын хэрэглээнд зориулж бүрдүүлэлт хийх"** гэдэгт гаалийн бүрдүүлэлтийн холбогдох үйл ажиллагааг дуусгаж, импортын гаалийн болон бусад татварыг төлсний үндсэн дээр барааг гаалийн нутаг дэвсгэрт чөлөөт эргэлтэд оруулах гаалийн горимыг;

E2./F1.

**"Чөлөөт эргэлтэд байгаа бараа"** гэдэгт гаалийн зүгээс ямар нэг хязгаарлалтгүйгээр хэрэглэж болох барааг тус тус ойлгоно.

**Зарчим**

**1. Стандарт**

Дотоодын хэрэглээнд зориулж бүрдүүлэлт хийхийг энэ бүлгийн заалт болон тохиромжтой бол Ерөнхий хавсралтын заалтаар зохицуулна.

**Бичиг баримт**

**2. Практик зөвлөмж**

Дотоодын хэрэглээнд зориулж бүрдүүлэлт хийх барааг холбогдох шаардлагатай мэдээллийг заасан нөхцөлтэйгээр барааны стандарт мэдүүлгээс өөр байдлаар мэдүүлж болох талаар үндэсний хууль тогтоомжид заана.

## 2 дугаар бүлэг

## БАРААНД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАЛГҮЙГЭЭР БУЦААН ИМПОРТЛОХ

**Тодорхойлолт**

Энэхүү бүлгийн зорилгоор:

E1./F3.

**"Дотоодын хэрэглээнд зориулж бүрдүүлэлт хийх"** гэдэгт гаалийн бүрдүүлэлтийн холбогдох үйл ажиллагааг дуусгаж, импортын гаалийн болон бусад татварыг төлсний үндсэн дээр барааг гаалийн нутаг дэвсгэрт чөлөөт эргэлтэд оруулах гаалийн горимыг;

E2./F5.

**"Орлуулах бүтээгдэхүүн"** гэдэгт дотоодод боловсруулах горимын зөвшөөрөл авч барааг үйлдвэрлэх, боловсруулах, эсхүл засварласны үр дүнд үүссэн бүтээгдэхүүнийг;

E3./F2.

**"Буцаан импортлох мэдэгдэлтэйгээр экспортлосон бараа"** гэдэгт импортлогч нь барааг буцаан импортлохоо мэдэгдэж өөрчлөлт оруулахгүйгээр буцаан импортлох явдлыг хөнгөвчлөх үүднээс ялгаж таних арга хэмжээг авч болох барааг;

E4./F1.

**"Чөлөөт эргэлтэд байгаа бараа"** гэдэгт гаалийн зүгээс ямар нэг хязгаарлалтгүйгээр хэрэглэж болох барааг;

E5./F4.

**"Өөрчлөлт оруулахгүйгээр буцаан импортлох горим"** гэдэгт хилийн чандад үйлдвэрлэл, боловсруулалт, засвар болон бусад өөрчлөлтөд ороогүй, экспортлохтой холбогдон импортын гаалийн болон бусад татвар болон бусад төлбөрийг нөхөн буцаан төлсөн, нөхөн барагдуулсан, эсхүл болзолтойгоор чөлөөлсөнтэй холбогдон ногдуулсан аливаа төлбөрийг төлсөн нөхцөлд экспортлосон барааг дотоодын хэрэглээнд зориулж бүрдүүлэлт хийх горимоор импортын гаалийн болон бусад татваргүйгээр буцаан импортлох гаалийн горимыг тус тус хэлнэ. Өөрчлөлт оруулахгүйгээр буцаан импортлох бараа нь чөлөөт эргэлтэд байгаа бараа буюу орлуулах бүтээгдэхүүн байж болно.

**Зарчим**

**1. Стандарт**

Өөрчлөлт оруулахгүйгээр буцаан импортлох горимыг энэ бүлгийн заалт болон

тохиромжтой бол Ерөнхий хавсралтын заалтаар зохицуулна.

**Хэрэглэх хүрээ**

**2. Стандарт**

Экспортлосон барааны зарим хэсгийг буцаан импортлож байсан ч өөрчлөлт оруулахгүйгээр буцаан импортлохыг зөвшөөрнө.

**3. Стандарт**

Тийнхүү шаардлагатай нөхцөл байдалд барааг экспортлосон этгээдээс өөр этгээд уг барааг буцаан импортлоход өөрчлөлт оруулахгүйгээр буцаан импортлохыг зөвшөөрнө.

**4. Стандарт**

Бараа нь хилийн чандад байх хугацаандаа ашиглагдсан, гэмтсэн буюу муудсан гэсэн үндэслэлээр өөрчлөлт оруулахгүйгээр буцаан импортлуулахаас татгалзаж болохгүй.

**5. Стандарт**

Бараа нь хилийн чандад байх хугацаандаа барааг хадгалах, хэвийн байлгахад шаардлагатай ажиллагаа хийгдсэн байж болох үндэслэлээр өөрчлөлт оруулахгүйгээр буцаан импортлуулахаас татгалзаж болохгүй. Гэхдээ тэдгээрийн үнэ нь экспортлосон үеийнхээсээ ийм ажиллагаанд орсон гэдгээр нэмэгдэх ёсгүй.

**6. Стандарт**

Өөрчлөлт оруулахгүйгээр буцаан импортлох горимыг нь хилийн чандаас шууд буцаан импортлох бараанд төдийгүй гаалийн бусад горимд байгаа бараанд мөн хэрэглэж болно.

**7. Стандарт**

Барааг буцааж импортлох нөхцлөө заагаагүй гэсэн үндэслэлээр өөрчлөлт оруулахгүйгээр буцаан импортлуулахаас татгалзаж болохгүй.

**Өөрчлөлт оруулахгүйгээр буцаан импортлох хугацаа**

**8. Стандарт**

Өөрчлөлт оруулахгүйгээр буцаан импортлохыг зөвшөөрөх хугацааны хязгаарлалт тогтоох тохиолдолд ийм хязгаарлалт нь тохиолдол тус бүрийн нөхцөл байдлыг харгалзан хүрэлцэхүйц байна.

**Эрх бүхий гаалийн газрууд**

**9. Стандарт**

Буцаан импортлох горимыг хөнгөвчлөх тохиолдолд гааль зөвхөн өөрчлөлт оруулахгүйгээр буцаан импортлох барааг экспортлосон гаалийн газарт мэдүүлэхийг шаардана.

**Мэдүүлсэн бараа**

**10. Стандарт**

Өөрчлөлт оруулахгүйгээр буцаан импортлож байгаа баглаа боодол, чингэлэг, тавиур болон арилжааны зориулалттай олон улсын бараа тээвэрлэлтэд ашиглаж буй тээврийн хэрэгслийг экспортлох үед чөлөөт эргэлтэд байсан гэдэг нь гаальд мэдэгдэж байгаа бол тэдгээрийг гаальд бичгээр мэдүүлэхийг шаардахгүй.

**Буцаан импортлох мэдэгдэлтэйгээр экспортлосон бараа**

**11. Стандарт**

Мэдүүлэгчийн хүсэлтээр барааг буцаан импортлох мэдэгдэлтэйгээр экспортлохыг гааль зөвшөөрч, өөрчлөлт оруулахгүйгээр буцаан импортлох явдлыг хөнгөвчлөх үүднээс шаардагдах арга хэмжээг авна.

**12. Стандарт**

Буцаан импортлох мэдэгдэлтэйгээр экспортлосон барааг таньж ялгахтай холбогдсон шаардлагыг гааль тодорхойлно. Үүнд барааны шинж чанар болон ашиг сонирхлыг анхаарч үзнэ.

**13. Практик зөвлөмж**

Буцаан импортлох мэдэгдэлтэйгээр экспортлосон барааг холбогдох экспортын болон бусад татвараас болзолтойгоор чөлөөлнө.

**14. Стандарт**

Холбогдох этгээдийн хүсэлтээр буцаан импортлох мэдэгдэлтэйгээр экспортлож байгаа бараа холбогдох нөхцөл, шаардлагад нийцэж байвал түүнийг бүрмөсөн экспортлох горимд шилжүүлж болно.

**15. Практик зөвлөмж**

Буцаан импортлох мэдэгдэлтэйгээр экспортлосон барааг өөрчлөлт оруулахгүйгээр хэд хэдэн удаа буцаан импортлох тохиолдолд мэдүүлэгчийн хүсэлтээр гааль буцаан импортлох мэдэгдэлтэйгээр экспортлосон анхны экспортын мэдүүлгийг тогтоосон хугацааны дотор барааг дахин буцаан импортлох, экспортлоход ашиглаж болно.

## 3 дугаар бүлэг
## ИМПОРТЫН ГААЛИЙН БОЛОН БУСАД ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ

**Тодорхойлолт**

Энэхүү бүлгийн зорилгоор:

E1./F2.

**"Дотоодын хэрэглээнд зориулж бүрдүүлэлт хийх"** гэдэгт гаалийн бүрдүүлэлтийн холбогдох үйл ажиллагааг дуусгаж, импортын гаалийн болон бусад татварыг төлсний үндсэн дээр барааг гаалийн нутаг дэвсгэрт чөлөөт эргэлтэд оруулах гаалийн горимыг;

**"Импортын гаалийн болон бусад татвараас чөлөөлөх"** гэдэгт барааг тодорхой нөхцөлд тусгайлсан зорилгоор импортлосон тохиолдолд тэдгээрийн тарифын хэвийн ангилал буюу хэвийн төлбөрөөс үл хамааран импортын гаалийн болон бусад татваргүйгээр дотоодын хэрэглээнд зориулж бүрдүүлэлт хийх горимоор оруулахыг тус тус ойлгоно.

**Зарчим**

**1. Стандарт**

Дотоодын хэрэглээнд зориулж бүрдүүлэлт хийх горимоор оруулах барааг импортын гаалийн болон бусад татвараас чөлөөлөхөд энэхүү бүлгийн заалт, тохиромжтой бол Ерөнхий хавсралтын заалтаар зохицуулна.

Хэрэглэх хүрээ

**2. Стандарт**

Үндэсний хууль тогтоомжоор импортын гаалийн болон бусад татвараас чөлөөлөх тохиолдлын жагсаалтыг гаргана.

**3. Стандарт**

Импортын гаалийн болон бусад татвараас хилийн чандаас шууд орж ирж байгаа бараа төдийгүй гаалийн бусад горимд байгаа барааг мөн чөлөөлж болно.

**4. Практик зөвлөмж**

Олон улсын баримт бичгээр өөрөөр тогтоогоогүй бол барааны гарал үүслийн улс болон уг бараа ирсэн орноос үл хамааран барааг импортын гаалийн болон бусад татвараас чөлөөлнө.

**5. Стандарт**

Үндэсний хууль тогтоомжоор импортын гаалийн болон бусад татвараас чөлөөлөхөд урьдчилан зөвшөөрөл авах шаардлагатай тохиолдол болон ийм зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагыг жагсаана. Ийм тохиолдол боломжийн хирээр цөөн байна.

**6. Практик зөвлөмж**

Хэлэлцэн тохирогч талууд олон улсын баримт бичигт дурдсан барааг импортын гаалийн болон бусад татвараас холбогдох нөхцөлтэйгөөр чөлөөлөх асуудлыг авч үзэж, эдгээр олон улсын баримт бичигт нэгдэн орох боломжийг нарийвчлан судална.

**7. Практик зөвлөмж**

Үндэсний хууль тогтоомжид заасан бусад шаардлагатай нийцэж байгаа тохиолдолд дараахь барааг импортын гаалийн болон бусад татвар, эдийн засгийн хориг, хязгаарлалтаас чөлөөлнө:

(a) эрх бүхий байгууллагаар зөвшөөрөгдсөн байгууллага, лабораторид ирж байгаа хүний гаралтай эмнэлгийн бодис, цусны бүлэг, эд эсийг тогтоох урвалжууд;

(b) гаалийн байгууллагаас өчүүхэн бага үнэтэй гэж тооцогдсон, тэдгээрийг төлөөлсөн аливаа барааны захиалгыг авах зорилгоор оруулсан арилжааны өртөггүй дээж;

(c) тухайн улсад оршин суухаар нүүх зорилгоор аливаа этгээд буюу түүний гэр бүлийн бусад гишүүдийн хувийн болон мэргэжлийн хэрэгцээний зориулалтаар ашиглахаар тухайн улсад өөрийн хамт буюу тусдаа авчирсан үйлдвэрийн, арилжааны эсхүл хөдөө аж ахуйн хэрэгсэл, тоног төхөөрөмжөөс бусад салгаж болох зүйлс;

(d) импортлогч улсад голлон амьдарч байгаад нас барсан хүний өв залгамжилсан эд зүйлс, чингэхдээ энэхүү эд зүйлс нь нас барсан хүний хувийн хэрэглээний эд зүйлс байх ёстой;

(e) жижиглэн худалдаалах үнийн үндсэн дээр үндэсний хууль тогтоомжоор тогтоосон нийт үнээс хэтрэхгүй архи, согтууруулах ундаа болон тамхины төрлийн бараанаас бусад хувийн бэлэг;

(f) энэрлийн буюу буяны зөвшөөрөгдсөн байгууллагад тухайн байгууллага эсхүл түүний хяналтын дор ядуу хүмүүст үнэ төлбөргүйгээр тараах зориулалтаар бэлэг болгон илгээсэн хүнсний бүтээгдэхүүн, эмийн зүйлс, хувцас, хөнжил зэрэг бараа;

(g) гаалиас шаардсан дагалдах бичиг баримтыг шалгуулсны үндсэн дээр импортлогч улсад оршин суугч хүмүүст олгох шагнал;

(h) эрх бүхий байгууллагаар зөвшөөрөгдсөн байгууллагуудын импортлосон цэргийн булшийг босгох, хамгаалах буюу чимэглэх зориулалттай материал, авс, чандрын сав, оршуулгын чимэглэлийн зүйлс;

(i) үндэсний хууль тогтоомжоор тогтоосон бичиг баримт, маягт, хэвлэмэл зүйлс, тайлан мэдээ болон арилжааны өртөггүй бусад зүйл;

(j) шүтлэгийн зориулалттай шашны эд зүйлс; болон

(k) шинжилгээнд шаардагдах хэмжээнээс хэтрэхгүй тохиолдолд шинжилгээний зориулалтаар оруулсан бүтээгдэхүүн, чингэхдээ шинжилгээний явцад ашигласан буюу түүнээс үлдсэн бүтээгдэхүүнийг гаалийн хяналтын дор буцаан экспортлох буюу арилжааны өртөггүй болгон шилжүүлнэ.

## ТУСГАЙ ХАВСРАЛТ С

### 1 дүгээр бүлэг

### БҮРМӨСӨН ЭКСПОРТЛОХ ГОРИМ

Тодорхойлолт

Энэхүү бүлгийн зорилгоор:

E1./F1.

**"бүрмөсөн экспортлох горим"** гэж чөлөөт эргэлтэд байгаад гаалийн нутаг дэвсгэрээс гарч, түүний гадна байнга үлдэх бараанд хамаарах гаалийн горимыг хэлнэ.

Зарчим

**1. Стандарт**

Бүрмөсөн экспортлох горимыг энэ бүлгийн заалт болон тохиромжтой бол Ерөнхий хавсралтын заалтаар зохицуулна.

Бичиг баримтын бүрдүүлэлт

**2. Практик зөвлөмж**

Бүрмөсөн экспортлох бараатай холбогдсон шаардлагатай мэдээллийг заасан нөхцөлтэйгээр барааны стандарт мэдүүлгээс өөр байдлаар мэдүүлж болох талаар үндэсний хууль тогтоомжид заана.

Хүрэх газраа очсоныг нотлох баримт

**3. Стандарт**

Гаалийн байгууллага бараа гадаадад хүрэх газраа очсон эсэхийг нотлох баримтыг шаардах ёсгүй.

## ТУСГАЙ ХАВСРАЛТ D

### 1 дүгээр бүлэг

### ГААЛИЙН АГУУЛАХ

Тодорхойлолт

Энэхүү бүлгийн зорилгоор:

E1./F1.

**"Гаалийн агуулахын горим"** гэж импортын барааг импортын гаалийн болон бусад татваргүйгээр гаалийн хяналтын дор зориулалтын газар (гаалийн агуулахад) хадгалах гаалийн горимыг хэлнэ.

**Зарчим**

**1. Стандарт**

Гаалийн агуулахын горимыг энэ бүлгийн заалт болон тохиромжтой Ерөнхий хавсралтын заалтаар зохицуулна.

**Гаалийн агуулахын ангилал**

**2. Стандарт**

Тухайн барааг захиран зарцуулах эрх бүхий аливаа этгээдэд нээлттэй гаалийн агуулах (гаалийн нээлттэй агуулах)-ыг үндэсний хууль тогтоомжоор зохицуулна.

**3. Стандарт**

Худалдааны тусгай хэрэгцээг хангахад шаардлагатай гэж үзэх тохиолдолд гаалийн агуулах (гаалийн хаалттай агуулах)-ыг тодорхой этгээд ганцаараа ашиглах талаар үндэсний хууль тогтоомжоор зохицуулна.

**Агуулах байгуулах, удирдах болон хяналт тавих**

**4. Стандарт**

Гаалийн агуулах байгуулах, тохиромжтой байх, удирдахад тавих шаардлага, мөн гаалийн хяналтын арга хэмжээг гаалийн байгууллага тогтооно. Гаалийн агуулахад бараа хадгалах болон нягтлан бодох бүртгэлийг гааль батална.

**Бараа оруулах**

**5. Практик зөвлөмж**

Импортын гаалийн болон бусад татвартай, эсхүл дор дурдсанаас бусад шалтгаанаар хориг буюу хязгаар тогтоосон импортын бүх төрлийн барааг, түүний тоо хэмжээ, гарал үүслийн улс, илгээсэн буюу хүлээн авах улсыг үл харгалзан гаалийн нээлттэй агуулахад хадгалахыг зөвшөөрнө:

- нийгмийн ёс зүй буюу хэв журам, нийгмийн аюулгүй байдал, нийгмийн эрүүл ахуй буюу эрүүл мэнд, мал эмнэлэг, эсхүл ургамал хорио цээрийн асуудлаар; эсхүл
- патент, худалдааны тэмдэгт болон зохиогчийн эрхийг хамгаалах.

Аюултайд тооцогдох, бусад бараанд нөлөөлж болзошгүй, эсхүл тусгай тоноглол шаардах барааг зөвхөн тэдгээрт тусгайлан зориулсан гаалийн агуулахад оруулна.

**6. Стандарт**

Гаалийн байгууллага гаалийн хаалттай агуулахад оруулах барааны нэр төрлийг тогтоож өгнө.

**7. Практик зөвлөмж**

Экспортлоход импортын гаалийн болон бусад татварыг нь буцаан олгох бараат тийм татварыг нэн даруй буцаан олгох тохиолдолд, холбогдох барааг цаашид экспортлох нөхцлөөр гаалийн агуулахад оруулахыг зөвшөөрнө.

**8. Практик зөвлөмж**

Түр оруулах горимд байгаа барааг цаашид экспортлох, эсхүл зөвшөөрөгдсөн бусад байдлаар захиран зарцуулах зорилгоор, уг горимын дагуу хүлээх үүргийг хойшлуулж буюу дуусгавар болгож гаалийн агуулахад оруулахыг зөвшөөрнө.

**9. Практик зөвлөмж**

Экспортлохоор төлөвлөж байгаа бөгөөд дотоодын гаалийн болон бусад татвар ногдуулах буюу ногдуулж барагдуулсан барааг дотоодын тийм гаалийн болон бусад татвараас чөлөөлөгдөх боломж олгох зорилгоор, тухайн барааг цаашид экспортлох нөхцлөөр гаалийн агуулахад оруулахыг зөвшөөрнө.

**Зөвшөөрөгдсөн үйл ажиллагаа**

**10. Стандарт**

Агуулахад байгаа барааг захиран зарцуулах эрх бүхий аливаа этгээд гаалийн байгууллагаас хүлээн зөвшөөрсөн шалтгаанаар дараахь үйл ажиллагааг явуулж болно:

a. бараанд үзлэг шалгалт хийх;

b. шаардлагатай бол гаалийн болон бусад татвар төлж, загвар авах;

c. барааны чанарыг хадгалахад шаардлагатай үйл ажиллагаа явуулах; болон

d. барааны баглаа боодол, зах зээлд борлогдох чанарыг сайжруулахад, эсхүл задгай барааг хэсэглэх, баглаа боодлыг бүлэглэх, ангилах, зэрэглэл тогтоох, дахин савлах зэргээр барааг ачилтад бэлтгэхэд шаардлагатай өөр бусад ердийн арчилгааны үйл ажиллагаа явуулах.

**Хадгалах хугацаа**

**11. Стандарт**

Гаалийн байгууллага худалдааны эрэлт хэрэгцээг харгалзан барааг гаалийн агуулахад хадгалахыг зөвшөөрсөн цаад хугацааг тогтоох бөгөөд амархан гэмтэхгүй барааны хувьд уг хугацаа нь нэг жилээс доошгүй байна.

**Эзэмших эрхийг шилжүүлэх**

**12. Стандарт**

Агуулахад хадгалагдсан барааг эзэмших эрхийг шилжүүлэхийг зөвшөөрнө.

**Бараа чанараа алдах**

**13. Стандарт**

Гаалийн агуулахын горимд байхдаа осол буюу давагдашгүй хүчин зүйлийн улмаас чанараа алдсан, эсхүл гэмтэж муудсан барааг тийнхүү чанараа алдсан буюу гэмтэж муудсаныг гаалийн байгууллага хүлээн зөвшөөрөхөөр зохих ёсоор тогтоогдсон бол чанараа алдсан буюу гэмтэж муудсан байдлаар импортлогдсонд тооцож, дотоодод хэрэглэхээр мэдүүлэхийг зөвшөөрнө.

**Барааг агуулахаас гаргах**

**14. Стандарт**

Тухайн барааг захиран зарцуулах эрх бүхий аливаа этгээд уг барааг бүхэлд нь буюу хэсэгчлэн гаалийн нэг агуулахаас нөгөөд, эсхүл гаалийн өөр горимд оруулахаар гаргахыг зөвшөөрнө. Ингэхдээ тухайн тохиолдол бүрт хамаарах нөхцөлийг хангасан байна.

**15. Стандарт**

Барааг гаалийн агуулахаас тогтоосон хугацаанд гаргаагүй тохиолдолд дагаж мөрдөх журмыг үндэсний хууль тогтоомжид заана.

**Гаалийн агуулахыг хаах**

**16. Стандарт**

Гаалийн агуулахыг хаах тохиолдолд, холбогдох этгээдэд өөрийн барааг гаалийн өөр агуулахад шилжүүлэх, эсхүл гаалийн өөр горимд оруулах хангалттай хугацаа олгоно. Ингэхдээ тухайн тохиолдол бүрт хамаарах нөхцөл, журмыг хангасан байна.

**2 дугаар бүлэг**
**ЧӨЛӨӨТ БҮС**
**Тодорхойлолт**

Энэхүү Бүлгийн зорилгоор:

E1./F1

**"Чөлөөт бүс"** гэж Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрийн нэг хэсэг бөгөөд түүнд оруулсан аливаа барааг импортын гаалийн болон бусад татварын хувьд ерөнхийдөө гаалийн нутаг дэвсгэрийн гадна байгаад тооцно.

**Зарчим**

**1. Стандарт**

Чөлөөт бүсэд хамаарах гаалийн журмыг энэ Бүлгийн заалтаар, болон холбогдолтой гэж үзвэл, Ерөнхий Хавсралтын заалтаар зохицуулна.

**Байгуулах болон хяналт тавих**

**2. Стандарт**

Чөлөөт бүс байгуулах, уг бүсэд оруулах барааны нэр төрөл, түүнд оруулсан бараатай холбогдуулан явуулж болох үйл ажиллагаанд тавих шаардлагыг үндэсний хууль тогтоомжид заана.

**3. Стандарт**

Чөлөөт бүсийг зохих ёсоор ажиллуулах боломж, байгууламж, загварт хамаарах зохих шаардлага зэрэг гаалийн хяналтын арга хэмжээг гаалийн байгууллага тогтооно.

**4. Стандарт**

Гаалийн байгууллага чөлөөт бүсэд хадгалагдаж буй бараанд хэдийд ч шалгалт хийх эрхтэй.

**Бараа оруулах**

**5. Стандарт**

Зөвхөн гадаадаас шууд импортолсон бараа төдийгүй бас Хэлэлцэн тохирогч холбогдох Талын гаалийн нутаг дэвсгэрт байсан бараага чөлөөт бүсэд оруулахыг зөвшөөрнө.

**6. Практик зөвлөмж**

Гадаадаас авчирсан барааг чөлөөт бүсэд оруулахыг зөвхөн дор дурдсанаас бусад шалтгаанаар хориг, эсхүл хязгаар тогтоосон гэсэн үндэслэлээр зөвшөөрөхгүй байж болохгүй:

- нийгмийн ёс зүй буюу хэв журам, нийгмийн аюулгүй байдал, нийгмийн эрүүл ахуй, эрүүл мэнд, мал эмнэлэг, ургамал хорио цээр; эсхүл
- патент, худалдааны тэмдэгт, зохиогчийн эрхийг хамгаалах.

Аюултайд тооцогдох, бусад бараанд нөлөөлж болзошгүй, эсхүл тусгай тоноглол шаардах барааг зөвхөн тэдгээрт тусгайлан зориулсан чөлөөт бүсэд оруулна.

**7. Стандарт**

Аливаа нэг чөлөөт бүсэд оруулахыг зөвшөөрсөн бөгөөд экспортлоход импортын гаалийн болон бусад татвараас чөлөөлөгдөх, эсхүл түүнийг нь буцаан олгох барааг холбогдох чөлөөт бүсэд оруулсан даруй уг татвараас чөлөөлөх буюу түүнийг буцаан олгоно.

**8. Стандарт**

Чөлөөт бүсэд оруулахыг зөвшөөрсөн бөгөөд экспортлоход дотоодын гаалийн болон бусад татвараас чөлөөлөх, эсхүл түүнийг нь буцаан олгох барааг холбогдох чөлөөт бүсэд оруулсны дараа уг татвараас чөлөөлөх буюу түүнийг буцаан олгоно.

**9. Практик зөвлөмж**

Хэрэв тухайн барааг дагалдах бичиг баримтад тодорхой мэдээлэл тусгагдсан бол, гадаадаас шууд чөлөөт бүсэд оруулах барааны хувьд гаалийн байгууллага, барааны мэдүүлэг шаардахгүй.

**Баталгаа**

**10. Практик зөвлөмж**

Гаалийн байгууллага барааг чөлөөт бүсэд оруулахад баталгаа шаардахгүй.

**Зөвшөөрөгдсөн үйл ажиллагаа**

**11. Стандарт**

Чөлөөт бүсэд оруулсан барааны чанарыг хадгалахад шаардлагатай, мөн түүний баглаа боодол, зах зээлд борлогдох чанарыг сайжруулах, эсхүл задгай барааг хэсэглэх, баглаа боодлыг бүлэглэх, ангилах, зэрэглэл тогтоох, дахин савлах зэргээр барааг ачилтад бэлтгэх ердийн арчилгаанд шаардлагатай үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрнө.

**12. Стандарт**

Хэрэв чөлөөт бүсэд боловсруулалт хийх, эсхүл үйлдвэрлэл явуулахыг эрх бүхий байгууллага зөвшөөрсөн бол ерөнхийдөө зөвшөөрсөн болон/эсхүл тухайн чөлөөт бүсэд хамаарах аль нэг дүрэм журамд нарийвчилан заасан, эсхүл дээрх үйл ажиллагаа явуулдаг үйлдвэрийн газарт зөвшөөрч болох боловсруулалтын буюу үйлдвэрлэлийн үйл ажиллагааг холбогдох байгууллага зааж өгнө.

**Чөлөөт бүсэд ашигласан бараа**

**13. Стандарт**

Чөлөөт бүсийн дотор ашиглах барааг импортын гаалийн болон бусад татвараас чөлөөлөх тохиолдлууд болон ямар шаардлага хангасан байх талаар үндэсний хууль тогтоомжид заана.

**Байх хугацаа**

**14. Стандарт**

Зөвхөн онцгой тохиолдолд, чөлөөт бүсэд бараа байх хугацаанд хязгаарлалт тавина.

**Өмчлөх эрхийг шилжүүлэх**

**15. Стандарт**

Чөлөөт бүсэд оруулсан барааг өмчлөх эрхийг шилжүүлэхийг зөвшөөрнө.

**Барааг гаргах**

**16. Стандарт**

Чөлөөт бүсэд оруулсан, эсхүл тэнд үйлдвэрлэсэн барааг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн өөр чөлөөт бүсэд оруулах, эсхүл гаалийн өөр горимд шилжүүлэхийг, тухайн тохиолдол бүрт хамаарах нөхцөл журмын дагуу зөвшөөрнө.

**17. Стандарт**

Барааг чөлөөт бүсээс гаргахад зөвхөн шаардагдах мэдүүлэг нь уг бараа байгаа гаалийн тухайн горимд ердийн үед шаардагдах барааны мэдүүлэг байна.

**18. Практик зөвлөмж**

Хэрэв чөлөөт бүсэд гадаадад шууд илгээх барааны хувьд гаалийн байгууллагад ямар нэгэн бичиг баримт гаргаж үзүүлэх тохиолдолд, холбогдох гаалийн байгууллага тухайн бараат дагалдах бичиг баримтад тусгагдсанаас илүү мэдээлэл шаардахгүй.

**Гаалийн болон бусад татварыг тодорхойлох**

**19. Стандарт**

Чөлөөт бүсээс дотоодын хэрэглээнд зориулан гаргах барааны үнэ, тоо хэмжээ, түүнчлэн тухайн тохиолдолд уг бараанд хамаарах импортын гаалийн болон бусад татвар буюу дотоодын гаалийн болон бусад татварын хувь хэмжээг тодорхойлох зорилгоор аль өдрийг авч үзэх вэ гэдгийг үндэсний хууль тогтоомжид заана.

**20. Стандарт**

Чөлөөт бүсэд боловсруулсан, эсхүл үйлдвэрлэсний дараа дотоодод хэрэглэхээр оруулсан бараанд тухайн тохиолдолд хамаарах импортын гаалийн болон бусад татвар буюу дотоодын гаалийн болон бусад татварын хэмжээг тодорхойлоход хэрэглэх дүрэм журмыг үндэсний хууль тогтоомжид заана.

**Чөлөөт бүсийг хаах**

**21. Стандарт**

Чөлөөт бүсийг хаах тохиолдолд холбогдох этгээдэд өөрийн бараат өөр чөлөөт бүсэд шилжүүлэх, эсхүл гаалийн өөр горимд оруулах хангалттай хугацаа олгоно. Ингэхдээ тухайн тохиолдол бүрт хамаарах нөхцөл журмыг хангасан байна.

**ТУСГАЙ ХАВСРАЛТ Е**

**1 дүгээр бүлэг**

**ГААЛИЙН ДАМЖИН ӨНГӨРӨХ**

**Тодорхойлолт**

Энэхүү Бүлгийн зорилгоор:

E1./F4

**"эрх бүхий хүлээн авагч"** гэж бараат хүлээн авах газрын албанд үзүүлэлгүйгээр шууд өөрийнхөө агуулахад хүлээн авахыг гаалийн байгууллагаас зөвшөөрсөн этгээдийг хэлнэ;

E2./F5

**"эрх бүхий илгээгч"** гэж бараат илгээх газрын албанд үзүүлэлгүйгээр шууд өөрийнхөө агуулахаас илгээхийг гаалийн байгууллагаас зөвшөөрсөн этгээдийг хэлнэ;

E3./F1

**"хяналтын алба"** гэж нэг буюу хэд хэдэн "эрх бүхий илгээгч", "эрх бүхий хүлээн авагч"-ийг хариуцсан бөгөөд, үүнтэй холбогдуулж, гаалиар дамжин өнгөрөх бүх ажиллагааг тусгай хянах үүрэг гүйцэтгэдэг гаалийн албыг хэлнэ;

E4./F7

**"гаалийн дамжин өнгөрөх горим"** гэж бараат гаалийн нэг байгууллагаас нөгөөд гаалийн хяналтын дор тээвэрлэх гаалийн горимыг хэлнэ;

E5./F6

**"гаалийн дамжин өнгөрөх ажиллагаа"** гэж бараат илгээх албанаас хүлээн авах газрын алба хүртэл гаалийн хяналтанд тээвэрлэхийг хэлнэ;

E6./F2

**"илгээх алба"** гэж гаалийн дамжин өнгөрөх ажиллагаа эхэлж буй гаалийн байгууллагыг хэлнэ;

E7./F3

**"хүлээн авах алба"** гэж гаалийн дамжин өнгөрөх ажиллагаа дуусгавар болж буй гаалийн байгууллагыг хэлнэ;

E8./F8

**"тээврийн хэрэгсэл"** гэж дараах зүйлийг хэлнэ:

a. нэг куб метр буюу түүнээс дээш дотоод эзэлхүүнтэй чингэлэг, түүний дотор задалж, угсардаг биетүүд; хуурай замын тээврийн хэрэгсэл түүний дотор чиргүүл, хагас чиргүүл;

b. төмөр замын тээврийн хэрэгсэл буюу вагон;

c. завь, сал болон бусад усан онгоц; болон

d. нисэх онгоц.

**Зарчим**

**1. Стандарт**

Гаалийн дамжин өнгөрөх горимыг энэ Бүлгийн заалт, болон холбогдолтой гэж үзвэл, Ерөнхий Хавсралтын холбогдох заалтаар зохицуулна.

**Үйлчлэх хүрээ**

**2. Стандарт**

Гаалийн байгууллага бараат гаалийн дамжин өнгөрөх горимын дагуу өөрийн нутаг дэвсгэрт дараах чиглэлээр тээвэрлэхийг зөвшөөрнө:

a. хилийн орох боомтоос хилийн гарах боомт хүртэл;

b. хилийн орох боомтоос гүний гаалийн байгууллага хүртэл;

c. гүний гаалийн байгууллагаас хилийн гарах боомт хүртэл; болон

d. гүний гаалийн нэг байгууллагаас гүний гаалийн нөгөө байгууллага хүртэл.

**3. Стандарт**

Гаалийн байгууллагаас тавьсан нөхцөл хангагдсан, болон шаардлагатай баталгаа гаргасан тохиолдолд гаалийн дамжин өнгөрөх горимоор тээвэрлэж буй бараанд гаалийн болон бусад татвар төлөхгүй.

**4. Стандарт**

Гаалийн дамжин өнгөрөх горимын дагуу үүрэг хүлээх, ялангуяа гаалийн байгууллагаас

тавьсан нөхцөлийн дагуу барааг хүлээн авах газрын албанд хөндөлгүй хүргэх хариуцлага хүлээх этгээдийг үндэсний хууль тогтоомжоор тодорхойлно.

**5. Практик зөвлөмж**

Гаалийн байгууллага гаалиас тавьсан тодорхой нөхцөл хангагдсан гэж үзвэл эрх бүхий илгээгч болон эрх бүхий хүлээн авагчаар холбогдох этгээдийг батална.

**Илгээх газарт хийх бүрдүүлэлт**

(а) Гаалийн дамжин өнгөрөх барааны мэдүүлэг

**6. Стандарт**

Шаардлагатай мэдээллийг тодорхой тусгасан арилжааны буюу тээврийн аливаа бичиг баримтыг гаалийн дамжин өнгөрөх барааны мэдүүлгийн барааг тодорхойлох хэсгийн улсад хүлээн зөвшөөрч, ийнхүү хүлээн зөвшөөрсөн тухай уг бичиг баримтад тэмдэглэнэ.

**7. Практик зөвлөмж**

Гаалийн бүх шаардлагыг хангасан холбогдох барааны хувьд арилжааны буюу тээврийн аливаа бичиг баримтыг гаалийн дамжин өнгөрөх барааны мэдүүлгийн адилаар хүлээн зөвшөөрнө. Ийнхүү хүлээн зөвшөөрсөн тухай холбогдох бичиг баримтад тэмдэглэнэ.

(b) Барааг битүүмжлэх болон онцлон таних

**8. Стандарт**

Илгээх газрын гаалийн байгууллага тухайн барааг хүлээн авах газрын онцлон таних, зөвшөөрөлгүй хөндсөн эсэхийг илрүүлэх талаар шаардлагатай бүх арга хэмжээг авна.

**9. Практик зөвлөмж**

Олон улсын бусад конвенцийн дагуу гаалийн байгууллага барааг гаалийн битүүмжлэлтэй тээвэрлэх зорилгоор тээврийн хэрэгсэлд зөвшөөрөл олгох шаардлага ерөнхийдөө тавихгүй.

**10. Стандарт**

Барааг тээврийн хэрэгслээр тээвэрлэх бөгөөд гаалийн битүүмжлэл шаардлагатай бол гаалийн ломбыг тээврийн хэрэгсэл дээр тавих ба тухайн тээврийн хэрэгслийг дараахь байдлаар тоноглосон байна:

a. гаалийн ломбыг хялбархан, найдвартай тавих боломжтой байх;

b. нүдэнд харагдах ул мөр үлдээлгүй, эсхүл гаалийн ломбыг эвдэлгүйгээр тухайн тээврийн хэрэгслийн битүүмжилсэн хэсэгт бараа хийх, тэндээс гаргах боломжгүй байх;

c. бараа нууж болох нууц зай завсаргүй байх; болон

d. бараа хийж болох бүх зай завсрыг гаалийн байгууллага шалгах боломжтой байх.

Тээврийн хэрэгсэл гаалийн дамжин өнгөрөх горимын зорилгод нийцсэн найдвартай эсэхийг гаалийн байгууллага тодорхойлно.

**11. Практик зөвлөмж**

Дагалдах бичиг баримтаар барааг гарцаагүй онцлон таних боломжтой бол тухайн барааг ерөнхийд нь гаалийн ломбогүй буюу бэхэлгээ утасгүй тээвэрлэвэл зохино. Гэхдээ дараахь тохиолдолд гаалийн ломбо буюу бэхэлгээ утас хэрэглэнэ:

- илгээх газрын гаалийн байгууллага эрсдлийн менежментийн хүрээнд шаардлагатай гэж үзсэн;

- гаалийн дамжин өнгөрөх ажиллагааг бүхэлд нь хөнгөвчлөхөөр бол; эсхүл

- олон улсын хэлэлцээрт тийнхүү заасан бол.

**12. Стандарт**

Хэрэв барааг зарчмын хувьд гаалийн битүүмжлэлтэй тээвэрлэх ёстой боловч тээврийн хэрэгсэлд ломбыг найдвартай тавих боломжгүй бол барааг онцлон таних, зөвшөөрөлгүй хөндсөнийг хялбархан илрүүлэх ажлыг дараахь замаар хийнэ:

- бараанд бүрэн шалгалт хийх, шалгалтын дүнг дамжин өнгөрөх бичиг баримтад тэмдэглэх;

- гаалийн ломбо буюу бэхэлгээ утсыг боодол бүрд хэрэглэх;

- дамжин өнгөрөх бичиг баримтад хавсаргах загвар, зураг төсөл, схем, фото зураг, эсхүл тэдгээртэй ижилтгэх хэрэгслийг ашиглан барааг тодорхой дүрслэх;

- маршрут, цагийн хязгаарыг хатуу тогтоох; эсхүл

- гаалийн харгалзагч томилох.

Гэвч тээврийн хэрэгслийг битүүмжлэлгүй явуулах шийдвэр нь зөвхөн гаалийн байгууллагын эрх мэдлийн асуудал болно.

**13. Стандарт**

Хэрэв гаалийн байгууллага гаалийн дамжин өнгөрөхөд цагийн хязгаар тогтоодог бол тэр нь дамжин өнгөрөх ажиллагаанд хүрэлцэхүйц хангалттай урт хугацаатай байна.

**14. Практик зөвлөмж**

Холбогдох этгээдийн хүсэлтээр, болон гаалийн байгууллагаас хүлээн зөвшөөрсөнөөр, гаалийн байгууллага анх тогтоосон аливаа хугацааг сунгана.

**15. Стандарт**

Зөвхөн гаалийн байгууллага зайлшгүй шаардлагатай гэж үзвэл дараахь арга хэмжээг авна:

(a) барааг тогтоосон маршрутаар явуулахыг шаардах; эсхүл

(b) барааг гаалийн харгалзагчтай тээвэрлэхийг шаардах.

**Гаалийн битүүмжлэл**

**16. Стандарт**

Гаалийн дамжин өнгөрөх горимыг мөрдөхөд хэрэглэх гаалийн ломбо болон бэхэлгээ утас нь энэ Бүлгийн Зүүлтэд заасан наад захын шаардлагад нийцсэн байна.

**17. Практик зөвлөмж**

Гадаадын гаалийн байгууллагын тавьсан гаалийн битүүмжлэл болон онцлон таних тэмдгийг дор дурдсанаас бусад тохиолдолд гаалийн дамжин өнгөрөх ажиллагааны зорилгоор хүлээн зөвшөөрнө:

- тэдгээрийг хангалттай биш гэж үзсэн;
- тэдгээр нь найдвартай биш байх; эсхүл
- гаалийн байгууллага холбогдох барааг гэнэт шалгах болсон.

Хэрэв гадаадын гаалийн ломбо болон бэхэлгээ утсыг аливаа нэг гаалийн нутаг дэвсгэрт хүлээн зөвшөөрсөн бол тэдгээр нь тухайн нутаг дэвсгэрт үндэсний ломбо болон бэхэлгээ утасны адилаар хууль тогтоомжийн хамгаалалтад байна.

**18. Практик зөвлөмж**

Хэрэв холбогдох гаалийн газар гаалийн ломбо болон бэхэлгээ утсыг шалгасан, эсхүл барааг шалгасан бол энэ тухай дамжин өнгөрөх бичиг баримтад тэмдэглэнэ.

**Аяллын замд мөрдөх ажиллагаа**

**19. Стандарт**

Хүлээн авах газрын албанд хийгдсэн өөрчлөлтийг холбогдох гаалийн байгууллага урьдчилан баталгаажуулах шаардлагатай гэж зааснаас бусад тохиолдолд урьдчилсан мэдэгдэлгүйгээр хүлээн зөвшөөрнө.

**20. Стандарт**

Гаалийн аливаа ломбо буюу бэхэлгээ утас гэмтээгүй, эсхүл гадны хөндөлтөд өртөөгүй бол холбогдох барааг гаалийн байгууллагын зөвшөөрөлгүйгээр тээврийн нэг хэрэгслээс нөгөөд шилжүүлж болно.

**21. Практик зөвлөмж**

Гаалийн байгууллага гаалийн дамжин өнгөрөх горимоор барааг тээврийн хэрэгсэлд бусад барааны хамт нэгэн зэрэг тээвэрлэхийг зөвшөөрнө. Чингэхэд тухайн бараа онцлон таних боломжтой болон гаалийн бусад шаардлага хангагдсан байна.

**22. Практик зөвлөмж**

Гаалийн байгууллага гаалийн дамжин өнгөрөх ажиллагаанд шууд нөлөөлж буй осол буюу бусад гэнэтийн аюулын талаар хамгийн ойрхон орших гаалийн байгууллагад, эсхүл эрх бүхий бусад байгууллагад нэн даруй мэдэгдэхийг холбогдох этгээдээс шаардана.

**Гаалийн дамжин өнгөрөх ажиллагаа дуусгавар болох**

**23. Стандарт**

Гаалийн дамжин өнгөрөх ажиллагаа дуусгавар болохтой холбогдуулан, холбогдох бараанд өөрчлөлт оруулалгүйгээр, мөн түүнийг ашиглаагүй байдлаар, түүнчлэн гаалийн ломбо, бэхэлгээ утас буюу таних тэмдгийг гэмтээлгүйгээр тухайн бараа болон барааны холбогдох мэдүүлгийг хүлээн авах гаалийн байгууллагад тогтоосон хугацааны дотор гаргаж өгөхөөс өөр зүйл шаардахгүй байхыг үндэсний хууль тогтоомжид заана.

**24. Стандарт**

Холбогдох бараа хүлээн авах гаалийн байгууллагын хяналтанд ормогц тухайн байгууллагад, хэрэв бүх нөхцөл хангагдсан гэж үзвэл, гаалийн дамжин өнгөрөх ажиллагааг дуусгавар болгох арга хэмжээг саадгүй хэрэгжүүлнэ.

**25. Практик зөвлөмж**

Хэрэв бусад бүх шаардлага хангагдсан гэж гаалийн байгууллага үзсэн бол, тогтоосон маршрут буюу тогтоосон хугацааг баримтлан ажиллаж чадаагүй нь, төлбөл зохих гаалийн болон бусад аливаа татварыг хураан авах үндэслэл болохгүй.

**Гаалийн дамжин өнгөрөхөд хамаарах олон улсын хэлэлцээр**

**26. Практик зөвлөмж**

Хэлэлцэн тохирогч Талууд гаалийн дамжин өнгөрөхөд хамаарах олон улсын баримт бичгүүдэд нэгдэн орох боломжийг анхааран авч үзвэл зохино. Хэрэв тэд олон улсын тийм баримт бичгүүдэд нэгдэн орох байр суурьгүй бол, гаалийн дамжин өнгөрөх олон улсын горим тогтоох үүднээс хоёр талт буюу олон талт хэлэлцээрийн төсөл хийхдээ, энэхүү Бүлгийн стандарт заалт болон практик зөвлөмжийг анхаарч үзнэ.

**ЗҮҮЛТ**

**Гаалийн ломбо болон бэхэлгээ утсанд тавих наад захын шаардлага**

А. Гаалийн ломбо болон бэхэлгээ утас нь дараахь наад захын шаардлагыг хангасан байна:

1. Ломбо болон бэхэлгээ утсанд тавих ерөнхий шаардлага:

Ломбо болон бэхэлгээ утас нь:

a. бөх бат, эдэлгээтэй байх;

b. хялбархан бөгөөд түргэн хийх боломжтой байх;

c. шууд шалгах болон онцлон таних боломжтой байна;

d. эвдэлгүй, эсхүл ул мөр үлдээлгүй салгах, тайлах боломжгүй байх;

e. олон удаа хэрэглэх ломбо (жишээ нь: электрон ломбо)-ноос бусдыг нэгээс илүү удаа хэрэглэх боломжгүй байх;

f. хуулбарлах буюу хуурамчаар үйлдэхэд төвөгтэй байхаар хийсэн байх.

2. Ломбоны онцлог шинж байдал:

a. ломбоны хэлбэр, хэмжээ нь таних тэмдгийг шууд онцлон таних боломжтой байх;

b. ломбоны нүх нь бэхэлгээ утасны хэмжээнд тохирсон, байрлал нь ломбыг хавчихад бэхэлгээ утас хөдөлгөөнгүй байх;

c. ослоос гэмтэх, чанараа эрт алдах (цаг агаарын нөхцөл байдал, химийн урвал гэх мэтийн улмаас), эсхүл ул мөргүй хөндөгдөх явдлаас урьдчилан сэргийлэх үүднээс ломбоны материал нь аль болох хатуу байх;

d. ломбоны материалыг сонгохдоо тухайн битүүмжлэлийн системийг харгалзан үзнэ.

3. Бэхэлгээ утасны онцлог шинж байдал:

a. бэхэлгээ утас нь бөх бат, эдэлгээтэй, цаг агаар, зэврэлтийн нөлөөнд өртөхөөргүй байх;

b. бэхэлгээ утас нь битүүмжилсэн онгорхой цоорхойг ломбо буюу бэхэлгээ утсыг эвдэх, эсхүл тэдгээрт илэрхий гэмтэл учруулалгүйгээр их, бага хэмжээгээр онгойлгох боломжгүй тийм урттай байх;

c. бэхэлгээ утасны материалыг сонгохдоо тухайн битүүмжлэлийн системийг харгалзан үзнэ.

4. Таних тэмдэг:

Ломбо буюу бэхэлгээ утсанд дараахь зорилгоор тэмдэг тавина:

a. Зөвлөлийн албан ёсны аль нэг хэлээр (англи буюу франц) "Гааль" гэсэн үгийг хэрэглэн, тэр нь гаалийн битүүмжлэл болохыг харуулах;

b. олон улсын тээвэрт ашиглаж буй автотээврийн хэрэгслийн бүртгэлийн улсыг илтгэх бүртгэлийн дугаарыг ашиглан, тухайн битүүмжлэлийг тавьсан улсыг харуулах;

c. жишээлбэл, үсэг, дугаар бүхий код ашиглан, тухайн битүүмжлэлийг тавьсан, эсхүл түүнийг тавихыг зөвшөөрсөн гаалийн байгууллагыг таних боломжийг бүрдүүлэх.

B. Гаалийн зорилгоор гаалийн дамжин өнгөрөх горимын баталгааг хангах үүднээс эрх бүхий илгээгч, зөвшөөрөгдсөн бусад этгээдийн хэрэглэсэн ломбо, эсхүл бэхэлгээний утас нь шинж байдлаараа гаалийн байгууллагаас тавьсан битүүмжлэлийнхтэй харьцуулахуйц бөгөөд дамжин өнгөрөх бичиг баримтын дугаарыг ашиглан, тухайн битүүмжлэл тавьсан этгээдийг таних боломжтой байна.

**2 дугаар бүлэг**

**ШИЛЖҮҮЛЭН АЧИХ**

**Тодорхойлолт**

Энэхүү Бүлгийн зорилгоор:

**"Шилжүүлэн ачих"** гэж импортлох болон экспортлох үйл ажиллагааны аль алиныг нь явуулдаг гаалийн байгууллагын харъяалах газрын бүсэд барааг орох тээврийн хэрэгслээс гарах тээврийн хэрэгсэлд гаалийн хяналтын дор шилжүүлэн ачих гаалийн горимыг хэлнэ.

**Зарчим**

**1. Стандарт**

Шилжүүлэн ачих горимыг энэ Бүлгийн заалт болон холбогдолтой гэж үзвэл, Ерөнхий Хавсралтын заалтаар зохицуулагдана.

**2. Стандарт**

Хэрэв гаалийн байгууллагаас тавьсан нөхцөл хангагдсан бол шилжүүлэн ачихыг зөвшөөрсөн бараанд гаалийн болон бусад татвар төлөхгүй.

**3. Практик зөвлөмж**

Зөвхөн тухайн барааны гарал үүслийн улс, тухайн барааг илгээсэн тухайн барааг хүлээн авах улсаас шалтгаалан шилжүүлэн ачихыг зөвшөөрөхгүй байж болохгүй.

**Шилжүүлэн ачихыг зөвшөөрөх**

(a) Мэдүүлэг

**4. Стандарт**

Шилжүүлэн ачих зорилгоор барааны зөвхөн нэг мэдүүлэг шаардана.

**5. Стандарт**

Шаардлагатай мэдээллийг тодорхой тусгасан арилжааны буюу тээврийн аливаа бичиг баримтыг шилжүүлэн ачих барааны мэдүүлгийн барааг тодорхойлох хэсгийн улсад хүлээн зөвшөөрч, энэ тухай үг бичиг баримтад тэмдэглэнэ.

**6. Практик зөвлөмж**

Гаалийн бүх шаардлагыг хангасан барааны хувьд арилжааны буюу тээврийн аливаа бичиг баримтыг шилжүүлэн ачих барааны мэдүүлгийн адилаар хүлээн зөвшөөрнө. Ийнхүү хүлээн зөвшөөрсөн тухай холбогдох бичиг баримтад тэмдэглэнэ.

(b) Барааг шалгах болон онцлон таних

**7. Стандарт**

Гаалийн байгууллага, шаардлагатай гэж үзвэл, шилжүүлэн ачих барааг гаргахад онцлон таних, мөн түүнийг зөвшөөрөлгүй хөндсөн эсэхийг илрүүлэх арга хэмжээг тухайн бараа орох үед авна.

(c) Хяналтын нэмэлт арга хэмжээ

**8. Стандарт**

Хэрэв гаалийн байгууллага шилжүүлэн ачихаар мэдүүлсэн барааг гаргах хугацааг тогтоодог бол тэр нь шилжүүлэн ачилт хийхэд хангалттай байна.

**9. Практик зөвлөмж**

Холбогдох этгээдийн хүсэлтээр, мөн гаалийн байгууллагаас хүлээн зөвшөөрсөн шалтгаанаар гаалийн байгууллага анхлан тогтоосон хугацаагаа сунгана.

**10. Практик зөвлөмж**

Хэрэв бусад бүх шаардлага хангагдсан гэж гаалийн байгууллага үзсэн бол, тогтоосон хугацааг баримтлан ажиллаж чадаагүй нь, төлбөл зохих гаалийн болон бусад аливаа татварыг хураан авах үндэслэл болохгүй.

(d) Зөвшөөрөгдсөн үйл ажиллагаа

**11. Практик зөвлөмж**

Холбогдох этгээдийн хүсэлтээр, мөн гаалийн байгууллагаас тавьж болох нөхцлийн дагуу, шилжүүлэн ачих барааг экспортлох ажиллагааг хөнгөвчлөх талаарх арга хэмжээг гаалийн байгууллага боломжтой бол зөвшөөрнө.

**3 дугаар бүлэг**

**БАРААГ ЭРГИЙН ДАГУУ ТЭЭВЭРЛЭХ**

**Тодорхойлолт**

Энэ Бүлгийн зорилгоор:

E1./F1.

**"Барааг эргийн дагуу тээвэрлэх горим"** гэж:

a. чөлөөт эргэлтэд байгаа бараа, болон

b. гаалийн нутаг дэвсгэрт ачиж ирсэн хөлөг онгоцноос өөр хөлөг онгоцоор тээвэрлэнэ гэсэн нөхцлөөр мэдүүлээгүй импортын барааг тухайн гаалийн нутаг дэвсгэр дэх аль нэг газраас ямар нэгэн хөлөг онгоцонд ачих, мөн гаалийн нутаг дэвсгэрийн өөр нэг газар аваачих, тэнд нь буулгах гаалийн горимыг хэлнэ.

**Зарчим**

**1. Стандарт**

Бараагийн эргийн дагуу тээвэрлэх горим нь энэ Бүлгийн заалт, мөн холбогдолтой гэж үзвэл, Ерөнхий Хавсралтын заалтаар зохицуулагдана.

**Үйлчлэх хүрээ**

**2. Стандарт**

Гаалийн байгууллага эргийн дагуу тээвэрлэх горимоор барааг хөлөг онгоцонд бусад барааны хамт нэгэн зэрэг тээвэрлэхийг зөвшөөрнө. Чингэхэд тухайн барааг ялган таних боломжтой, мөн бусад шаардлага хангагдсан байна.

**3. Практик зөвлөмж**

Гаалийн байгууллага чөлөөт эргэлтэд байгаа бөгөөд эргийн дагуу тээвэрлэх горимоор тээвэрлэж буй барааг зөвхөн хяналтын зорилгоор шаардлагатай гэж үзвэл тухайн хөлөг онгоцоор тээвэрлэж буй бусад бараанаас тусгаарлахыг шаардана.

**4. Практик зөвлөмж**

Холбогдох этгээдийн хүсэлтээр, мөн гаалийн байгууллага шаардлагатай гэж үзсэн нөхцлийн дагуу барааг эргийн дагуу тээвэрлэх горимоор эргийн дагуу аялах замдаа гадаадын боомтыг дайран өнгөрөх хөлөг онгоцонд тээвэрлэхийг гаалийн байгууллага зөвшөөрнө.

**5. Практик зөвлөмж**

Гаалийн нутаг дэвсгэрийн гадна орших нэг буюу хэд хэдэн боомтыг дайран өнгөрөх аливаа хөлөг онгоцоор эргийн дагуу тээвэрлэх горимд байгаа барааг тээвэрлэхийг зөвшөөрсөн тохиолдолд зөвхөн холбогдох этгээдийн хүсэлтээр, эсхүл нууцаар тухайн барааг авах буюу түүн дээр өөр бараа нэмэх боломжийг хаах үүднээс битүүмжлэх шаардлагатай гэж гаалийн байгууллага үзвэл уг барааг битүүмжилнэ.

**6. Практик зөвлөмж**

Хэрэв тухайн бараа анхлан уг горимоор орсон бараа мөн болох нь тогтоогдсон бол эргийн дагуу тээвэрлэх горимд байгаа барааг тээвэрлэж буй хөлөг онгоц тогтоосон маршрутаас зайлшгүй хазайх болон гаалийн нутаг дэвсгэрээс гадна орших боомтод гарцаагүй зогсох тохиолдолд гаалийн байгууллага тэр барааг эргийн дагуу тээвэрлэх горимд байгаа гэж үзнэ.

**Ачих болон буулгах**

**7. Стандарт**

Эргийн дагуу тээвэрлэх горимд байгаа барааг ачиж, буулгах зөвшөөрөгдсөн газар, мөн ачих, буулгах хугацааг үндэсний хууль тогтоомжоор тогтооно.

**8. Практик зөвлөмж**

Зөвхөн чөлөөт эргэлтэд байгаа бөгөөд эргийн дагуу тээвэрлэх горимд байгаа бараа тээвэрлэж буй хөлөг онгоцны хувьд, холбогдох этгээдийн хүсэлтээр тухайн барааг хаана ч, хэдийд ч ачиж, буулгахыг гаалийн байгууллага зөвшөөрнө.

**9. Практик зөвлөмж**

Тухайн хөлөг онгоц мэдүүлээгүй буюу гаалийн өөр горимд байгаа импортын бараа бас тээвэрлэж байгааг үл харгалзан, эргийн дагуу тээвэрлэх горимд байгаа барааг эсхүл зорилгоор ердийн тогтоосон газраас өөр газар руу тээвэрлэхийг холбогдох этгээдийн хүсэлтээр гаалийн байгууллага зөвшөөрнө. Үүнтэй холбогдуулан төлбөл зохих аливаа төлбөр нь холбогдох үйлчилгээний хөлстэй ойролцоо байна.

**10. Практик зөвлөмж**

Эргийн дагуу тээвэрлэх горимд байгаа барааг тээвэрлэж буй тээврийн хэрэгсэл аяллын маршрутаасаа хазайсан тохиолдолд гаалийн байгууллага холбогдох этгээдийн хүсэлтийг үндэслэн уг барааг дээрх горимын дагуу анх төлөвлөснөөс өөр газарт буулгахыг зөвшөөрнө. Үүнтэй холбогдуулан төлбөл зохих аливаа төлбөр нь холбогдох үйлчилгээний хөлстэй ойролцоо байна.

**11. Стандарт**

Хэрэв эргийн дагуу тээвэрлэх горимд байгаа барааны тээвэрлэлт осол буюу давагдашгүй хүчин зүйлийн улмаас тасалдсан бол гаалийн байгууллага тухайн бараа зөвшөөрөгдөөгүй эргэлтэд орохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч, уг аяллыг зогсоосон осол буюу бусад нөхцөл байдлын талаар гаалийн эсхүл эрх бүхий бусад байгууллагад мэдэгдэхийг хөлгийн дарга буюу өөр холбогдох этгээдээс шаардана.

**12. Стандарт**

Хэрэв эргийн дагуу тээвэрлэх горимд байгаа бараа тээвэрлэж буй хөлөг онгоц мэдүүлээгүй буюу гаалийн өөр нэгэн горимд байгаа импортын бараа тээвэрлэж байгаа бол эргийн дагуу тээвэрлэх горимд байгаа барааг тухайн хөлөг онгоц ачих буюу буулгахаар тогтоосон газар ирмэгц даруй ачих буюу буулгахыг гаалийн байгууллага зөвшөөрнө.

**Бичиг баримтын бүрдүүлэлт**

**13. Стандарт**

Гаалийн байгууллага тухайн хөлөг онгоцны талаарх мэдээлэл, эргийн дагуу тээвэрлэх горимоор тээвэрлэх барааны жагсаалт, тэдгээрийг гаалийн нутаг дэвсгэрт буулгах нэг буюу хэд хэдэн газрын нэрсийг багтаасан зөвхөн нэг бичиг баримт үзүүлэхийг хөлгийн дарга буюу өөр холбогдох этгээдээс шаардана. Энэхүү бичиг баримтыг гаалийн байгууллага нэгэнт баталгаажуулсан бол тэр нь эргийн дагуу тээвэрлэх горимд байгаа барааг тээвэрлэх зөвшөөрлийн бичиг болно.

**14. Практик зөвлөмж**

Гаалийн байгууллага эргийн дагуу тээвэрлэх горимд байгаа бараа тээвэрлэх ерөнхий зөвшөөрлийг тогтоосон боомтуудын хооронд тогтмол аялал/худалдаа хийдэг хөлөг онгоцонд олгоно.

**15. Практик зөвлөмж**

Хэрэв аль нэгэн хөлөг онгоцонд ерөнхий зөвшөөрөл олгосон бол гаалийн байгууллага зөвхөн эргийн дагуу тээвэрлэх горимоор тээвэрлэх барааны жагсаалтыг тухайн барааг ачуулахын өмнө шаардана.

**16. Практик зөвлөмж**

Тусгайлсан зөвшөөрөл бүхий хөлөг онгоцноос бараа буулгахтай холбогдуулан гаалийн байгууллага зөвхөн тухайн боомтод буулгах барааны жагсаалт бүхий зөвшөөрлийн бичгийн нэг

хувийг гаргаж үзүүлэхийг хөлгийн дарга буюу өөр холбогдох этгээдээс шаардана. Ерөнхий зөвшөөрөл бүхий хөлөг онгоцны хувьд зөвхөн буулгасан барааны жагсаалтыг шаардана.

**Баталгаа**

**17. Стандарт**

Чөлөөт эргэлтэд байгаа бөгөөд хэрэв экспортлоход экспортын гаалийн болон бусад татвартай, эсхүл экспортын хориг, хязгаар тогтоосон барааг эргийн дагуу тээвэрлэх горимоор тээвэрлэхэд зөвхөн гаалийн байгууллага зайлшгүй шаардлагатай гэж үзсэн тохиолдолд баталгаа гаргана.

**ТУСГАЙ ХАВСРАЛТ F**

**1 дүгээр бүлэг**

**ДОТООДОД БОЛОВСРУУЛАХ**

**Тодорхойлолт**

Энэхүү Бүлгийн зорилгоор:

E1./F3.

**"эцсийн бүтээгдэхүүн"** гэж дотоодод боловсруулах горим ашиглахыг зөвшөөрсөн барааны үйлдвэрлэл, боловсруулалт, эсхүл засварын үр дүнд бий болсон бүтээгдэхүүнийг хэлнэ;

E2./F1.

**"адил бараа"** гэж тодорхойлолт, чанар, техникийн үзүүлэлтийн хувьд дотоодод боловсруулах горимд байгаа бараатай ижил бөгөөд түүнийг орлох дотоодын буюу импортын барааг хэлнэ;

E3./F2.

**"дотоодод боловсруулах"** гэж тодорхой барааг үйлдвэрлэл, боловсруулалт, эсхүл засварт оруулж, дараа нь экспортлох үндсэн дээр тухайн барааг импортын гаалийн болон бусад татвараас болзол тавьж чөлөөлөн гаалийн нутаг дэвсгэрт оруулах гаалийн горимыг хэлнэ.

**Зарчим**

**1. Стандарт**

Дотоодод боловсруулах нь энэ Бүлгийн заалт болон холбогдолтой гэж үзвэл, Ерөнхий Хавсралтын холбогдох заалтаар зохицуулагдана.

**Үйлчлэх хүрээ**

**2. Стандарт**

Дотоодод боловсруулахаар оруулсан барааг импортын гаалийн болон бусад татвараас болзол тавьж бүрэн чөлөөлнө. Гэвч, дотоодод боловсруулахаар оруулсан барааны үйлдвэрлэл буюу боловсруулалтаас гарсан хаягдал зэрэг аливаа бүтээгдэхүүнийг экспортлоогүй, эсхүл түүнийг арилжааны үнэ цэнэгүйд тооцож үзээгүй бол түүнээс импортын гаалийн болон бусад татварыг хураан авч болно.

**3. Стандарт**

Дотоодод боловсруулахыг зөвхөн гадаадаас шууд импортолсон бараагаар хязгаарлахгүй, бас гаалийн өөр горимд байгаа бараанд зөвшөөрч болно.

**4. Практик зөвлөмж**

Зөвхөн тухайн барааны гарал үүслийн улс, тухайн барааг илгээсэн буюу тухайн барааг хүлээн авах улсаас шалтгаалан дотоодод боловсруулахыг зөвшөөрөхгүй байж болохгүй.

**5. Стандарт**

Дотоодод боловсруулахаар бараа оруулах эрх нь тухайн импортын барааны эзнээр хязгаарлагдахгүй.

**6. Практик зөвлөмж**

Хэрэв гадаадад үүсэн байгуулагдсан аливаа этгээдтэй байгуулсан гэрээний биелэлтийн явцад ашиглах барааг тухайн этгээд нийлүүлж байгаа бол тодорхойлолт, чанар, техникийн үзүүлэлтийн хувьд түүнтэй ижил бараа импортлогч улсын гаалийн нутаг дэвсгэрт бий гэдэг үндэслэлээр дотоодод боловсруулахыг зөвшөөрөхгүй байж болохгүй.

**7. Практик зөвлөмж**

Тухайн импортын бараа холбогдох эцсийн бүтээгдэхүүнд шингэсэн эсэхийг тодорхойлох боломж нь дараахь тохиолдолд дотоодод боловсруулахад тавигдах зайлшгүй шаардлага болохгүй:

(a) тухайн барааг дараахь замаар онцлон таниж болох:

- эцсийн бүтээгдэхүүний орц, үйлдвэрлэлийн шат дамжлагын талаар дэлгэрэнгүй мэдээлэл авах; эсхүл

- үйлдвэрлэлийн явцад гаалийн хяналт тавих;

эсхүл

(b) тодорхойлолт, чанар, техникийн үзүүлэлтийн хувьд дотоодод боловсруулах горимд оруулсан бараатай ижил бараа ашиглан гаргаж авсан бүтээгдэхүүнийг экспортолсноор уг горим дуусгавар болсон.

**Барааг дотоодод боловсруулах горимд оруулах**

(a) Дотоодод боловсруулах горимд оруулах зөвшөөрөл

**8. Стандарт**

Дотоодод боловсруулахад шаардагдах урьдчилсан зөвшөөрөл олгох тохиолдлууд болон тийм зөвшөөрөл олгох байгууллагыг үндэсний хууль тогтоомжоор тогтооно.

**9. Стандарт**

Дотоодод боловсруулах зөвшөөрөлд дотоодод боловсруулахад зөвшөөрөгдсөн үйл ажиллагааг хэрхэн явуулах хэлбэрийг зааж өгнө.

**10. Практик зөвлөмж**

Хэрэв барааг импортолсны дараа дотоодод боловсруулах хүсэлт гаргасан бөгөөд тэр нь зөвшөөрөл олгох шаардлагыг хангаж байвал уг зөвшөөрлийг нөхөн олгоно.

**11. Практик зөвлөмж**

Дотоодод боловсруулах байнгын үйл ажиллагаа эрхэлдэг этгээдэд, түүний хүсэлтийг үндэслэн, тийм үйл ажиллагааг хамарсан ерөнхий зөвшөөрөл олгоно.

**12. Стандарт**

Хэрэв дотоодод боловсруулах горимд орсон барааг үйлдвэрлэл буюу боловсруулалтад

оруулах бол эрх бүхий байгууллагууд тухайн үйлдвэрлэл явуулах буюу боловсруулалт хийх бодит нөхцөл байдалд тулгуурлан холбогдох үйл ажиллагааны бүтээмжийн хувь хэмжээг тогтоох буюу тохиролцоно. Тийнхүү тогтоосон буюу тохиролцсон хувь хэмжээг үндэслэн төрөл бүрийн эцсийн бүтээгдэхүүний тодорхойлолт, чанар, тоо хэмжээг зааж өгнө.

**13. Практик зөвлөмж**

Хэрэв дотоодод боловсруулах үйл ажиллагаа нь дараах нөхцлийг хангаж байвал:

- тогтмол үзүүлэлт бүхий бараанд хамааралтай;
- техникийн тодорхой тогтоосон нөхцөлд тохируулан явуулах боломжтой; мөн
- тогтмол нэг чанарын эцсийн бүтээгдэхүүн гаргадаг бол эрх бүхий байгууллагууд тухайн үйл ажиллагаанд хамааралтай стандарт хувь хэмжээ тогтооно.

b) Онцлон таних арга хэмжээ

**14. Стандарт**

Дотоодод боловсруулах барааг онцлон танихтай холбогдсон шаардлагыг гаалийн байгууллага тогтооно. Тийм шаардлага тавихдаа уг барааны мөн чанар, тухайн үйл ажиллагааны онцлог, мөн холбогдох ашиг сонирхлуудын ач холбогдлыг зохих ёсоор анхаарна.

**Бараа гаалийн нутаг дэвсгэрт байх**

**15. Стандарт**

Гаалийн байгууллага дотоодод боловсруулах хугацааг тохиолдол бүрээр тогтооно.

**16. Практик зөвлөмж**

Холбогдох этгээдийн хүсэлтээр, мөн гаалийн байгууллагаас хүлээн зөвшөөрсөн шалтгаанаар гаалийн байгууллага анх тогтоосон хугацааг сунгана.

**17. Практик зөвлөмж**

Тухайн импортын бараа болон холбогдох эцсийн бүтээгдэхүүнийг өмчлөх эрх гуравдагч этгээдэд шилжих тохиолдолд, зөвшөөрөл авсан этгээдийн хүлээх хариуцлагыг уг этгээдэд ногдуулах нөхцлөөр дотоодод боловсруулах ажиллагааг үргэлжлүүлэх тухай заалт байна.

**18. Практик зөвлөмж**

Эрх бүхий байгууллагууд дотоодод боловсруулах байр, тоног төхөөрөмжөөр хангаж өгсөн этгээдээс өөр аль нэг этгээд боловсруулалтын үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрнө. Дотоодод боловсруулах байр, тоног төхөөрөмжөөр хангаж өгсөн этгээд тухайн үйл ажиллагааны бүхий л хугацааны турш, холбогдох зөвшөөрөлд заасан нөхцлийг хангаж биелүүлэх талаар гаалийн байгууллагын өмнө үүрэг хүлээсэн бол дотоодод боловсруулах горимд орсон барааны өмчлөх эрхийг шилжүүлэх шаардлагагүй.

**19. Стандарт**

Дотоодод боловсруулах горимд оруулсан барааг импортолсноос өөр гаалийн байгууллагаар эцсийн бүтээгдэхүүн болгон экспортлохыг зөвшөөрсөн заалт байна.

**Барааг дотоодод боловсруулахыг дуусгавар болгох**

(a) Экспортлох

**20. Стандарт**

Эцсийн бүтээгдэхүүнийг нэг буюу хэд хэдэн удаагийн ачилтаар экспортолсноор дотоодод боловсруулах горимыг дуусгавар болгохыг зөвшөөрсөн заалт байна.

**21. Стандарт**

Эрх бүхий байгууллагууд, холбогдох этгээдийн хүсэлтээр, дотоодод боловсруулах горимыг дуусгавар болгож, холбогдох барааг импортолсон байдлаар нь буцаан экспортлохыг зөвшөөрнө.

(b) Захиран зарцуулах бусад аргууд

**22. Практик зөвлөмж**

Тухайн импортын бараа болон холбогдох эцсийн бүтээгдэхүүнийг, тухайн тохиолдол бүрд хамаарах нөхцөл, журмын дагуу гаалийн өөр горимд шилжүүлэх замаар дотоодод боловсруулах горимыг хойшлуулах, эсхүл дуусгавар болгох тухай заалт байна.

**23. Практик зөвлөмж**

Эцсийн бүтээгдэхүүнийг экспортлоогүй тохиолдолд хамаарах импортын гаалийн болон бусад татварын хэмжээ нь дотоодод боловсруулах горимд оруулсан холбогдох импортын бараанд хамаарах импортын болон бусад татварын хэмжээнээс илүүгүй байна гэдгийг үндэсний хууль тогтоомжид заана.

**24. Стандарт**

Холбогдох барааны шинж чанарын улмаас ашиглагдаж үгүй болсон барааны хувьд, тийнхүү үгүй болсныг гаалийн байгууллага зохих ёсоор тогтоосон бол эцсийн бүтээгдэхүүнийг экспортлох бүрд дотоодод боловсруулах горимыг дуусгавар болгох тухай заалт байна.

**25. Практик зөвлөмж**

Адил бараа ашиглан гаргаж авсан бүтээгдэхүүнийг энэ Бүлгийн хувьд эцсийн бүтээгдэхүүн гэж үзнэ (адил бараагаар орлуулах).

**26. Практик зөвлөмж**

Хэрэв адил бараагаар орлуулахыг зөвшөөрсөн бол дотоодод боловсруулах горимд оруулах барааг импортлохоос өмнө эцсийн бүтээгдэхүүн болгон экспортлохыг гаалийн байгууллага зөвшөөрөх ёстой.

**2 дугаар бүлэг**

**ГАДААДАД БОЛОВСРУУЛАХ**

**Тодорхойлолт**

Энэхүү Бүлгийн зорилгоор:

E1./F2.

**"эцсийн бүтээгдэхүүн"** гэж гадаадад боловсруулах горим ашиглахыг зөвшөөрсөн барааны үйлдвэрлэл, боловсруулалт, эсхүл засварын үр дүнд бий болсон бөгөөд гадаадад гаргаж авсан бүтээгдэхүүнийг хэлнэ;

E2./F1.

**"гадаадад боловсруулах"** гэж гаалийн нутаг дэвсгэрт чөлөөт эргэлтэд байгаа барааг

гадаадад үйлдвэрлэл явуулах, боловсруулалт, эсхүл засвар хийх зорилгоор түр экспортолж, дараа нь импортын гаалийн болон бусад татвараас бүрэн буюу хэсэгчлэн чөлөөлж буцаан импортлох гаалийн горимыг хэлнэ.

**Зарчим**

**1. Стандарт**

Гадаадад боловсруулах горимыг энэ Бүлгийн заалт болон холбогдолтой гэж үзвэл, Ерөнхий Хавсралтын холбогдох заалтаар зохицуулна.

**Үйлчлэх хүрээ**

**2. Практик зөвлөмж**

Гадаадад боловсруулахыг тухайн барааг зөвхөн тухайлсан нэг улсад үйлдвэрлэх, боловсруулах, засварлах ёстой гэдэг үндэслэлээр зөвшөөрөхгүй байж болохгүй.

**3. Стандарт**

Гадаадад боловсруулахаар түр экспортлохыг тухайн барааны эзнээр хязгаарлахгүй.

**Барааг гадаадад боловсруулах горимд оруулах**

(a) Барааг түр экспортлохоос өмнөх ажиллагаа

**4. Стандарт**

Гадаадад боловсруулахад шаардагдах урьдчилсан зөвшөөрөл олгох тохиолдлууд болон тийм зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагыг үндэсний хууль тогтоомжоор тогтооно. Тийм тохиолдлууд нь аль болох цөөн байна.

**5. Практик зөвлөмж**

Гадаадад боловсруулах байнгын үйл ажиллагаа эрхэлдэг этгээдэд, түүний хүсэлтийг үндэслэн, тийм үйл ажиллагааг хамарсан ерөнхий зөвшөөрөл олгоно.

**6. Практик зөвлөмж**

Эрх бүхий байгууллагууд шаардлагатай гэж үзвэл, эсхүл тухайн үйл ажиллагааг хөнгөвчилнө гэж үзвэл, гадаадад боловсруулах үйл ажиллагааны бүтээмжийн хувь хэмжээг тогтооно. Тийнхүү тогтоосон хувь хэмжээг үндэслэн төрөл бүрийн эцсийн бүтээгдэхүүний тодорхойлолт, чанар, тоо хэмжээг зааж өгнө.

(b) Онцлон таних арга хэмжээ

**7. Стандарт**

Гадаадад боловсруулах барааг онцлон танихтай холбогдсон шаардлагыг гаалийн байгууллага тогтооно. Тийм шаардлага тавихдаа уг барааны мөн чанар, тухайн үйл ажиллагааны онцлог, мөн холбогдох ашиг сонирхлуудын ач холбогдлыг зохих ёсоор анхаарна.

**Барааг гаалийн нутаг дэвсгэрийн гадна байлгах**

**8. Стандарт**

Гаалийн байгууллага гадаадад боловсруулах хугацааг тохиолдол бүрээр тогтооно.

**9. Практик зөвлөмж**

Холбогдох этгээдийн хүсэлтээр болон гаалийн байгууллагаас хүлээн зөвшөөрсөн шалтгаанаар, гаалийн байгууллага анх тогтоосон хугацааг сунгана.

**Эцсийн бүтээгдэхүүнийг импортлох**

**10. Стандарт**

Гадаадад боловсруулахаар тухайн барааг түр экспортолсноос өөрөөр гаалийн байгууллагаар дамжуулан эцсийн бүтээгдэхүүнийг импортлохыг зөвшөөрсөн заалт байна.

**11. Стандарт**

Эцсийн бүтээгдэхүүнийг нэг буюу хэд хэдэн удаагийн ачилтаар импортлохыг зөвшөөрсөн заалт байна.

**12. Стандарт**

Холбогдох этгээдийн хүсэлтээр, гадаадад боловсруулахаар түр экспортолсон бараа хэрэв тухайн улсад буцаж ирсэн бол импортын гаалийн болон бусад татвараас чөлөөлж, буцаан импортлохыг эрх бүхий байгууллага зөвшөөрнө.

Ийм чөлөөлөлт нь тухайн барааг гадаадад боловсруулахаар түр экспортлохтой холбогдуулан буцаан олгосон буюу гүйвүүлсэн импортын гаалийн болон бусад татварт хамаарахгүй.

**13. Стандарт**

Гадаадад боловсруулахаар түр экспортолсон барааг буцаан импортлохыг үндэсний хууль тогтоомжид заагаагүй бол тухайн тохиолдолд хамаарах нөхцөл, ажиллагааг сахин мөрдөж, барааг бүрмөсөн гаргахаар мэдүүлсэн бол гадаадад боловсруулах горимыг дуусгавар болгох тухай заалт байна.

**Эцсийн бүтээгдэхүүнд хамаарах гаалийн болон бусад татвар**

**14. Стандарт**

Эцсийн бүтээгдэхүүнийг дотоодын хэрэглээнд зориулан оруулахад импортын гаалийн болон бусад татвараас ямар хэмжээнд чөлөөлөх, мөн тухайн чөлөөлөлтийг тооцох аргыг үндэсний хууль тогтоомжид заана.

**15. Стандарт**

Эцсийн бүтээгдэхүүнд хамаарах импортын гаалийн болон бусад татварын чөлөөлөлт нь тухайн барааг гадаадад боловсруулахаар түр экспортлохтой холбогдуулан буцаан олгосон буюу гүйвүүлсэн импортын гаалийн болон бусад татварт хамаарахгүй.

**16. Практик зөвлөмж**

Хэрэв гадаадад боловсруулахаар түр экспортолсон бараанд гадаадад үнэ төлбөргүй засвар хийсэн бол үндэсний хууль тогтоомжид заасан нөхцлийн дагуу холбогдох барааг импортын гаалийн болон бусад татвараас бүрэн чөлөөлж, буцаан импортлох тухай заалт байна.

**17. Практик зөвлөмж**

Хэрэв эцсийн бүтээгдэхүүнийг дотоодын хэрэглээнд зориулан оруулахаар мэдүүлэхээс өмнө гаалийн өөр горимд оруулсан бол импортын гаалийн болон бусад татвараас чөлөөлнө.

**18. Практик зөвлөмж**

Хэрэв эцсийн бүтээгдэхүүний өмчлөх эрхийг түүнийг дотоодын хэрэглээнд зориулан

оруулахаас өмнө шилжүүлсэн бол импортын гаалийн болон бусад татвараас чөлөөлнө.

3 дугаар бүлэг
ТАТВАР БУЦААН ОЛГОХ
Тодорхойлолт

Энэхүү Бүлгийн зорилгоор:

E1./F1.

**"татвар буцаан олгох"** гэж импортын гаалийн болон бусад татварыг татвар буцаан олгох горимын дагуу буцаан төлөхийг хэлнэ;

E2./F3

**"татвар буцаан олгох горим"** гэж бараа экспортлоход тухайн бараанд, эсхүл түүнийг бүрдүүлж байгаа буюу түүнийг үйлдвэрлэхэд ашиглаж үгүй болсон материалд төлсөн импортын гаалийн болон бусад татварыг (бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн) буцаан олгох гаалийн горимыг хэлнэ;

E3.F1/.

**"адил бараа"** гэж тодорхойлолт, чанар, техникийн үзүүлэлтийн хувьд татвар буцаан олгох горимд байгаа бараатай ижил бөгөөд түүнийг орлох дотоодын буюу импортын барааг хэлнэ.

Зарчим

**1. Стандарт**

Татвар буцаан олгох горимыг энэхүү Бүлгийн заалт болон холбогдолтой гэж үзвэл, Ерөнхий Хавсралтын холбогдох заалтаар зохицуулна.

Үйлчлэх хүрээ

**2. Стандарт**

Татвар буцаан олгох тохиолдлуудыг үндэсний хууль тогтоомжид заана.

**3. Практик зөвлөмж**

Импортын гаалийн болон бусад татвар төлсөн барааг экспортын бараа үйлдвэрлэхэд ашигласан адил бараагаар орлуулсан тохиолдолд татвар буцаан олгох горимыг хэрэглэх тухай заалтыг үндэсний хууль тогтоомжид тусгана.

Бүрдүүлэх нөхцөл

**4. Стандарт**

Импортлогч барааг дотоодын хэрэглээнд зориулан оруулах үедээ тухайн барааг экспортлоход татвараа буцаан нэхэмжлэх зорилготой байснаа мэдэгдээгүй гэдэг ганц үндэслэлээр гаалийн байгууллага татвар буцаан олгохоос татгалзахгүй. Үүнтэй нэгэн адил, тийм мэдэгдлийг бараа оруулах үед хийсэн бол тухайн барааг заавал экспортлох албагүй.

Бараа гаалийн нутаг дэвсгэрт
байх хугацаа

**5. Практик зөвлөмж**

Тухайн барааг экспортлох хугацааг тогтоосон бөгөөд түүнээс хойш татвар буцаан олгож болохгүй бол холбогдох этгээдийн хүсэлтээр, мөн гаалийн байгууллагаас хүлээн зөвшөөрсөн шалтгаанаар уг хугацааг сунгана.

**6. Практик зөвлөмж**

Хугацаа тогтоосон бөгөөд түүнээс хойш татвар буцаан олгох хүсэлтийг хүлээн авахгүй бол гаалийн байгууллагаас хүлээн зөвшөөрсөн худалдааны буюу бусад шалтгаанаар уг хугацааг сунгах тухай заалт байна.

Татварыг буцаан төлөх

**7. Стандарт**

Холбогдох нэхэмжлэлийг шалгасаны дараа татварыг нэн даруй буцаан төлнө.

**8. Практик зөвлөмж**

Татвар буцаан төлөхдөө электрон сүлжээ ашиглан гүйвүүлга хийх талаар үндэсний хууль тогтоомжид заана.

**9. Практик зөвлөмж**

Тухайн барааг гаалийн аль нэгэн агуулахад хадгалах, эсхүл түүнийг чөлөөт бүсэд оруулах, дараа нь экспортлох нөхцлөөр татварыг бас буцаан олгоно.

**10. Практик зөвлөмж**

Хэрэв тийнхүү хүсэлт тавьсан бол гаалийн байгууллага тодорхой хугацааны турш экспортлох барааны татварыг тогтмол хугацаагаар буцаан олгоно.

4 дүгээр бүлэг
БАРААГ ДОТООДЫН ХЭРЭГЛЭЭНД
ЗОРИУЛАН БОЛОВСРУУЛАХ
Тодорхойлолт

Энэхүү Бүлгийн зорилгоор:

E1./F1.

**"Барааг дотоодын хэрэглээнд зориулан боловсруулах"** гэж импортын барааг дотоодын хэрэглээнд зориулан оруулахаар бүрдүүлэлт хийлгэхээс өмнө, гаалийн хяналтын дор үйлдвэрлэл, боловсруулалт буюу ажил үйлчилгээнд оруулж, түүнээс гаргаж авсан бүтээгдэхүүнд хамаарах импортын гаалийн болон бусад татварын хэмжээг тухайн импортын бараанд ногдох татварын хэмжээнээс багасгаж болох гаалийн горимыг хэлнэ;

Зарчим

**1. Стандарт**

Барааг дотоодын хэрэглээнд зориулан оруулахаар боловсруулах горимыг энэхүү Бүлгийн заалт болон холбогдолтой гэж үзвэл, Ерөнхий Хавсралтын холбогдох заалтаар зохицуулна.

**2. Стандарт**

Барааг дотоодын хэрэглээнд зориулан оруулахаар боловсруулах зөвшөөрлийг дараахь нөхцөлд олгоно:

- барааг дотоодын хэрэглээнд зориулан оруулахаар боловсруулсны үр дүнд бий болсон бүтээгдэхүүн тухайн импортын бараанаас үүсэлтэй болохыг гаалийн байгууллага тогтоох боломжтой байх; болон
- тухайн үйлдвэрлэл, боловсруулалт ажил үйлчилгээ хийгдсэний дараа холбогдох барааг анхны шинж байдалд нь буцаан оруулах боломжгүй байх.

Үйлчлэх хүрээ

**3. Стандарт**

Дотоодын хэрэглээнд зориулан оруулахаар боловсруулахыг зөвшөөрсөн барааны төрөл зүйл, уг горимоор зөвшөөрөгдсөн үйл ажиллагаа үндэсний хууль тогтоомжоор зохицуулна.

**4. Стандарт**

Барааг дотоодын хэрэглээнд зориулан оруулахаар боловсруулах нь зөвхөн гадаадаас шууд импортолсон бараагаар хязгаарлагдахгүй, гаалийн өөр горимд байгаа бараанд мөн хамаарна.

**5. Стандарт**

Барааг дотоодын хэрэглээнд зориулан боловсруулах эрх тухайн импортын барааны эзэнээр хязгаарлагдахгүй.

**6. Практик зөвлөмж**

Барааг дотоодын хэрэглээнд зориулан боловсруулах байнгын үйл ажиллагаа эрхэлдэг этгээдэд хүсэлтийг нь үндэслэн, тийм үйл ажиллагааг хамарсан ерөнхий зөвшөөрөл олгоно.

**Барааг дотоодын хэрэглээнд зориулан боловсруулах горим дуусгавар болгох**

**7. Стандарт**

Барааг дотоодын хэрэглээнд зориулан боловсруулах горим нь уг боловсруулалтын үр дүнд бий болсон бүтээгдэхүүнийг дотоодын хэрэглээнд зориулан оруулахаар бүрдүүлэлт хийлгэснээр дуусгавар болно.

**8. Стандарт**

Хэрэв үйлдвэрлэл, боловсруулалт, эсхүл ажил үйлчилгээний үр дүнд бий болсон бүтээгдэхүүнийг тухайн тохиолдол бүрд хамаарах нөхцөл, ажиллагааны дагуу гаалийн өөр горимын дагуу оруулах тохиолдолд гаалийн байгууллага зүйтэй гэж үзсэн нөхцөлд, мөн холбогдох этгээдийн хүсэлтээр уг горимыг дуусгавар болгохыг нотолно.

**9. Стандарт**

Барааг дотоодын хэрэглээнд зориулан боловсруулсны үр дүнд бий болсон аливаа үлдэгдэл, хаягдлыг хэрэв дотоодын хэрэглээнд зориулан оруулахаар бүрдүүлэлт хийлгэвэл тийм үлдэгдэл буюу хаягдлыг тухайн байдлаар нь импортлоход хамаарах импортын гаалийн болон бусад татвар ногдуулна.

**ТУСГАЙ ХАВСРАЛТ G**

**1 дүгээр бүлэг**

**ТҮР ХУГАЦААГААР ОРУУЛАХ**

**Тодорхойлолт**

Энэхүү Бүлгийн зорилгоор:

E1./F1.

**"Түр хугацаагаар оруулах горим"** гэдэг нь импортын татварыг төлөхөөс бүтэн, эсхүл хэсэгчлэн чөлөөлөх нөхцлөөр гаалийн нутаг дэвсгэрт тодорхой бараа оруулах гаалийн бүрдүүлэлтийн горимыг хэлнэ. Ийм барааг тусгай зориулалтаар импортлох бөгөөд тогтоосон хугацаанд буцаан экспортлох болзолтойгоор оруулах ба ингэхдээ ашиглалтаас үүсэх хэвийн элэгдэл хорогдлоос өөр ямар нэгэн өөрчлөлт ороогүй байна.

**Зарчим**

**1. Стандарт**

Барааг түр хугацаагаар оруулах горимыг энэхүү Бүлгийн заалт болон холбогдолтой гэж үзвэл, Ерөнхий Хавсралтын холбогдох заалтаар зохицуулна.

**Үйлчлэх хүрээ**

**2. Стандарт**

Үндэсний хууль тогтоомжоор түр хугацаагаар оруулах нөхцлүүдийг тогтооно.

**3. Стандарт**

Үндэсний хууль тогтоомжийн дагуу түр хугацаагаар оруулах барааг импортын гаалийн болон бусад татвараас зөвхөн хэсэгчлэн чөлөөлөх тухай заасанаас бусад тохиолдолд түр хугацаагаар оруулсан барааг гаалийн татвараас бүрэн чөлөөлнө.

**4. Стандарт**

Түр хугацаагаар оруулах горимыг гадаадаас шууд оруулсан бараа төдийгүй мөн гаалийн өөр горимоор бүрдүүлэлт хийсэн бараанд хэрэглэж болно.

**5. Практик зөвлөмж**

Барааг түр хугацаагаар оруулахдаа гарал үүслийн улс орон, барааг ачуулсан орон болон барааг хүлээн авч байгаа улсын аль алиныг үл хамааран оруулна.

**6. Стандарт**

Түр хугацаагаар оруулсан бараанд гаалийн нутаг дэвсгэр дээр байлган хадгалахад шаардагдах үйлчилгээ хийж болно.

**Түр хугацаагаар оруулахын өмнөх ажиллагаа**

**7. Стандарт**

Барааг түр хугацаагаар оруулахад урьдчилсан зөвшөөрөл шаардагдах тохиолдлыг үндэсний хууль тогтоомжоор заах бөгөөд ийм зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагыг тогтооно. Тийм тохиолдолууд аль болох бага гарна.

**8. Практик зөвлөмж**

Гаалийн байгууллага нь барааг түр хугацаагаар оруулах нөхцлийг хангасан тодорхой гаалийн газраар бараагг оруулахыг шаардана.

**9. Практик зөвлөмж**

Тухайн барааг дараа нь буцаан экспортлох талаар ямар нэгэн эргэлзээ байхгүй тохиолдолд гаалийн байгууллага бичгээр үйлдсэн барааны мэдүүлэггүйгээр түр хугацаагаар оруулах зөвшөөрөл олгоно.

**10. Практик зөвлөмж**

Хэлэлцэн тохирогч талууд барааг түр хугацаагаар оруулахтай холбогдсон олон улсын эрхийн баримт бичигт нэгдэх боломжийн талаар нухацтай судлан, олон улсын байгууллагаас гаргасан бичиг баримт, баталгаа хүлээн зөвшөөрч үндэсний гаалийн бичиг баримт, баталгааг нийцүүлэх талаар авч үзнэ.

**Онцлон таних арга хэмжээ**

**11. Стандарт**

Барааг түр хугацаагаар оруулах нь түр оруулах хугацаа дуусмагц гаалийн байгууллага уг бараагг онцлон таних боломжтой байх нөхцөлтэй байна.

**12. Практик зөвлөмж**

Түр хугацаагаар оруулсан барааг онцлон таних зорилгоор гаалийн байгууллага онцлон таних

арилжааны хэрэгслийг хангалтгүй гэж үзвэл өөрийн онцлон таних арга хэмжээг авна.

**Буцаан экспортлох хугацаа**

**13. Стандарт**

Гаалийн байгууллага нь тохиолдол бүрт барааг түр хугацаагаар оруулах хугацааны хязгаарлалтыг тогтооно.

**14. Практик зөвлөмж**

Холбогдох этгээдийн хүсэлтээр болон гаалийн байгууллага шаардлагатай гэж үзсэн тохиолдолд, гаалийн байгууллага анх тогтоосон хугацааг сунгаж болно.

**15. Практик зөвлөмж**

Хувь хүн шүүхэд гомдол гаргасны улмаас хурааснаас бусад тохиолдолд барааг хураан авсан бол түр хугацаагаар оруулсан барааг буцаан экспортлож болохгүй бөгөөд бараа хураагдсан хугацаанд буцаан экспортлохыг хойшлуулна.

**Түр хугацаагаар оруулахыг шилжүүлэх**

**16. Практик зөвлөмж**

Дараахь тохиолдолд барааг түр хугацаагаар оруулах зөвшөөрлийг бусад этгээдэд хүсэлтээр нь, шилжүүлэх бөгөөд тийм бусад этгээд нь:

(a) тогтоосон нөхцлийг хангасан; болон

(b) барааг түр хугацаагаар оруулах зөвшөөрөл авсан этгээдийн хүлээх хариуцлагыг зөвшөөрсөн.

**Түр хугацаагаар оруулахыг зогсоох**

**17. Стандарт**

Түр хугацаагаар оруулсан барааг анх импортлосноос өөр гаалийн газраар дамжуулан буцаан экспортлохыг зөвшөөрнө.

**18. Стандарт**

Түр хугацаагаар оруулсан барааг нэг буюу хэд хэдэн хэсэг болгон буцаан экспортлохыг зөвшөөрнө.

**19. Практик зөвлөмж**

Тухайн тохиолдол бүрт хэрэглэж болох нөхцөл, ажиллагаанд нийцүүлж гаалийн бусад горимын дагуу импортолсон барааг шилжүүлэн түр хугацаагаар оруулах зөвшөөрлийн хугацааг хойшлуулах, эсхүл зогсоох, цуцлах заалтыг журмаар тогтооно.

**20. Практик зөвлөмж**

Барааг түр хугацаагаар оруулах үед хүчин төгөлдөр үйлчилж байсан хориг, эсхүл хязгаарлалт нь түр хугацаагаар оруулах зөвшөөрлийн бичиг баримт хүчинтэй байх хугацаанд хүчингүй болбол гаалийн байгууллага уг барааг дотоодын хэрэглээнд зориулан бүрдүүлэлт хийлгэх хүчингүй болгох хүсэлтийг хүлээн авна.

**21. Практик зөвлөмж**

Хэрэв баталгааг бэлэн мөнгөөр хийсэн, түүнчлэн хэрэв уг барааг гаалийн газраар дамжуулан импортлоогүй гэх тохиолдолд тухайн буцаан экспортлохдоо дамжуулсан гаалийн газарт уг мөнгийг буцаан төлөх тухай заалт оруулна.

**Барааг түр хугацаагаар оруулах тохиолдол**

(a) Импортын гаалийн болон бусад татвараас бүрэн чөлөөлөх нөхцөл

**22. Практик зөвлөмж**

1990 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн Барааг түр хугацаагаар оруулах тухай Конвенц (Стамбулын Конвенц)-ийн дараахь Хавсралтуудад заасан бараанд түр хугацаагаар оруулах үед импортын гаалийн болон бусад татвараас бүрэн чөлөөлөх нөхцлийг олгоно:

1. Хавсралт B.1-д дурдсан "Үзэсгэлэн, яармаг, уулзалт болон бусад төстэй үйл явдлын үеэр үзүүлэх ашиглах бараа".

2. Хавсралт B.2-д дурдсан "Мэргэжлийн багаж төхөөрөмж".

3. Хавсралт B.3-д дурдсан "Чингэлэг, тавиур, баглаа боодол, дээж загвар болон арилжааны үйл ажиллагаатай холбогдон импортолсон бусад бараа".

4. Хавсралт B.5-д дурдсан "Боловсрол, шинжлэх ухаан, эсхүл соёлын зориулалтаар импортолсон бараа".

5. Хавсралт B.6-д дурдсан "Зорчигчийн хувийн хэрэглээний болон спортын зориулалтаар импортолсон бараа".

6.Хавсралт B.7-д дурдсан "Аялал жуулчлалын сурталчилгааны материал".

7. "Хавсралт B.8-д дурдсан "Хилийн хөдөлгөөний шугамаар импортолсон бараа".

8. "Хавсралт B.9-д дурдсан "Хүмүүнлэгийн зориулалтаар импортолсон бараа".

9. Хавсралт C-д дурдсан "Тээврийн хэрэгсэл".

10. Хавсралт D-д дурдсан "Мал, амьтан".

(b) Импортын гаалийн болон бусад татвараас хэсэгчлэн чөлөөлөх нөхцөл

**23. Практик зөвлөмж**

Практик зөвлөмж 22-д ороогүй барааг болон Практик зөвлөмж 22-д дурьдсан бүрэн чөлөөлөгдөх ,нөхцлийн бүхий л шаардлагыг хангаагүй барааг импортын гаалийн болон бусад татвараас аль болох хэсэгчлэн чөлөөлсний үндсэн дээр түр хугацаагаар оруулах зөвшөөрөл олгоно.

**ТУСГАЙ ХАВСРАЛТ H**

**1 дүгээр бүлэг**

**ГААЛИЙН ЗӨРЧИЛ**

**Тодорхойлолт**

Энэхүү Бүлгийн зорилгоор:

E1./F2.

**"гаалийн зөрчлийг захиргааны журмаар шийдвэрлэх"** гэж үндсэний хууль тогтоомжоор гаалийн байгууллагад эрх олгосны үндсэн дээр гаалийн зөрчлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу, эсхүл харилцан буулт хийх хэлбэрээр шийдвэрлэхийг хэлнэ;

E2./F3.

**"харилцан буулт хийх"** гэж гаалийн байгууллагад эрх олгосны дагуу тухайн зөрчилд

холбогдогч этгээдийн гаалийн зөрчилтэй холбоотой дагаж мөрдөх тодорхой нөхцлүүдээс татгалзахыг хүлээн зөвшөөрөхийг хэлнэ;

E3./F1.

**"гаалийн зөрчил"** гэж гаалийн хуулийг зөрчсөн, эсхүл зөрчихийг завдсаныг хэлнэ.

**Зарчим**

**1. Стандарт**

Гаалийн байгууллагаас гаалийн зөрчлийг мөрдөн байцаах, тогтоох болон захиргааны журмаар шийдвэрлэхийг энэхүү Бүлгийн заалтууд болон холбогдолтой гэж үзвэл, Ерөнхий Хавсралтын заалтуудаар зохицуулна.

**2. Стандарт**

Үндэсний хууль тогтоомжид гаалийн зөрчлийг тодорхойлох бөгөөд тэдгээрийг мөрдөн байцаах, тогтоох болон холбогдолтой бол, захиргааны журмаар шийдвэрлэх нөхцлийг заана.

**Үйлчлэх хүрээ**

**3. Стандарт**

Үндэсний хууль тогтоомжид гаалийн зөрчлийг үйлдсэн хариуцлагыг хүлээх этгээдийг тодорхойлно.

**4. Стандарт**

Үндэсний хууль тогтоомжид гаалийн зөрчлийг шийдвэрлэх, түүнээс хойш хэрэгсэхгүй болгох хугацааг тогтоосон байхаас гадна тухайн хугацааг эхлэх өдрийг тодорхой заана.

**Гаалийн зөрчлийг мөрдөн байцаах, тогтоох**

**5. Стандарт**

Үндэсний хууль тогтоомжид гаалийн байгууллагад дараахь эрх мэдлийг олгох нөхцлийг заана:

- бараа, тээврийн хэрэгслийг шалгах;
- бичиг баримт болон захидал харилцааг гаргаж өгөхийг шаардах;
- компьютерийн мэдээллийн баазад нэвтрэх;
- хувь хүнийг нэгжих болон агуулах байранд үзлэг хийх; болон
- нотлох баримтыг хамгаалах.

**6. Стандарт**

Зөвхөн хууль бусаар нэвтрүүлэхийг завдсан үйлдэл, эсхүл гаалийн бусад ноцтой зөрчилд холбогдсон талаар хангалттай үндэслэл байгаа тохиолдолд гаалийн зорилгоор хувь хүний биед үзлэг хийнэ.

**7. Стандарт**

Гаалийн байгууллага нь хууль бусаар нэвтрүүлэхийг завдсан үйлдэл, эсхүл гаалийн бусад ноцтой зөрчилд холбогдсон талаар хангалттай үндэслэл байхгүй бол агуулах байранд үзлэг хийхгүй.

**8. Стандарт**

Гаалийн байгууллага нь сэжиглэгдэж буй гэмт хэргийн нөхцөл байдал, хууль тогтоомжийн ямар заалтыг зөрчсөн талаар болон шаардлагатай бол хүлээлгэх хариуцлагын талаар холбогдох этгээдэд нэн даруй мэдэгдэнэ.

**Гаалийн зөрчил илэрсэн үед дагаж мөрдөх журам**

**9. Стандарт**

Үндэсний хууль тогтоомжид гаалийн зөрчил гарсан болох нь тогтоогдсон нөхцөлд гаалийн байгууллагаас дагаж мөрдөх журам болон авах арга хэмжээг заана.

**10. Практик зөвлөмж**

Гаалийн байгууллага гаалийн зөрчлийн талаар авсан арга хэмжээний бүртгэлд буюу захиргааны тайланд тэмдэглэсэн байна.

**Бараа буюу тээврийн хэрэгслийг хураах буюу саатуулах**

**11. Стандарт**

Гаалийн байгууллага дараахь нөхцөлд бараа болон/буюу тээврийн хэрэгслийг хураана:

- тэдгээрийг хураах зайлшгүй шаардлагатай; эсхүл
- зөрчлийг шийдвэрлэх зарим сүүлчийн шатанд эд мөрийн баримт бүрдүүлэхийг шаардаж болох.

**12. Стандарт**

Хэрэв барааны нэг хэсэг нь гаалийн зөрчилтэй холбоотой бөгөөд гаалийн байгууллага барааны бусад үлдсэн хэсэг нь шууд болон шууд бусаар уг зөрчилтэй холбоогүй гэж үзсэн бол зөвхөн зөрчилд холбогдох хэсгийн барааг хураах буюу саатуулна.

**13. Стандарт**

Гаалийн байгууллага нь бараа болон/буюу тээврийн хэрэгслийг хураах, эсхүл саатуулах нөхцөлд холбогдох этгээдэд дараахь мэдээлэл бүхий бичиг баримтыг гаргаж өгнө:

- хураагдсан, эсхүл саатуулагдсан бараа болон тээврийн хэрэгслийн тайлбар, тоо хэмжээ;
- хураасан, эсхүл саатуулсан шалтгаан; болон
- зөрчлийн шинж байдал.

**14. Практик зөвлөмж**

Гаалийн байгууллага нь хураагдсан, эсхүл саатуулагдсан барааг хангалттай баталгааны үндсэн дээр уг бараа нь хориглосон, эсхүл хязгаарласан бараанд хамаарахгүй бөгөөд зарим дараагийн хэрэг шийдвэрлэх шатанд эд мөрийн баримт болох шаардлагагүй бол буцаан олгоно.

**15. Практик зөвлөмж**

Гаалийн зөрчлийг үйлдэхэд хэрэглэсэн тээврийн хэрэгсэл нь дараахь шаардлагыг хангаж байвал гаалийн байгууллага хураагдсан, эсхүл саатуулагдсан барааг буцаан олгоно:

- тээврийн хэрэгсэл нь барааг нуух зориулалтаар тусгайлан хийгдээгүй, өөрчлөлт оруулаагүй, эсхүл тоноглогдоогүй; болон
- тээврийн хэрэгсэл нь зарим дараагийн хэрэг шийдвэрлэх шатанд эд мөрийн баримт болохгүй; болон
- шаардлагатай баталгааг гаргасан.

**16. Практик зөвлөмж**

Тээврийн хэрэгслийг дараахь нөхцөлд хураана. Үүнд:

- тээврийн хэрэгслийг эзэмшигч, жолоодогч, эсхүл хариуцагч нь тухай үед гаалийн зөрчилд оролцсон, эсхүл хамсаатан болсон эсхүл зөрчлөөс урьдчилан сэргийлэх бүх шаардлагатай арга хэмжээг аваагүй, эсхүл
- тээврийн хэрэгслийг бараагнуух зориулалтаар тусгайлан хийсэн, өөрчлөлт оруулсан, тоноглосон, эсхүл
- тусгайлан өөрчлөлт оруулсан эсхүл тоноглосон тээврийн хэрэгслийг хэвийн байдалд оруулах боломжгүй болсон.

**17. Практик зөвлөмж**

Хураагдсан, эсхүл саатуулагдсан бараа нь түргэн муудаж гэмтэх, эсхүл барааны шинж чанарын хувьд гаалийн байгууллага хадгалах боломжгүйгээс бусад нөхцөлд гаалийн байгууллага хураагдсан, эсхүл саатуулагдсан бараагулсын орлого болгох, хураах шийдвэр гарахаас өмнө устгах, худалдан борлуулахгүй.

**Хувь этгээдийг саатуулах**

**18. Стандарт**

Үндэсний хууль тогтоомжид хувь этгээдийг саатуулахтай холбоотой гаалийн байгууллагын эрх мэдлийг заах бөгөөд үүнтэй холбоотой нөхцлийг ялангуяа саатуулах шийдвэрийг шүүхийн байгууллагаар хянуулах хугацааг заана.

**Гаалийн зөрчлийг захиргааны журмаар шийдвэрлэх**

**19. Стандарт**

Гаалийн байгууллага нь гаалийн зөрчлийг илрүүлсний дараа нэн даруй дараахь нөхцлийг хангах шаардлагатай арга хэмжээг авна:

- гаалийн зөрчлийг захиргааны журмаар шийдвэрлэх үйл ажиллагааг эхэлсэн байх; болон
- холбогдох этгээдэд зөрчлийг шийдвэрлэх нөхцөл, журмыг болон тийм давж заалдах хугацааны талаар мэдээлэх.

**20. Практик зөвлөмж**

Барааны бүрдүүлэлтийн явцад ноцтой бус гаалийн зөрчил илэрсэн бол уг зөрчлийг илрүүлсэн гаалийн газраас шийдвэрлэх боломжтой байна.

**21. Практик зөвлөмж**

Хэрэв зорчигч нь гаалийн ноцтой бус гаалийн зөрчлийг үйлдсэнтэй холбоотой бол уг зөрчлийг илрүүлсэн гаалийн газраас нь зөрчлийг хойшлуулахгүйгээр шийдвэрлэх боломжтой байна.

**22. Стандарт**

Үндэсний хууль тогтоомжид захиргааны журмаар шийдвэрлэх гаалийн зөрчлийн зүйл тус бүрд ногдуулах торгууль шийтгэлийг заах бөгөөд тэдгээрийг хэрэгжүүлэх гаалийн газрын эрх мэдлийг тогтоосон байна.

**23. Стандарт**

Гаалийн зөрчлийг захиргааны журмаар шийдвэрлэхэд ногдуулах аливаа торгууль шийтгэлийн хэмжээ, эсхүл хүндрүүлэх нөхцөл нь тухайн гаалийн зөрчлийн үр дагавар, ноцтой байдал болон холбогдох этгээдийн гаалийн байгууллагад мэдүүлсэн байдал зэргээс хамаарна.

**24. Стандарт**

Барааны мэдүүлэгт буруу мэдээлэл өгсөн боловч мэдүүлэгч нь үнэн зөв мэдээллийг өгөх шаардлагатай арга хэмжээ авснаа нотолсон бол гаалийн байгууллага аливаа торгууль шийтгэлийг ногдуулахдаа тэдгээр хүчин зүйлийг анхаарч үзнэ.

**25. Стандарт**

Гаалийн зөрчил нь давагдашгүй хүчин зүйлийн, эсхүл холбогдох этгээдийн хяналтаас гадуур бусад нөхцлийн улмаас үүссэн бөгөөд холбогдох этгээд болгоомжгүй байдлаар, эсхүл хууран мэхлэх санаатайгаар үйлдээгүй болохыг гаалийн байгууллага хүлээн зөвшөөрсөн бол аливаа торгууль шийтгэл ногдуулахгүй.

**26. Стандарт**

Хураагдсан, эсхүл саатуулагдсан бараag буюу аливаа гаалийн болон бусад татварыг болон бусад бүх хураамжийг болон гарсан зардлыг хассаны дараа тийм бараагборлуулснаас олсон орлогыг:

- гаалийн зөрчлийг бүрэн шийдвэрлэсний дараа тэдгээрийг хүлээн авах эрх бүхий этгээдэд нэн даруй буцаан олгоно; эсхүл
- хэрэв боломжгүй бол тодорхой хугацаанд тэдгээрийг хадгална.

Ингэхдээ бараагхураасны улмаас ээзн нь хэрэгсэхгүй орхисон эсхүл уг хэргийг шийдвэрлэсэн улсын орлогод авсан байж болохгүй.

**Давж заалдах эрх**

**27. Стандарт**

Захиргааны журмаар шийдвэрлэхэд хамаарах гаалийн зөрчилтэй холбоотой аливаа этгээд харилцан буулт хийхийг хүлээн зөвшөөрөх арга замыг сонгоогүй бол гаалийн байгууллагаас бие даасан хөндлөнгийн байгууллагад давж заалдах эрхтэй байна.

**ТУСГАЙ ХАВСРАЛТ J**

**1 дүгээр бүлэг**

**ЗОРЧИГЧ**

**Тодорхойлолт**

Энэхүү Бүлгийн зорилгоор:

E1./F2.

**"Хоёр-гарцын систем"** гэж хоёр төрлийн гарцын аль нэгийг сонгох замаар мэдүүлэг өгөхөөр ирж буй зорчигчийн дагаж мөрдөх гаалийн хяналтын хялбарчилсан системийг хэлнэ. Ногоон өнгийн таних тэмдэгтэй гарц нь татваргүй оруулах хэмжээнээс хэтрээгүй бөгөөд импортлохыг хориглоогүй, эсхүл хязгаарлаагүй тоо хэмжээ, эсхүл үнэ бүхий бараагавч яваа зорчигчдод зориулсан байна. Нөгөө гарц нь улаан өнгөтэй байх бөгөөд бусад зорчигчдод зориулсан байна.

E2./F4.

**"Хувийн хэрэглээний тээврийн хэрэгсэл"** гэж холбогдох этгээдийн зөвхөн хувийн хэрэглээнд ашиглах зориулалтаар импортолсон, эсхүл экспортолсон бөгөөд этгээдүүдийг хөлсөөр тээвэрлэх тээврийн хэрэгсэл, эсхүл үйлдвэрлэлийн, эсхүл арилжааны зорилгоор бараа тээвэрлэх зориулалт бүхий тээврийн хэрэгсэл

хамаарахгүй автомашин болон чиргүүл, завь болон нисэх онгоц, тэдгээрийн сэлбэг, ердийн тоноглол болон төхөөрөмжийг хэлнэ.

E3./F5.

**"Зорчигч"** гэж

(1) тухайн нутаг дэвсгэрээс гарч явдаг буюу байнга оршин суудаггүй ("байнгын бус оршин суугч") улсын нутаг дэвсгэрт түр хугацаагаар орох аливаа этгээд; болон

(2) тухайн нутаг дэвсгэрт буцаж ирдэг ("буцаж ирэх оршин суугч") буюу байнга оршин суудаг ("гарч явах оршин суугч") улсын нутаг дэвсгэрээс гарч явах этгээдийг тус тус хэлнэ.

E4./F3.

**"Хувийн хэрэглээний эд зүйлс"** гэж аяллын үеэр зорчигчийн хувийн хэрэглээнд нь зохих ёсоор шаардагдаж болох, аялалын бүхий нөхцөл байдлыг харгалзан, гэхдээ арилжааны зорилгоор импортолсон, эсхүл экспортолсон аливаа бараа хамаарахгүй бусад бүх зүйл (шинэ буюу хэрэглэж байсан)-ийг хэлнэ.

E5./F1.

**"Түр хугацаагаар оруулах горим"** гэж импортын гаалийн болон бусад татвар төлөхөөс бүрэн, эсхүл хэсэгчлэн чөлөөлсөн нөхцөлөөр гаалийн нутаг дэвсгэрт тодорхой барааг оруулах гаалийн горимыг; тийм барааг тусгай зориулалтаар импортлох бөгөөд тогтоосон хугацаанд болон барааг ашигласнаас үүсэх хэвийн элэгдэл хорогдлоос өөр аливаа өөрчлөлт оруулахгүйгээр буцаан экспортлох болзолтойгоор оруулна.

**Зарчим**

**1. Стандарт**

Зорчигчдод хамаарах гаалийн хөнгөлөлт нь энэхүү Бүлгийн заалтууд болон холбогдолтой бол, Ерөнхий Хавсралтын заалтын дагуу зохицуулагдана.

**2. Стандарт**

Энэхүү Бүлэгт дурьдсан гаалийн хөнгөлөлт зорчигчдын иргэншил/харьялалаас үл хамааран мөрдөгдөнө.

**Үйлчлэх хүрээ**

**3. Стандарт**

Гаалийн байгууллага нь зорчигчидтой холбогдох гаалийн бүрдүүлэлтийг хийж дуусгах гаалийн газрыг томилно. Эдгээр гаалийн газрын эрх мэдэл, байршил болон ажиллах цагийг тогтоохдоо тухайлбал, газар зүйн нөхцөл байдал болон зорчигчдын хөдөлгөөний тухайн үеийн хэмжээг харгалзан үзнэ.

**4. Стандарт**

Гаалийн зохих хяналтын шаардлагыг хангасан, хувийн хэрэглээний тээврийн хэрэгслээр тухайн улсад ирж байгаа,эсхүл явж байгаа зорчигчид өөрсдийн зорчиж байгаа тээврийн хэрэгслээ орхилгүйгээр гаалийн бүхий л шаардлагатай бүрдүүлэлтийг хийлгэхийг зөвшөөрнө.

**5. Практик зөвлөмж**

Арилжааны зориулалттай автомашин, эсхүл галт тэргээр тухайн улсад ирж байгаа, эсхүл явж байгаа зорчигчид өөрсдийн зорчиж байгаа тээврийн хэрэгслээ орхилгүйгээр гаалийн бүхий л шаардлагатай бүрдүүлэлтийг хийлгэхийг зөвшөөрнө.

**6. Практик зөвлөмж**

Хоёр гарцын системийг зорчигчдод гаалийн хяналт тавих, тэдгээрийн авч яваа бараанд, шаардлагатай тохиолдолд, хувийн хэрэглээний тээврийн хэрэгсэлд бүрдүүлэлт хийхэд ашиглана.

**7. Практик зөвлөмж**

Хэрэглэсэн тээврийн хэрэгслийн төрлөөс үл хамааран зорчигчдын эсхүл тэдгээрийн авч яваа ачааны тусгай жагсаалтыг гаалиийн зорилгоор шаардахгүй.

**8. Практик зөвлөмж**

Гаалийн байгууллага нь бусад агентлаг болон худалдааны хүрээнийхэнтэй хамтран зорчигчдод гаалийн хяналт тавих болон тэдгээрийн авч яваа ачаанд хийх бүрдүүлэлтийг хөнгөлөх зорилгоор, боломжтой бол, олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн зорчигчдын талаарх урьдчилсан мэдээллийг ашиглах арга хэмжээ авна.

**9. Практик зөвлөмж**

Зорчигч өөрийн авч яваа барааны талаар аман мэдүүлэг өгч болно. Гэхдээ зорчигчид үндэсний хууль тогтоомжид заасан хэмжээнээс хэтэрсэн үнэ эсхүл тоо хэмжээтэй, эсхүл арилжааны шинжтэй барааг импортлох, эсхүл экспортлохоор авч яваа бараа бол гаалийн байгууллага бичгээр, эсхүл электрон сүлжээгээр мэдүүлэхийг шаардаж болно.

**10. Стандарт**

Гаалийн хяналтын зорилгоор хүний биед хийх үзлэгийг зөвхөн онцгой тохиолдолд, барааг хилээр хууль бусаар нэвтрүүлэх үйлдэлд эсхүл бусад зөрчилд сэжиглэх бодит үндэслэл байгаа үед гаалийн ажилтан хийнэ.

**11. Стандарт**

Гаалийн байгууллагаас тогтоосон нөхцлийн дагуу зорчигчийн авч яваа бараанд гаалийн холбогдох горимоор бүрдүүлэлт хийх, буцаан экспортлох, эсхүл үндэсний хууль тогтоомжийн дагуу өөр байдлаар захиран зарцуулах барааг дараах тохиолдолд агуулахад хадгална:

- тухайн зорчигчийн хүсэлтээр;
- холбогдох бараанд шууд бүрдүүлэлт хийх боломжгүй; эсхүл
- энэхүү Бүлгийн бусад заалтууд тийм бараанд хамаарахгүй.

**12.Стандарт**

Биеэс тусдаа ачуулсан ачаа (өөрөөр хэлбэл зорчигчоос өмнө, эсхүл хойно ирж байгаа, эсхүл явж байгаа)-нд зорчигчийн авч яваа бараатай нэг адил, эсхүл гаалийн бусад хялбарчилсан горимын дагуу бүрдүүлэлт хийнэ.

**13. Стандарт**

Аливаа итгэмжлэгдсэн этгээд биеэс тусдаа ачуулсан ачаанд зорчигчийн нэрийн өмнөөс гаалийн бүрдүүлэлт хийлгэнэ.

**14. Практик зөвлөмж**

Үндэсний хууль тогтоомжид заасан хэмжээнээс нийт үнэ, эсхүл тоо хэмжээ нь хэтрээгүй, арилжааны бус шинж чанартай бараа импортолсон зорчигч дотоодын хэрэглээнд зориулан бүрдүүлэлт хийх горимд оруулахаар мэдүүлсэн бол үнэлгээний тэглэх системийг хэрэглэнэ.

**15. Практик зөвлөмж**

Боломжтой бол кредит карт, эсхүл банкны картыг ашиглан гаалийн болон бусад татвар болон гаалийн үйлчилгээний төлбөрийг төлөх хэрэгсэл болохыг хүлээн зөвшөөрч болно.

Орох

**16. Практик зөвлөмж**

Зорчигчид импортын гаалийн болон бусад татвар төлөхгүйгээр оруулах тамхин бүтээгдэхүүн, дарс, архи болон үнэртэй усны төрлийн барааны тоо хэмжээ нь дор дурдсан хэмжээнээс хэтрээгүй байна:

(a) 200 ширхэг янжуур тамхи, эсхүл 50 ширхэг сигар, эсхүл 250 гр тамхи, эсхүл эдгээр төрлийн барааны нийт жин нь 250 гр-аас хэтрээгүй байх;

(b) 2 л дарс, эсхүл 1 л архи;

(c) 0 .250 л үнэртэй ус ба 50 гр сүрчиг.

Гэвч тамхи болон согтууруулах ундааны талаарх энэ журам нь тодорхой насны хүмүүст хамаарах бөгөөд тэдэнд эдгээр бараа авч явах эрх олгохгүй байх, эсхүл олгосон ч тоон хязгаарлалттай байж болох ийм хүмүүст, эсхүл хилээр байнга, эсхүл тухайн улсаас гараад 24 цагийн дотор буцаж нэвтэрч байгаа хүмүүст зөвхөн тодорхой хэмжээгээр хязгаар тогтоож болно.

**17. Практик зөвлөмж**

Тогтоосон тоо хэмжээний дотор импортын гаалийн татваргүй оруулах өргөн хэрэглээний бүтээгдэхүүнээс гадна зорчигчид 75 зээлжих тусгай эрхтэй тэнцэх үнэ бүхий зөвхөн арилжааны шинж чанаргүй бараа гаалийн татваргүйгээр импортлох эрхтэй. Тодорхой насанд хүрээгүй хүмүүс, эсхүл байнга хилээр зорчдог хүмүүс, тухайн улсаас гараад 24 цагийн дотор буцаж нэвтэрч байгаа хүмүүсийн хувьд энэхүү хязгаарыг бага хэмжээгээр тогтоож болно.

**18. Стандарт**

Буцаж ирж буй оршин суугчидад тухайн улсаас гарах үедээ авч явсан бөгөөд хэрэглээнд байсан хувийн эд зүйлс болон өөрсдийн тээврийн хэрэгслээ импортын гаалийн болон бусад татваргүйгээр буцаан импортлохыг зөвшөөрнө.

**19. Стандарт**

Байнгын бус оршин суугчдаас дор дурьдсанаас бусад тохиолдолд хувийн эд зүйлсийг нь түр хугацаагаар оруулахад гаалийн бичиг баримт, эсхүл баталгааг гаалийн байгууллага шаардахгүй:

- үнэ, эсхүл тоо хэмжээ нь үндэсний хууль тогтоомжоор тогтоосон хэмжээнээс хэтэрсэн; эсхүл

- гаалийн байгууллагаас татварын орлогод эрсдэл учруулж магадгүй гэж үзсэн.

**20. Стандарт**

Хувцас, ариун цэврийн хэрэглэл болон хувийн хэрэглээний зайлшгүй бусад зүйлсээс гадна дараах зүйлсийг байнгын бус оршин суугчдын хувийн хэрэглээний зүйлс гэж тооцогдоно.

- Хувийн үнэт, гоёл чимэглэлийн эдлэл;

- Гэрэл зургийн аппарат болон дүрс бичлэг, кино зургийн камер, тэдгээрийн тодорхой тоо хэмжээний хальс, хуурцаг болон бусад дагалдах хэрэглэл;

- Зөөврийн слайд болон кино прожектор, тэдгээрийн тодорхой тоо хэмжээний слайд болон хальс;

- дуран;

- зөөврийн хөгжмийн зэмсэг;

- зөөврийн тоглуулагч, бичлэгийн хальс, СД тоглуулагч болон дуу хураагч хальс,бичлэг болон дискний хамт;

- зөөврийн радио хүлээн авагч;

- гар утас, эсхүл үүрэн телефон;

- зөөврийн телевизор;

- зөөврийн бичгийн машин;

- зөөврийн компьютер болон дагалдах хэрэгсэл;

- зөөврийн тооны машин;

- хүүхдийн тэрэг болон тэргэнцэр;

- тахир дутуу хүмүүсийн тэргэнцэр;

- спортын хэрэглэл.

**21. Стандарт**

Байнгын бус оршин суугчдын хувийн эд зүйлсийг түр хугацаагаар оруулах мэдүүлгийг бичих шаардлагатай бол түр хугацаагаар оруулах зөвшөөрлийн хугацаа нь зорчигчдын тухайн улсад байх хугацааг харгалзах бөгөөд тэр нь үндэсний хууль тогтоомжид заасан хугацаанаас хэтрээгүй байх ёстой.

**22. Стандарт**

Зорчигчийн хүсэлтээр, болон гаалийн байгууллагаас шаардлагатай гэж үзвэл байнгын бус оршин суугчдын хувийн эд зүйлсийг түр оруулахыг зөвшөөрсөн анхны хугацааг үндэсний хууль тогтоомжид заасан хугацаанаас хэтрээгүй тохиолдолд гаалийн байгууллага сунгаж болно.

**23. Стандарт**

Байнгын бус оршин суугчид хувийн хэрэглээний тээврийн хэрэгслээ түр хугацаагаар оруулахыг зөвшөөрнө.

**24. Стандарт**

Хувийн хэрэглээний автомашины банкинд хийсэн шатахууныг импортын гаалийн болон бусад татвараас чөлөөлнө.

**25. Стандарт**

Хувийн хэрэглээний тээврийн хэрэгсэлд үзүүлж байгаа хөнгөлөлт нь байнгын бус оршин суугч зорчигчийн эзэмшиж байгаа, түрээсэлсэн,

эсхүл зээлдэн яваа болон тухайн зорчигчтой хамт, өмнө нь, эсхүл хойно нь ирж байгаагаас үл шалтгаалан тэдгээр тээврийн хэрэгсэлд хамаарна.

**26. Практик зөвлөмж**

Байнгын бус оршин суугчдын хувийн хэрэглээний тээврийн хэрэгслийг түр хугацаагаар оруулахад гаалийн байгууллага гаалийн бичиг баримт, эсхүл баталгаа шаардахгүй.

**27. Практик зөвлөмж**

Байнгын бус оршин суугчдын хувийн хэрэглээний тээврийн хэрэгслийг түр хугацаагаар оруулахыг зөвшөөрөхтэй холбогдуулан гаалийн бичиг баримт, эсхүл баталгаа шаардах тохиолдолд гаалийн байгууллага олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрсөн баримт бичиг, баталгааг хүлээн авбал зохино.

**28. Стандарт**

Түр оршин суугчдын хувийн хэрэглээний тээврийн хэрэгсэлд түр хугацаагаар оруулах зөвшөөрөл олгохтой холбогдуулан түр хугацаагаар оруулахаар мэдүүлэх нөхцөлд байнгын бус оршин суугчийн тухайн улсад байх хугацааг харгалзан үндэсний хууль тогтоомжид заасан хугацаанаас хэтрээгүй тохиолдолд зөвшөөрлийг олгоно.

**29. Стандарт**

Тухайн зорчигчийн хүсэлтээр болон гаалийн байгууллага шаардлагатай гэж үзвэл байнгын бус оршин суугчдын хувийн хэрэглээний тээврийн хэрэгслийг түр хугацаагаар оруулахыг зөвшөөрсөн анхны хугацааг үндэсний хууль тогтоомжид заасан хугацаанаас хэтрээгүй тохиолдолд сунгаж болно.

**30. Стандарт**

Тухайн улсад түр хугацаагаар оруулсан хувийн хэрэглээний тээврийн хэрэгслийг засварлахад шаардагдах сэлбэгийг түр хугацаагаар оруулахыг зөвшөөрч болно.

**Буцаан экспортлох**

**31. Стандарт**

Гаалийн байгууллага импортолсон гаалийн газраас өөр гаалийн газраар байнгын бус оршин суугчдын түр хугацаагаар оруулсан барааг буцаан экспортлохыг зөвшөөрнө.

**32. Стандарт**

Гаалийн байгууллага байнгын бус оршин суугчдын хувийн хэрэглээний тээврийн хэрэгсэл, эсхүл хувийн эд зүйлс нь осол, эсхүл давагдашгүй хүчин зүйлсийн улмаас ноцтой гэмтсэн, эсхүл эвдэрсэн тохиолдолд буцаан экспортлохыг шаардахгүй.

**Гарах**

**33. Стандарт**

Гарч байгаа зорчигчдын гаалийн бүрдүүлэлт нь аль болох энгийн байна.

**34. Стандарт**

Гаалийн журамд нийцсэн, төлбөл зохих аливаа экспортын гаалийн болон бусад татварыг төлсөн тохиолдолд зорчигчдод арилжааны зорилгоор бараа экспортлохыг зөвшөөрнө.

**35. Стандарт**

Тухайн улсаас гарч яваа иргэдийн хүсэлтээр, гаалийн татваргүйгээр буцаан импортлох үед гаалийн байгууллага зарим төрлийн барааг онцлон танихад зориулсан арга хэмжээ авна.

**36. Стандарт**

Зөвхөн онцгой тохиолдолд, гаалийн байгууллага тухайн улсаас гарч яваа иргэдээс хувийн хэрэглээний тээврийн хэрэгсэл болон хувийн эд зүйлсийг түр хугацаагаар экспортлох бичиг баримтийг шаардаж болно.

**37. Практик зөвлөмж**

Хэрэв бэлэн мөнгөөр баталгааг гаргасан бол бараа тухайн гаалийн газраар дамжин импортлогдоогүй байсан ч буцаан экспортлож буй гаалийн газар уг баталгааг буцаан төлөх нөхцлийг бүрдүүлнэ.

**Дамжин өнгөрөх зорчигчид**

**38. Стандарт**

Дамжин өнгөрөх зорчигчид дамжин өнгөрөх бүсээс гараагүй тохиолдолд аливаа гаалийн хяналтаар орохыг шаардахгүй. Гэхдээ гаалийн байгууллага дамжин өнгөрөх бүсийг ерөнхийд нь хянаж, гаалийн ямар нэг зөрчил гарах магадлал байгаа бол шаардлагатай арга хэмжээ эрхтэй.

**Зорчигчдод хэрэглэх гаалийн хөнгөлөлтийн талаарх мэдээлэл**

**39. Практик зөвлөмж**

Зорчигчийн хувьд хөнгөлөлт эдлэх талаарх мэдээлэл нь тухайн улсын албан ёсны хэл, эсхүл шаардлагатай гэж үзвэл аливаа бусад хэл дээр байна.

**2 дугаар бүлэг**

**ШУУДАНГИЙН ТЭЭВЭРЛЭЛТ**

**Тодорхойлолт**

Энэхүү бүлгийн зорилгоор:

E1./F1.

**"CN22/23"** гэж одоогийн мөрдөгдөж байгаа Дэлхийн Шуудан Холбооны актад заасан шуудан илгээлтэд зориулсан мэдүүлгийн тусгай маягтуудыг хэлнэ.

E2./F3.

**"Шуудан илгээлтэд хийх гаалийн бүрдүүлэлт"** гэж шуудангийн илгээмжид хамаарах гаалийн байгууллагаас болон сонирхогч талаас явуулж буй бүхий л үйл ажиллагааг хэлнэ.

E3./F2.

**"шуудан илгээлт"** гэж шуудангаар илгээж байгаа, эсхүл шуудангийн байгууллагуудад зориулсан одоогийн мөрдөгдөж байгаа Дэлхийн Шуудан Холбооны актад заасан захидал болон илгээмжийг хэлнэ.

E4./F5.

**"шуудангийн байгууллага"** гэж Дэлхийн Шуудан Холбооны одоогийн мөрдөгдөж байгаа актаар зохицуулагдаж байгаа олон улсын үйлчилгээг явуулах засгийн газраас эрх авсан улсын, эсхүл хувийн байгууллагыг хэлнэ.

E5./F4.

**"Дэлхийн Шуудан Холбоо"** гэж 1874 онд "Шуудангийн Ерөнхий Холбоо" нэртэйгээр Бернийн Хэлэлцээрээр байгуулагдаж, 1878 онд Дэлхийн Шуудан Холбоо гэсэн нэртэй болж, 1948 оноос НҮБ-ын тусгай агентлаг болсон засгийн газар хоорондын байгууллагыг хэлнэ.

**Зарчим**

**1. Стандарт**

Шуудан илгээлтэд хийх гаалийн бүрдүүлэлт нь энэхүү Бүлгийн заалт болон холбогдолтой бол, Ерөнхий Хавсралтын заалтаар зохицуулагдана.

**2. Стандарт**

Шуудан илгээлтийн талаарх гаалийн нөхцөлтэй холбоотой гаалийн болон шуудангийн байгууллагын холбогдох үүрэг, хариуцлагыг үндэсний хууль тогтоомжид заана.

**Шуудан илгээлтэд гаалийн бүрдүүлэлт хийх**

**3. Стандарт**

Шуудан илгээлтэд хийх бүрдүүлэлтийг аль болох шуурхай хийж гүйцэтгэнэ.

(а) Барааг гаалиар гаргах, оруулах

**4.Стандарт**

Чөлөөт эргэлтэд байгаа бараа, эсхүл гаалийн өөр горимд хамрагдаж байгаа эсэхээс үл хамааран шуудан илгээлтээр бараа экспортлохыг зөвшөөрнө.

**5. Стандарт**

Дотоодын хэрэглээнд зориулан бүрдүүлэлт хийх, эсхүл өөр гаалийн горимоор бүрдүүлэлт хийхээс үл хамааран шуудан илгээлтээр бараа импортлохыг зөвшөөрнө.

(б) Гаальд шалгуулах

**6. Стандарт**

Гаалийн байгууллага шуудан илгээлтийн гаалийн хяналт тавих, тэдгээрийг шалгах ажлыг хийх шуудангийн байгууллагыг томилно.

**7. Стандарт**

Дор дурьдсанаас бусад тохиолдолд гаалийн хяналт тавих зорилгоор экспортлох шуудан илгээлтийг гаалийн байгууллагад мэдүүлэхийг шаардахгүй:

- экспортлоход зөвшөөрөл шаардагдах бараа;
- экспортлохыг хориглосон, эсхүл хязгаарласан, эсхүл экспортын татвар болон бусад татвар ногдуулах бараа;
- үндэсний хууль тогтоомжид заасан хэмжээнээс хэтэрсэн үнэ бүхий бараа; эсхүл
- сонгон шалгах замаар гаалийн хяналтад орох бараа.

**8. Практик зөвлөмж**

Гаалийн байгууллага импортолсон шуудан илгээлтийн дор дурьдсан төрлүүдийг, нийтлэг журмын дагуу, тэдгээрт шалгалт хийхийг шаардахгүйгээр:

а. хувийн шуудангийн зөвхөн ил захидал болон захиа;

b. хараагүй хүмүүст зориулсан ном зохиол;

c. импортын гаалийн болон бусад татвараас чөлөөлөгдөх хэвлэмэл материал.

(c) CN22 эсхүл CN23 маягт эсхүл гаалийн мэдүүлгийн эсрэг бүрдүүлэлт хийх

**9. Стандарт**

Гаалийн байгууллагад шаардлагатай бүх мэдээлэл CN22 эсхүл CN23 болон бусад дагалдах бичиг баримтад байгаа тохиолдолд CN22 эсхүл CN23 маягтыг дор дурьдсанаас бусад тохиолдолд гаалийн мэдүүлэг гэж үзнэ:

- үндэсний хууль тогтоомжид заасан хэмжээнээс хэтэрсэн үнэ бүхий бараа;
- хориглосон, эсхүл хязгаарласан, эсхүл экспортын гаалийн болон бусад татвар ногдуулах бараа;
- экспортлоход зөвшөөрөл шаардагдах бараа;
- дотоодын хэрэглээнд зориулан бүрдүүлэлт хийхээс бусад гаалийн горимын дагуу сонгох зорилгоор импортолсон бараа.

Дээрх тохиолдолд тусдаа гаалийн мэдүүлэг бичихийг шаардана.

**Дамжин өнгөрөх шуудан илгээлт**

**10. Стандарт**

Дагалдах эзэнтэйгээс бусад дамжин өнгөрөх шуудан илгээлтийг гаалийн шалгалтгүйгээр явуулна.

**Гаалийн болон бусад татвар хураах**

**11. Стандарт**

Гаалийн байгууллага нь шуудан илгээлтээр явуулсан бараанаас гаалийн болон бусад татвар хураахад хамгийн энгийн журмыг баримтална.

**3 дугаар бүлэг**

**АРИЛЖААНЫ ЗОРИУЛАЛТЫН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ**

**Тодорхойлолт**

Энэхүү бүлгийн зорилгоор:

E1./F2.

**"арилжааны зориулалтын тээврийн хэрэгсэлд хийх гаалийн бүрдүүлэлт"** гэж холбогдох этгээд болон гаалийн байгууллагаас гаалийн нутаг дэвсгэрт орж байгаа, эсхүл гарч байгаа болон түүний дотор байгаа арилжааны зориулалтын тээврийн хэрэгслийн хувьд хийж байгаа бүхий л үйл ажиллагааг хэлнэ.

E2./F1.

**"Хилээр оруулах мэдүүлэг"** эсхүл **"хилээр гаргах мэдүүлэг"** гэж энэ тохиолдолд арилжааны зориулалтын тээврийн хэрэгслийг ирж байгаа, эсхүл гарч байгаа үед тухайн арилжааны зориулалттай тээврийн хэрэгслийг хариуцаж байгаа этгээдээс арилжааны зориулалттай тээврийн хэрэгсэл болон тухайн аялал, ачаа, агуулах, багийн гишүүд, эсхүл зорчигчдод хамаарах хэрэгцээт эд зүйлсийг агуулсан гаалийн байгууллагад өгөх аливаа мэдүүлгийг хэлнэ.

E3./F3.

**"арилжааны зориулалтын тээврийн хэрэгсэл"** гэж аливаа усан онгоц ( усан онгоц болон усан дээгүүр хөвөгч хөнгөн болон ачааны онгоцыг оруулан), хийлсэн агаараар явагч усан онгоц, нисэх онгоц, автомашин (чиргүүл, хагас чиргүүл эсвэл автомашины хосолмолыг оруулан), олон улсын тээврийн хөдөлгөөнд зорчигчдод хөлсөөр үйлчилдэг, эсхүл арилжааны, эсхүл үйлдвэрлэлийн зориулалттай барааг тээвэрлэхэд ашигладаг төмөр замын хэрэгсэл, тэдгээрийн ердийн сэлбэг, дагалдах хэрэгсэл болон тоног төхөөрөмж, мөн арилжааны зориулалттай тээврийн хэрэгсэлтэй хамт тээвэрлэж байгаа тосолгооны материал болон ердийн саванд нь байгаа түлш шатахууныг хэлнэ.

**Зарчим**

**1. Стандарт**

Арилжааны зориулалттай тээврийн хэрэгсэлд хийх гаалийн бүрдүүлэлтийг энэхүү Бүлгийн заалт болон холбогдолтой бол Ерөнхий Хавсралтын заалтуудаар зохицуулна.

**2. Практик зөвлөмж**

Арилжааны зориулалттай тээврийн хэрэгсэлд хийх гаалийн бүрдүүлэлтийг арилжааны зориулалттай тээврийн хэрэгслийг бүртгэсэн улс орон, эсхүл эзэмшигч, аль улсаас ирж байгаа, эсхүл аль улсад очихоос үл хамааран тэгш эрхтэйгээр хийнэ.

**Арилжааны зориулалттай тээврийн хэрэгслийг түр хугацаагаар оруулах**

**3. Практик зөвлөмж**

Арилжааны зориулалтай тээврийн хэрэгслийг ачаатай, ачаагүйгээс нь үл хамааран гаалийн нутаг дэвсгэрт импортын гаалийн болон бусад татвараас чөлөөлөн оруулах зөвшөөрөл олгохдоо тэдгээрийг түр хугацаагаар оруулсан гаалийн нутаг дэвсгэрт дотоодын тээвэрт ажиглахгүй гэсэн нөхцлөөр олгоно. Тэдгээр тээврийн хэрэгслийг хэвийн ажиллах үеийн элэгдэл хорогдол, шатах-тослох материалын хэвийн хэрэглээ болон ердийн засвараас өөр ямар нэгэн өөрчлөлт оруулахгүйгээр буцаан экспортлох нөхцөлтэйгээр оруулна.

**4. Стандарт**

Гаалийн байгууллага зөвхөн гаалийн шаардлагатай хяналт шалгалт хийх зорилгоор шаардлагатай гэж үзсэн тохиолдолд гадаадад зохих ёсоор бүртгэгдсэн арилжааны зориулалттай тээврийн хэрэгслээс баталгаа, эсхүл түр зөвшөөрлийн бичиг баримт шаардаж болно.

**5. Стандарт**

Гаалийн байгууллага арилжааны зориулалттай тээврийн хэрэгслийг буцаан экспортлох хугацааг тогтоохдоо тэдгээр тээврийн хэрэгслийн үйл ажиллагааны нөхцөл байдлыг анхаарч үзнэ.

**6. Практик зөвлөмж**

Тухайн хүний хүсэлтээр болон гаалийн байгууллага шаардлагатай гэж үзвэл анх тогтоосон хугацааг өөрчилж болно.

**Сэлбэг болон тоног төхөөрөмжийг түр хугацаагаар оруулах**

**7. Практик зөвлөмж**

Арилжааны зориулалттай тээврийн хэрэгсэлтэй хамт импортолсон бөгөөд түүнтэй хамт буцаан экспортлох, түүнээс тусад нь, эсхүл хамтад нь ашиглаж болох ачааг ачих, буулгах, зөөх болон хамгаалах тусгай зориулалтын тоног төхөөрөмжийг импортын гаалийн болон бусад татвараас чөлөөлөх нөхцөлтэйгөөр гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулж болно.

**8. Практик зөвлөмж**

Гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар импортолсон засварын, эсхүл үйлчилгээний явцад арилжааны зориулалтттай тээврийн хэрэгсэлд ашиглах, эсхүл түүнтэй холбоотой сэлбэг болон тоног төхөөрөмжийг солиход ашиглах сэлбэг болон тоног төхөөрөмжийг импортын гаалийн болон бусад татвараас чөлөөлөн гаалийн нутаг дэвсгэрт оруулж болно.

**Ирэх**

**9. Стандарт**

Арилжааны зориулалттай тээврийн хэрэгслийг ирэхэд хилээр оруулахаар гаальд мэдүүлэх үед шаардагдах бичиг баримт нь гаалийн хуулийн заалттай нийцэхүйц, аль болох цөөн байх ёстой.

**10. Стандарт**

Гаалийн байгууллага тээврийн хэрэгслийг ирэх үед хилээр оруулах гаалийн мэдүүлгийн хувийг аль болох цөөлөх ёстой.

**11. Стандарт**

Арилжааны зориулалттай тээврийн хэрэгслийг ирэхтэй холбогдуулан мэдүүлэх, гаалийн мэдүүлэгтэй хамт шаардах бичиг баримтыг хууль ёсны болгох, шалгах, үнэн зөвийг тогтоох, эсхүл тээврийн хэрэгсэл ирж байгаа улстай урьдчилан тохиролцсон байхыг шаардахгүй.

**Гаалийн нутаг дэвсгэрийн зохих зогсоолд ирэх**

**12. Стандарт**

Арилжааны зориулалттай тээврийн хэрэгсэл өөр улсад дундын зогсолт хийхгүйгээр гаалийн нутаг дэвсгэр дэх зохих зогсоолд ирж байгаа тохиолдолд хийх гаалийн бүрдүүлэлт нь аль болох энгийн байх бөгөөд өмнө нь тухайн тээврийн хэрэгсэлд хэрэглэсэн гаалийн хяналт шалгалтын ажиллагаар харгалзан үзнэ.

**Гарах**

**13. Стандарт**

Арилжааны зориулалттай тээврийн хэрэгслийг гаалийн нутаг дэвсгэрээс гарах үед хэрэглэх гаалийн бүрдүүлэлт нь дараахь нөхцлийг хангах арга хэмжээгээр хязгаарлагдах ёстой:

a. шаардлагатай бол гаалийн холбогдох байгууллагад зохих журмын дагуу мэдүүлсэн хилээр гаргах мэдүүлэг;\

b. шаардлагатай бол гаалийн лац, ломбыг тавьсан байх;

c. хяналт шалгалтын зорилгоор шаардлагатай бол тусгай тогтоосон гаалийн замаар явах; болон

d. арилжааны зориулалттай тээврийн хэрэгслийг гарах үед зөвшөөрөлгүйгээр хоцроохгүй байх.

**14. Практик зөвлөмж**

Хилээр гарах мэдүүлгийн агуулга хилээр орох мэдүүлэгтэй адил байх тохиолдолд гаалийн байгууллага түүнийг хилээр гаргах зорилгоор ашиглахыг зөвшөөрч болно.

**15.Стандарт**

Гаалийн нутаг дэвсгэрээс гаргахыг зөвшөөрсөн арилжааны зориулалттай тээврийн хэрэгсэл нь анх орж ирсэн гаалийн газраас өөр газраар дамжин гарч болно.

**4 дүгээр бүлэг**

**ТАТВАРГҮЙ БАРАА**

**Тодорхойлолт**

Энэхүү бүлгийн зорилгоор:

E1./F6.

**"тээвэрлэгч"** гэж барааг тээвэрлэж буй эсхүл орлож буй эсхүл тээврийн хэрэгслийн үйл ажиллагааг хариуцсан этгээдийг хэлнэ.

E2.F/1.

**"татваргүй бараанд хэрэглэх гаалийн бүрдүүлэлт"** гэж тухайн этгээд болон гаалийн байгууллагаас татваргүй хэрэглэх бараатай холбогдуулан явуулж байгаа бүхий л үйл ажиллагааг хэлнэ.

E3./F5

**"татваргүй бараанд гаалиас хийх ажиллагаа"** гэж шаардлагатай үйлчилгээ болон татваргүй бараатай холбоотой хийх гаалийн бүх үйл ажиллагааг хэлнэ.

E4./F2.

**"татваргүй бараа"** гэж

- хэрэглэхэд зориулсан татваргүй бараа; болон

- авч явах татваргүй барааг хэлнэ.

E5./F3.

**"хэрэглэхэд зориулсан татваргүй бараа"** гэж

- Усан онгоц, нисэх онгоц эсхүл галт тэрэгний зорчигчид болон багийн гишүүдийн хэрэглэхэд зориулан худалдсан эсхүл худалдаагүй барааг;

- Усан онгоц, нисэх онгоц эсхүл галт тэргийг ажиллуулах болон үйлчилгээ хийхэд шаардлагатай сэлбэг болон тоног төхөөрөмжөөс бусад шатахуун болон тосолгооны материал, барааг; эдгээр бараа нь гаалийн нутаг дэвсгэрт ирээд байгаа, эсхүл тэнд зогсож байгаа усан онгоц, нисэх онгоцонд, эсхүл

галт тэргэнд байгаа зорчигч, багийн гишүүдэд худалдах ,эсхүл олон улсын тээвэрт хүмүүсийг хөлсөөр тээвэрлэх, эсхүл бараа үйлдвэрлэлийн болон арилжааны зориулалтаар, хөлсөөр, эсхүл хөлсгүй тээвэрлэж байгаа усан болон нисэх онгоцонд хэрэглэх барааг хэлнэ.

E6./F4.

**"авч явах татваргүй бараа"** гэж усан болон нисэх онгоцны баг, зорчигчдод газардсаны дараа болон тэдгээрийн бүхээг, тавцанд, эсхүл тухайн усан болон нисэх онгоц гаалийн нутаг дэвсгэрт байх хугацаандаа хэрэглэх, олон улсын замд хүмүүсийг хөлсөөр тээвэрлэж байгаа, эсхүл барааг хөлсөөр болон хөлсгүй тээвэрлэж байгаа усан болон нисэх онгоцонд хэрэглэх барааг хэлнэ.

**Зарчим**

**1. Стандарт**

Татваргүй барааг гаалиар нэвтрүүлэх ажиллагааг энэхүү Бүлгийн болон холбогдолтой бол Ерөнхий Хавсралтын заалтаар зохицуулна.

**2. Практик зөвлөмж**

Татваргүй барааны гаалийн нөхцлийг усан онгоц, нисэх онгоц эсвэл галт тэргийг бүртгүүлсэн эсхүл эзэмшигч улсаас үл хамааран адил тэгш хэрэглэнэ.

**Ирж байгаа усан онгоц, нисэх онгоц эсхүл галт тэргэн дэх татваргүй бараа**

(a) Импортын гаалийн болон бусад татвараас чөлөөлөх

**3. Стандарт**

Гаалийн нутаг дэвсгэрт ирж байгаа усан онгоц, эсхүл нисэх онгоц дахь татваргүй барааг тухайн тээврийн хэрэгслийн тавцан дээр байгаа нөхцөлд импортын гаалийн болон бусад татвараас чөлөөлнө.

**4. Практик зөвлөмж**

Олон улсын буухиа галт тэрэгний хувьд зорчигч болон багийн гишүүдийн хэрэглээнд зориулан импортолсон барааг дараахь нөхцөлд импортын гаалийн болон бусад татвараас чөлөөлнө:

(a) зөвхөн тухайн галт тэрэг явж өнгөрч байгаа улсад эдгээр барааг худалдаж авсан;

(b) барааг худалдаж авсан улсад тухайн бараанд ногдох татварыг төлсөн.

**5. Стандарт**

Гаалийн нутаг дэвсгэрт ирж байгаа усан онгоц, нисэх онгоц болон галт тэрэгний хэвийн ажиллагаа болон үйлчилгээнд шаардагдах зориулалтын татваргүй бараа нь гаалийн нутаг дэвсгэрт орж ирэхдээ эдгээр тээврийн хэрэгслийн тавцанд байгаа бол гаалийн нутаг дэвсгэрт байх үедээ ч тавцан дээрээ байх тохиолдолд импортын гаалийн болон бусад татвараас чөлөөлнө.

(b) Бичиг баримт

**6. Стандарт**

Гаалийн нутаг дэвсгэрт ирж байгаа усан онгоцны тавцанд байгаа татваргүй барааны мэдүүлгийг гаалийн байгууллага шаардах бөгөөд өгөх мэдээлэл нь гаалийн хяналтад шаардагдах аль болох цөөн тооны мэдээлэл байна.

**7. Практик зөвлөмж**

Тээврийн хэрэгсэл дотор байгаа татваргүй бараанаас гаалийн байгууллагын зөвшөөрлөөр гаргах барааны тоо хэмжээг гаалийн нутаг дэвсгэрт усан онгоц ирэх үед мэдүүлсэн татваргүй барааны мэдүүлэгт бичих ёстой бөгөөд тэдгээрийг гаальд мэдүүлэхтэй холбогдуулан тусгайлан маягт шаардахгүй.

**8. Практик зөвлөмж**

Татваргүй барааг гаалийн нутаг дэвсгэрт байх үед усан онгоцонд нийлүүлэх татваргүй барааны тоо хэмжээг гаалийн байгууллагаас шаардсан татваргүй барааны мэдүүлэгт бичнэ.

**9. Стандарт**

Нисэх онгоц дотор үлдсэн татваргүй барааны салангид мэдүүлгийг гаалийн байгууллага шаардахгүй.

(c) Хэрэглээний зориулалттай татваргүй барааг олгох

**10. Стандарт**

Гаалийн байгууллага гаалийн нутаг дэвсгэрт байгаа усан онгоц дээрх хэрэглээний зориулалттай татваргүй барааг оруулахдаа зорчигч болон багийн гишүүдийн тоо, тухайн усан онгоцны гаалийн нутаг дэвсгэрт байх хугацааг харгалзан шаардлагатай тоо хэмжээг тогтооно.

**11. Практик зөвлөмж**

Усан онгоцны зогсоолд байгаа эсхүл засвар хийлгэж байгаа усан онгоцноос багийн гишүүд хэрэглээний зориулалтаар татваргүй барааг гаргах бол тухайн усан онгоцны байх хугацааг үндэслэлтэй гэж үзсэн тохиолдолд гаалийн байгууллага зөвшөөрөл олгоно.

**12. Практик зөвлөмж**

Гаалийн нутаг дэвсгэр дээрх нэг, эсхүл түүнээс дээш онгоцны буудалд нисэх онгоц газардах нөхцөлд гаалийн байгууллага тухайн онгоцыг дундын буудлуудад байх болон тэдгээр буудлуудын хооронд нисэх үед хэрэглээний зориулалтаар татваргүй бараа олгохыг зөвшөөрнө.

(d) Гаалийн хяналт

**13. Стандарт**

Шаардлагатай үед татваргүй барааг лацдах гэх мэтээр татваргүй барааг зөвшөөрөлгүй ашиглахыг зогсоох талаар зохих арга хэмжээ авахыг гаалийн байгууллага тээвэрлэгчээс шаардана.

**14. Стандарт**

Гаалийн байгууллага зөвхөн шаардлагатай гэж үзсэн тохиолдолд өөр газар хадгалах зорилгоор гаалийн нутаг дэвсгэрт байгаа усан онгоц, нисэх онгоц эсхүл галт тэрэгнээс татваргүй барааг шилжүүлэхийг тээвэрлэгчээс шаардана.

**Гаалийн болон бусад татвараас чөлөөлөгдөх бараагаар хангах**

**15. Стандарт**

Гадаадын чиглэлд явах усан онгоц болон нисэх онгоцонд гаалийн болон бусад татвараас чөлөөлөгдөх дараахь барааг авч явахыг зөвшөөрнө.

а. гаалийн байгууллага зорчигч болон багийн гишүүд, мөн аялал эсхүл нислэгийн хугацаа болон түүн дээр өмнө нь байгаа татваргүй барааны тоо хэмжээг харгалзан шаардлагатай гэж үзсэн тоо хэмжээ бүхий татваргүй барааг;

b. онгоцон дээр байгаа татваргүй барааны тоо хэмжээг харгалзан аяллын, эсхүл нислэгийн хугацаанд онгоцны ажиллагаа болон үйлчилгээнд зохистой гэж үзсэн тоо хэмжээний хэрэглээний зориулалттай татваргүй барааг онгоцны ажиллагааны болон үйлчилгээний зориулалтаар.

**16. Стандарт**

Гаалийн нутаг дэвсгэрт ирсэн бөгөөд гаалийн нутаг дэвсгэр доторх сүүлчийн зогсоол руу явах үеийн аялалд зориулан усан онгоц болон нисэх онгоцонд гаалийн болон бусад татвараас чөлөөлөгдөх бараагаа нөхөн сэлбэхийг зөвшөөрнө.

**17. Стандарт**

Гаалийн нутаг дэвсгэрт зогсож байгаа усан онгоц болон нисэх онгоцонд нийлүүлж буй хэрэглээний зориулалттай татваргүй барааг энэ бүлэгт хэрэглэж болох гаалийн нутаг дэвсгэр рүү ирж байгаа усан онгоц болон нисэх онгоцонд буй хэрэглээний зориулалттай татваргүй бараанд олгодог адил нөхцөлөөр олгож болно.

**Явах**

**18. Практик зөвлөмж**

Татваргүй бараанд холбогдолтой салангид мэдүүлгийг гаалийн нутаг дэвсгэрээс гарч байгаа усан онгоцноос шаардахгүй.

**19. Стандарт**

Гаалийн нутаг дэвсгэрээс гарч буй, эсхүл нисэх онгоцонд оруулсан татваргүй барааны хувьд мэдүүлэг шаардах тохиолдолд шаардагдах мэдээлэл нь гаалийн хяналтад хэрэглэх аль болох цөөн мэдээлэл байна.

**Татваргүй барааны бусад олголт**

**20. Стандарт**

Гаалийн нутаг дэвсгэрт ирж байгаа усан онгоц, нисэх онгоц болон галт тэргэнд буй татваргүй барааг дараахь тохиолдолд зөвшөөрнө.

а. дотоодын хэрэглээнд зориулан оруулах горимоор бүрдүүлэлт хийх бараа, эсхүл гаалийн бүрдүүлэлтийн өөр горим хэрэглэх бараа, тэгэхдээ аль ч тохиолдолд нөхцөл байдал болон гаалийн бүрдүүлэлтийн ажиллагаанд нийцсэн; эсхүл

b. зөвхөн гаалийн байгууллагаас урьдчилан зөвшөөрөл авсан тохиолдолд олон улсын тээврийн өөр усан онгоц, нисэх онгоц, эсхүл галт тэргэнд шилжүүлсэн.

**5 дугаар бүлэг**

**ТУСЛАМЖИЙН БАРАА**

**Тодорхойлолт**

Энэхүү Бүлгийн зорилгоор:

E1./F1.

**"тусламжийн бараа"** гэж:

- автомашин болон тээврийн бусад хэрэгсэл, хүнсний зүйлс, эм, хувцас, хөнжил, майхан, угсармал байшин, ус цэвэршүүлэх болон ус хадгалах төхөөрөмж, эсхүл зайлшгүй хэрэгцээт бусад бараа зэргийг оролцуулан байгалийн гамшигт өртсөн этгээдэд тусламж болгон өгсөн барааг; болон

- бүх тоног төхөөрөмж, автомашин болон тээврийн бусад хэрэгсэл, ялангуяа сургуультай амьтан, хүнс, материал, хувийн хэрэглээний зүйлс болон гамшиг болсон нутаг дэвсгэрт байгаа тусламжийн ажилтнуудын ажиллах болон амьдрах хугацаанд ажил үүргээ гүйцэтгэхэд нь болон тэдэнд дэмжлэг үзүүлэхэд зориулсан бусад бараа.

**Зарчим**

**1. Стандарт**

Тусламжийн бараанд хийх гаалийн бүрдүүлэлтийг энэхүү Бүлгийн заалт болон холбогдолтой бол Ерөнхий Хавсралтын заалтуудаар зохицуулна.

**2. Стандарт**

Экспортлох, дамжин өнгөрөх, түр хугацаагаар оруулах болон импортлох зориулалт бүхий тусламжийн барааны бүрдүүлэлтийг тэргүүн ээлжинд хийнэ.

**Үйлчлэх хүрээ**

**3. Стандарт**

Гаалийн байгууллага тусламжийн барааны хувьд дараахь хөнгөлөлтийг үзүүлнэ:

- тусгайлан тогтоосон хугацаанд мэдүүлгийг гүйцээн бөглөх нөхцөлтэйгээр барааны хялбарчилсан мэдүүлгээр, эсхүл барааны бүрэн бус түр мэдүүлгээр мэдүүлэх,

- барааны гаалийн мэдүүлэг, дагалдах бичиг баримтыг бараа ирэхээс өмнө болон хүрч ирсэн барааг эзэнд нь олгохоос өмнө шалгах, бүртгэх,

- гаалийн байгууллага бахгүй газраар буюу ажлын бус цагаар бүрдүүлэлт хийх, холбогдох төлбөр хийхийг шаардахгүй байх,

- зөвхөн онцгой нөхцөлд барааг шалгах, дээж авах.

**4. Практик зөвлөмж**

Тусламжийн барааны бүрдүүлэлтийг аль улсаас гаралтай, аль улсаас ирж байгаа эсхүл ямар улсад очихоос үл хамааран хийнэ.

**5. Практик зөвлөмж**

Тусламжийн барааны хувьд бусад бараанд тавих эдийн засаг, экспортын хориг, эсхүл хязгаарлалт болон экспортын гаалийн болон бусад татвар авахгүй.

**6. Практик зөвлөмж**

Холбогдох байгууллагуудын зөвшөөрлөөр бэлгийн журмаар авсан бөгөөд тэдний өөрсдийн ашиглах, эсхүл тэдний хяналтын дор ашиглах, эсхүл тэдний хуваарилсан, эсхүл тэдний хяналтын дор үнэ төлбөргүй хуваарилсан тусламжийн барааг импортын гаалийн болон бусад татвараас чөлөөлөх бөгөөд эдийн засаг, импортын хориг, эсхүл хязгаарлалт хийхгүй.

**ТУСГАЙ ХАВСРАЛТ К**

**1 дүгээр бүлэг**

**ГАРАЛ ҮҮСЛИЙН ДҮРЭМ**

**Тодорхойлолт**

Энэхүү Бүлгийн зорилгоор:

E1./F2.

**"Барааны гарал үүслийн улс"** гэж гаалийн тариф, тоон хязгаарлалт эсхүл худалдаатай холбогдох бусад арга хэмжээг хэрэглэх зорилгоор тогтоосон шалгуурын дагуу бараа үйлдвэрлэсэн улсыг хэлнэ;

E2./F3.

**"Гарал үүслийн дүрэм"** гэж барааны гарал үүслийн улс орныг тогтооход үндэсний хууль тогтоомж, эсхүл олон улсын гэрээ ("гарал үүслийн шалгуур") – гээр тогтоогдсон зарчмын үндсэн дээр боловсруулсан тусгай заалтыг хэлнэ;

E3./F1.

**"Ихээхэн өөрчлөлтийн шалгуур"** гэж барааны эцсийн үндсэн үйлдвэрлэл эсхүл боловсруулалт хийгдэж тухайн барааны онцлог шинж чанарыг бий болгосон улсыг гарал үүслийн улсаар тодорхойлох шалгуурыг хэлнэ.

**Зарчим**

**1. Стандарт**

Барааг импортлох, экспортолоход гаалийн хариуцсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай гарал үүслийн дүрэм нь энэхүү Бүлгийн заалт болон холбогдолтой бол Ерөнхий Хавсралтын заалтын дагуу боловсруулагдсан байна.

**Гарал үүслийн дүрэм**

**2. Стандарт**

Тухайн улсад бүтнээрээ үйлдвэрлэгдсэн барааг тухайн улсаас гарал үүсэлтэй гэж тооцно. Тухайн улсад бүрэн хэмжээгээр үйлдвэрлэгдсэн бараа гэдэгт дараахь зүйлсийг ойлгоно:

a. тухайн улсын газрын хөрс, ус, нутаг дэвсгэрт хамаарах далай, тэнгис, түүний гүнээс олборлосон эрдэс бүтээгдэхүүн;

b. тухайн улсад тарьж ургуулсан, хураасан хүнсний ногоогоор хийсэн бүтээгдэхүүн;

c. тухайн улсад өсгөж үржүүлсэн мал амьтан;

d. тухайн улсын мал амьтдаас гаргаж авсан бүтээгдэхүүн;

e. тухайн улсад хийгдсэн ан, загас агнуураас гаргаж авсан бүтээгдэхүүн;

f. тухайн улсын далай, тэнгисээс тэдний усан онгоцоор агнасан загасаар хийсэн бүтээгдэхүүн болон далайгаас гаргаж авсан бусад бүтээгдэхүүн;

g. дээрх (f) хэсэгт заасан бүтээгдэхүүнээс гаргаж тухайн улсын үйлдвэрийн усан онгоцон дээр гаргаж авсан бүтээгдэхүүн;

h. тухайн улсын нутаг дэвсгэрт хамаарах далай, тэнгисээс гаднахь далай тэнгисийн хөрс, хөрсний гүнээс олборлосон бүтээгдэхүүн. Энэ тохиолдолд тухайн улс зөвхөн тэр хөрс, хөрсний гүнд ажиллах онцгой эрхтэй байна;

i. Тухайн улсад үйлдвэрлэл, боловсруулалтын үйл явцад гарсан хаягдал, өөдөс, түүнчлэн тухайн улсад хэрэглэгдсэн болон эвдүүлж цуглуулсан зүйлс. Эдгээр нь зөвхөн түүхий эдийг сэргээхэд зориулагдсан байна;

j. Зөвхөн дээрх (a)-(i)-д хамаарах бүтээгдэхүүнээр тухайн улсад үйлдвэрлэсэн бараа.

**3. Практик зөвлөмж**

Барааны үйлдвэрлэлд хоёр эсхүл түүнээс дээш улс оролцсон бол барааны гарал үүсэл нь ихээхэн хэмжээний өөрчлөлтийн шалгуурын дагуу тодорхойлогдоно.

**4. Практик зөвлөмж**

Ихээхэн хэмжээний өөрчлөлтийн шалгуурыг хэрэглэж байгаа тохиолдолд Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан системийн тухай олон улсын конвенцийн дагуу хэрэглэнэ.

**5. Практик зөвлөмж**

Барааны нийт үнийн дүнд татварыг хувиар ногдуулахад ихээхэн хэмжээний өөрчлөлтийн шалгуурыг хэрэглэх бол дараахь үнийг анхааралдаа авбал зохино:

- импортлох материалын хувьд импортлох үеийн татвар ногдуулбал зохих үнэ, гарал үүсэл нь тодорхой бус материалын хувьд үйлдвэрлэл явагдсан улсын нутаг дэвсгэрт төлөгдсөн байж болох анхны үнэ;

- үйлдвэрлэгдсэн барааны хувьд, үйлдвэрийн үнэ эсхүл үндэсний хууль тогтоомжийн дагуу экспортын үнэ.

**6. Практик зөвлөмж**

Барааны үндсэн шинж, онцлогт огт өөрчлөлт ороогүй, орсон ч бага хэмжээгээр өөрчлөлт орох үйл ажиллагаа, тухайлбал дор дурдсан үйл ажиллагааг ихээхэн хэмжээний боловсруулалт эсхүл үйлдвэрлэлийн аргаар боловсруулалт хийгдээгүй гэж үзнэ:

a. барааг тээвэрлэх, хадгалах явцад гарах зайлшгүй үйл ажиллагаа;

b. барааг савлах, эсхүл барааны зах зээлд өрсөлдөх чадварыг сайжруулах үйл ажиллагаа, барааг ачуулахаар бэлтгэх, тухайлбал задгай барааг савлах, савлахаар хэсэглэх, ангилах, дугаарлах, дахин савлах;

c. энгийн угсрах үйл ажиллагаа;

d. өөр өөр гарал үүсэлтэй барааг холих, ингэхдээ шинээр үүсэх бүтээгдэхүүний шинж чанар нь хольсон барааны шинж чанараас нэг их өөргүй байх.

**Гарал үүслийг тогтоох тусгай тохиолдлууд**

**7. Практик зөвлөмж**

Машин техник, хэрэгсэл, аппарат эсхүл тээврийн хэрэгсэлтэй хамт хэрэглэх туслах хэрэгсэл, сэлбэг болон багаж нь машин техник, хэрэгсэл, аппарат эсхүл тээврийн хэрэгслийн нэг адил гарал үүсэлтэйд тооцогдох бөгөөд ингэхдээ тэд тоног хэрэгсэл, түүний дугаар нь хоорондоо тохирч хамт зарагдсан байх ёстой.

**8. Практик зөвлөмж**

Нэг ачилтаар оруулахад тээврийн эсхүл үйлдвэрлэлийн шалтгаанаас болон тохиромжгүй учраас импортлогчийн хүсэлтээр нэгээс илүү ачилтаар импортлогдсон угсраагүй эсхүл задалж салгасан зүйлсийг гарал үүслийг нь тодорхойлохдоо нэг бараа хэмээн тооцно.

**10. Практик зөвлөмж**

Барааны гарал үүслийг тодорхойлох зорилгоор баглаа боодлыг бараатай адил гарал үүсэлтэй гэж тооцвол, ялангуяа хувиар тооцох аргыг хэрэглэж байгаа бол жижиглэн худалдаагаар энгийн байдлаар зарагдаж байгаа барааны баглаа боодлын талаар ярьж байгааг анхааралдаа авбал зохино.

**11. Стандарт**

Барааны гарал үүслийг тодорхойлоход барааны үйлдвэрлэл, боловсруулалтад ашигласан цахилгаан эрчим хүч, машин тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн гарал үүслийг тооцохгүй.

**Шууд тээвэрлэх дүрэм**

**12. Практик зөвлөмж**

Барааг гарал үүслийн улсаас шууд тээвэрлэх заалт байгаа бол, ялангуяа газар зүйн шалтгаанаас (жишээлбэл, далайд гарцгүй улсын хувьд) болон гуравдагч улсд гаалийн хяналтад байгаа барааны хувьд (жишээлбэл, үзэсгэлэн яармаг, эсхүл гаалийн баталгаат агуулахад байгаа барааны хувьд) зөрүү гарч болохыг зөвшөөрвөл зохино.

**Гарал үүслийн дүрмийн талаарх мэдээлэл**

**13. Стандарт**

Гарал үүслийн дүрэмд, эсхүл түүнийг хэрэгжүүлэх журамд орсон өөрчлөлт нь экспортын зах зээл, нийлүүлэгч улсын аль алинд сонирхогч этгээдүүд хангалттай мэдээлэл авч шинэ заалтыг анхааралдаа авсны дараагаар зөвхөн хүчин төгөлдөр болно.

**2 дугаар бүлэг**

**ГАРАЛ ҮҮСЛИЙГ БАРИМТААР НОТЛОХ**

**Тодорхойлолт**

Энэхүү Бүлгийн зорилгоор:

E1./F2.

**"гарал үүслийн гэрчилгээ"** гэж эрх бүхий байгууллагын олгосон барааны гарал үүслийг гэрчилж, барааг тодорхойлсон тусгай маягтыг хэлнэ.

Энэхүү гэрчилгээ нь үйлдвэрлэгч, боловсруулагч, нийлүүлэгч, экспортлогч болон бусад эрх бүхий этгээдийн гаргасан мэдүүлэгийг багтааж байж болно.

E2./F3.

**"гарал үүслийг гэрчилсэн мэдүүлэг"** гэж гэрчлэх эрх бүхий байгууллага, этгээдийн баталгаажуулсан гарал үүслийн мэдүүлгийг хэлнэ.

E3./F4.

**"гарал үүслийн мэдүүлэг"** гэж барааг экспортлохтой холбогдуулан үйлдвэрлэгч, боловсруулагч, экспортлогч болон бусад эрх бүхий этгээд үнийн нэхэмжлэх болон бараатай холбогдох баримтанд уг барааны гарал үүслийн талаар гаргасан мэдүүлгийг хэлнэ.

E4./F5

**"гарал үүслийг нотлох баримт"** гэж барааны гарал үүслийн гэрчилгээ, гарал үүслийн баталгаажсан мэдүүлэг, эсхүл гарал үүслийн мэдүүлгийг хэлнэ.

E5./F1.

**"бүс нутгийн харьяаны гэрчилгээ"** гэж эрх бүхий байгууллага, этгээдийн гаргасан журмын дагуу барааны гарал үүслийг тухайн бүс нутгийн онцлогт тохируулан тодорхойлсон гэрчилгээг хэлнэ ( тухайлбал, Champagne, Port wine, Parmasen cheese гэх мэт).

**Зарчим**

**1. Стандарт**

Барааны гарал үүсэлтэй холбогдох бичиг баримтыг шаардах, тогтоох болон олгохдоо энэхүү Бүлгийн заалт, холбогдолтой бол Ерөнхий Хавсралтын заалтаар зохицуулагдана.

**Гарал үүслийг нотлох баримт шаардах**

**2. Практик зөвлөмж**

Барааны гарал үүслийг нотлох баримтыг гаалийн хөнгөлөлтийн тариф хэрэглэх, нэг талаас баталсан эдийн засаг, худалдааны арга хэмжээ авсан, эсхүл хоёр талын болон олон талт хэлэлцээрийн дагуу эсхүл нийгмийн эрүүл мэнд, хэв журмын шалтгаанаар арга хэмжээ авч байгаа үед шаардана.

**3. Практик зөвлөмж**

Гарал үүслийг дараахь тохиолдолд баримтаар нотлохыг шаардахгүй:

a. нийт үнийн дүн нь 100 ам. доллараас хэтрэхгүй буюу арилжааны шинж чанаргүй, хувь хүнд хаягласан жижиг хэмжээний бараа буюу зорчигчийн ачаа тээшинд авч яваа бараа;

b. нийт үнийн дүн нь 60 ам. доллараас хэтрэхгүй арилжааны зориулалттай бараа;

c. түр хугацаагаар оруулахыг зөвшөөрсөн бараа;

d. гаалиар дамжуулан өнгөрүүлэх бараа;

e. бүс нутгийн харьяаны гэрчилгээтэй, гарал үүслийг баримтаар нотлох шаардлагагүй, нийлүүлж байгаа улсынх нь нөхцөл хоёр талт болон олон талт хэлэлцээрт нийцсэн зарим төрлийн бараа.

(a) буюу (b)-д заагдсан хэд хэдэн ачааг нэг удаагийн ачилтаар, нэг тээврийн хэрэгслээр, нэг хүлээн авагчид, нэг илгээгчээс явуулсан бол эдгээр ачилтын нийт үнийг тооцно.

**4. Практик зөвлөмж**

Гарал үүслийг баримтаар нотлох шаардлагатай холбогдсон дүрмийг нэгдмэл байдлаар боловсруулсан бол түүнийг тогтоосон үеийн эдийн засаг, худалдааны нөхцөл байдлын өөрчлөлттэй зохицож байгаа эсэхийг гурван жил тутамд хянан үзнэ.

**5. Практик зөвлөмж**

Гарал үүслийн улсын эрх бүхий байгууллагаас олгосон нотлох баримтыг импортлогч улсын гаалийн байгууллага хуурамч байна гэж сэжиглэх үндэслэлтэй бол шаардана.

**Гарал үүслийг нотлох баримтын янз бүрийн төрлийн маягт болон өргөдөл**

(a) Гарал үүслийн гэрчилгээ

**Маягт, агуулга**

**6. Практик зөвлөмж**

Гарал үүслийн гэрчилгээний эдгээр маягтыг сайжруулах, эсхүл шинэ маягтыг боловсруулахдаа Хэлэлцэн тохирогч талууд энэхүү Бүлгийн Зүүлт 1-д өгөгдсөн загварыг Зүүлт 3-т заасан Дүрмийг анхааралдаа авч Зүүлт 2-т заасан зааврын дагуу ашиглана.

Энэхүү Бүлгийн Зүүлт 1-д заасан загвар маягтын дагуу гарал үүслийн гэрчилгээгээ хийсэн Хэлэлцэн тохирогч талууд Гаалийн хамтын ажиллагааны Зөвлөлийн Ерөнхий нарийн бичгийн даргад энэ тухайгаа мэдэгдэнэ.

**Ашиглах хэл**

**7. Практик зөвлөмж**

Гарал үүслийн гэрчилгээний маягтыг экспортлогч улсын сонгосон хэл дээр хэвлэх бөгөөд тэрхүү хэл нь англи, франц хэлний аль нэг нь биш бол англи эсхүл франц хэл дээр хэвлэнэ.

**8. Практик зөвлөмж**

Гарал үүслийн гэрчилгээг импортлогч улсын хэл дээр хэвлээгүй байвал тэрхүү улсын гаалийн байгууллага гарал үүслийн гэрчилгээн доторхи мэдээллийн орчуулгыг шаардахгүй.

**Гарал үүслийн гэрчилгээг олгох эрх бүхий газрууд, бусад байгууллагууд**

**9. Стандарт**

Энэхүү Бүлгийг хүлээн зөвшөөрч байгаа Хэлэлцэн тохирогч талууд хүлээн зөвшөөрөх тухай мэдэгдэл өгөхдөө, эсхүл бараа нь гарал үүслийн гэрчилгээг олгох эрх бүхий газар, байгууллагуудаа тогтооно.

**10. Практик зөвлөмж**

Бараа гарал үүслийн улсаас шууд импортлогдоогүй, гуравдагч улсын нутаг дэвсгэрээр дамжин орж ирсэн бол гарал үүслийн гэрчилгээг тэрхүү гуравдагч улсад ийм гэрчилгээг олгох эрх бүхий газар, байгууллагаас олгосон байхыг зөвшөөрч болох бөгөөд ингэхдээ барааны гарал үүслийн улсад өмнө нь олгосон гэрчилгээн дээр үндэслэн олгосон байна.

**11. Практик зөвлөмж**

Гарал үүслийн гэрчилгээг олгох эрх бүхий газар, байгууллага олгож байгаа гэрчилгээгээ хоёр жилийн дотор хэрэглэгдэх, хуулбарыг хянах эрхтэйгээр олгоно.

(b) гарал үүслийн гэрчилгээнээс бусад нотлох баримт

**12. Практик зөвлөмж**

Гарал үүслийг нотлох бичиг баримт шаардаж байгаа бол дараахь нөхцөлд гарал үүслийн мэдүүлгийг хүлээн зөвшөөрнө:

a. нийт үнийн дүн нь 500 ам. доллараас хэтрэхгүй буюу арилжааны шинж чанаргүй, хувь хүнд хаягласан жижиг хэмжээний бараа эсхүл зорчигчийн ачаа тээшид авч яваа бараа;

b. нийт үнийн дүн нь 300 ам. доллараас хэтрэхгүй арилжааны зориулалттай бараа.

(a) буюу (b)-д заагдсан хэд хэдэн ачааг нэг удаагийн ачилтаар, нэг тээврийн хэрэгслээр, нэг хүлээн авагчид, нэг илгээгчээс явуулсан бол эдгээр ачилтын нийт үнийг тооцно.

**Хүлээлгэх хариуцлага**

**13. Стандарт**

Гарал үүслийг баримтаар нотлохын тулд хуурамч мэдээлэл агуулсан бичиг баримтыг бэлтгэдэг, бэлтгэх боломжийг бүрдүүлсэн хүнд хариуцлага хүлээлгэх тухай заалтыг боловсруулна.

**ЗҮҮЛТ I**

<table>
<tr><td>1. Экспортлогч (нэр, хаяг, улс)</td><td colspan="3" rowspan="3">2. Дугаар<br><br>ГАРАЛ ҮҮСЛИЙН ГЭРЧИЛГЭЭ</td></tr>
<tr><td>3. Хүлээн авагч (нэр, хаяг, улс)</td></tr>
<tr><td>4. Тээврийн хэрэгсэл (шаардлагатай бол)</td></tr>
<tr><td colspan="2">5. Марк, Дугаар: Баглаа боодлын дугаар болон төрөл: Барааны тодорхойлолт</td><td>6. Нийт жин</td><td>7.</td></tr>
<tr><td>8. Бусад мэдээлэл<br><br>Тамга</td><td colspan="3">Дээрх бараа ................ улсын гарал үүсэлтэй болохыг гэрчлэв.<br>____________________<br>ГЭРЧЛЭГЧ БАЙГУУЛЛАГА<br>____________________<br>Олгосон газар болон он сар, өдөр<br>____________________<br>Гарын үсэг</td></tr>
</table>

**ЗҮҮЛТ II**

**Тайлбар**

1. Гэрчилгээний хэмжээ нь олон улсын стандартын ISO хэмжээ A4 (210x297mm, 8.27x11.69 inches) байна. Маягтын дээд зах 10 мм, зүүн зах нь 20 мм байна. Мөр хоорондын зай 4.24 мм. (1/6 инч), өргөөшөө зай нь 2.54 мм (1/10 мм). Гэрчилгээний загвар нь Европын Холбооны загвартай тохирсон байх бөгөөд Зүүлт 1-д заасантай адил байна. Гэрчилгээг олгогч улсын тусгайлсан шаардлагаар хүснэгтүүдэд үл ялиг өөрчлөлт орж болох бөгөөд энэ нь метрийн хэмжээнээс өөр хэмжигдэхүүн хэрэглэдэг, тухайн улсын үндэстний бичиг баримтын системийн онцлог зэргээс шалтгаалж болно.

2. Гарал үүслийн гэрчилгээнд өргөдөл гаргах шаардлагатай бол өргөдлийн маягт, гэрчилгээний маягт хоёр нь хоорондоо таарч тохирч байна.

3. Улсууд цаасны метр квадрат тутмын жин болон хуурамчаар үйлдэхээс сэргийлэн машинаар эргүүлсэн суурь ашиглахыг зөвшөөрч болно.

4. Гарал үүслийн гэрчилгээг хэрхэн үйлдэх талаар хэрэглэгчдэд зориулсан лавламжийг гэрчилгээний ар талд хэвлэж болно.

5. Захиргааны тусламжийг харилцан олгох тухай хэлэлцээрийн дагуу дахин хянах хүсэлт гарвал бөглөх зорилгоор гэрчилгээний ар талд зай үлдээж болно.

6. Загвар маягтад дараахь тайлбарыг хийнэ:

Хүснэгт 1: "Ачуулагч", "үйлдвэрлэгч", "нийлүүлэгч" гэснийг "экспортлогч"-оор орлуулж болно.

Хүснэгт 2: Энд зөвхөн ганцхан эх хувь гарал үүслийн гэрчилгээ байх бөгөөд баримтын дээд хэсэгт "Жинхэнэ эх хувь" гэсэн үгтэй байна. Гарал үүслийн гээгдсэн гэрчилгээг орлуулах зорилгоор гэрчилгээг хийсэн бол орлуулагч гэрчилгээ нь дээд талдаа "Хуулбар" гэсэн үгтэй байна. Жинхэнэ эх хувь болон орлуулагч гэрчилгээний хувийн дээд талд нь "хуулбар хувь" гэсэн үг байна.

Энэ хүснэгтэд мөн гэрчилгээ олгогч байгууллагын нэр (эмблем, сүлд) –ийг бичих бөгөөд албан хэрэгцээнд зориулсан зайг мөн үлдээнэ.

Хүснэгт 3: Энэ хүснэгтэд байгаа зүйлийг "захиалах" гэсэн үгээр сольж хүрэх улсыг бичих юм.

Хүснэгт 4: Энэ хүснэгтэд тээврийн хэрэгсэл, замын тухай нэмэлт мэдээлэл байх бөгөөд үүнийг жишээ нь гэрчилгээг олгогч байгууллага хүсвэл бөглөж болох юм.

Хүснэгт 5: Барааны дугаар шаардлагатай бол энд заагдах бөгөөд ингэхдээ эхний хүснэгтэд орно. "Марк, дугаар" нь "Баглаа боодлын тоо, төрөл" болон "Барааны тодорхойлолт" –оос босоо шугамаар таслагдана. Шугам байхгүй бол эдгээр мэдээллийг тохирох зайгаар ялгана. Барааны тодорхойлолт гэсэн хэсэгт БТКУС –ийн ангиллын дугаарыг баруун талд нь бичнэ. Гарал үүслийн шалгуур шаардлагатай бол энэ хүснэгтэд бичих бөгөөд бусад мэдээллээс босоо шугамаар тасална.

Хүснэгт 6. Барааны нийт жин барааг тодорхойлоход гол төлөв үүрэг гүйцэтгэдэг.

Хүснэгт 7. Энэ хүснэгтийг нэмэлт нарийвчилсан мэдээлэлд зориулан хоосон үлдэх бөгөөд хэмжих нэгж буюу холбогдох бусад бичиг баримт ( нэхэмжлэх гэх мэт ) зэргийг оруулж болно.

Хүснэгт 6, 7: Экспортлогчоос барааг ялгаж таних явдлыг хөнгөвчлөх үүднээс оруулах бусад тоо хэмжээг 6, 7 дугаар хүснэгтийн аль тохироход оруулж бичнэ.

Хүснэгт 8. Энэ зайг эрх бүхий байгууллагаас гэрчлэх мэдээлэл ( тамга, тэмдэг, гарын үсэг, олгосон он сар өдрийг гэрчлэх )-д зориулсан. Олгох байгууллагаас ямар үг, үсэг бичихийг шийдэх бөгөөд энэхүү загварт байгаа үг бол зөвхөн жишээ юм. Энэ хүснэгтэд экспортлогч (эсхүл бараа нийлүүлэгч, үйлдвэрлэгч) гарын үсэг зуран мэдүүлэг болгон ашиглаж болно.

**ЗҮҮЛТ III**

**Гарал үүслийн гэрчилгээг бөглөх дүрэм**

Гарал үүслийн гэрчилгээг бөглөх дүрэм (эсхүл шаардлагатай тохиолдолд ийм гэрчилгээний

өргөдөл)-ийг дээрх Тайлбарт дурдсаныг анхааралдаа авч үндэсний байгууллага тогтооно. Гэхдээ дараахь заалттай тохирсон байх шаардлагатай:

1.Эдгээр маягтыг арилж балрахааргүйгээр, гаргагдахуйцаар ямар нэг хэрэгслээр бөглөсөн байх ёстой.

2.Гэрчилгээ (өргөдөл)-нд ямар нэг сохолж, балласан зүйл байж болохгүй. Аливаа засварыг хийхдээ алдаатай зүйлийг дараад нэмэлт зүйлийг оруулж ирсэн байдлаар хийнэ. Өөрчлөлтийг хийсэн хүн нь баталгаажуулж холбогдох эрх бүхий байгууллага, газар үүнийг гэрчилсэн байна.

3.Ашиглаагүй зайг нэмэлт мэдээлэл орохоос сэргийлэн хэрээсээр тэмдэглэнэ.

4.Экспортлох зорилгоор эх хувиас гадна нэг буюу түүнээс дээш хувийг үйлдэж болно.

## 3 дугаар бүлэг
## ГАРАЛ ҮҮСЛИЙН НОТЛОХ БАРИМТЫГ ШАЛГАХ

**Тодорхойлолт**

Энэхүү Бүлгийн зорилгоор:

E1./F1.

**"гарал үүслийн гэрчилгээ"** гэж эрх бүхий байгууллагын олгосон барааны гарал үүслийг гэрчилж, барааг тодорхойлсон тусгай маягтыг хэлнэ. Энэхүү гэрчилгээ нь үйлдвэрлэгч, боловсруулагч, нийлүүлэгч, экспортлогч болон бусад эрх бүхий этгээдийн гаргасан мэдүүлгийг багтааж болно.

E2./F2.

**"гарал үүслийг гэрчилсэн мэдүүлэг"** гэж гэрчлэх эрх бүхий байгууллага, этгээдийн баталгаажуулсан гарал үүслийн мэдүүлгийг ойлгоно.

E3./F3.

**"гарал үүслийн мэдүүлэг"** гэж барааг экспортлохтой холбогдуулан үйлдвэрлэгч, боловсруулагч, экспортлогч болон бусад эрх бүхий этгээд үүний нэхэмжлэх болон бараатай холбогдох баримтанд уг барааны гарал үүслийн талаар гаргасан мэдүүлгийг хэлнэ.

E4./F4.

**"гарал үүслийг нотлох баримт"** гэж барааны гарал үүслийн гэрчилгээ, гарал үүслийн баталгаажсан мэдүүлэг, эсхүл гарал үүслийн мэдүүлгийг ойлгоно.

**Зарчим**

**1. Стандарт**

Гарал үүслийг баримтаар нотлоход захиргааны тусламж авахад энэхүү Бүлгийн заалт, шаардлагатай бол Ерөнхий Хавсралтын заалтыг хэрэглэнэ.

**Харилцан адил байх зарчим**

**2. Стандарт**

Хяналт тавих хүсэлтийг хүлээн авч буй Хэлэлцэн тохирогч талын эрх бүхий байгууллага нь хэрвээ хүсэлт гаргаж байгаа Хэлэлцэн тохирогч талын эрх бүхий байгууллага тэрхүү тусламжийг үзүүлэх чадваргүй байвал тухайн хүсэлтийг биелүүлэхгүй байж болно.

**Хяналт тавих хүсэлт**

**3. Практик зөвлөмж**

Энэхүү Бүлгийг хүлээн зөвшөөрсөн Хэлэлцэн тохирогч талын Гаалийн байгууллага энэхүү Бүлгийг хүлээн зөвшөөрсөн аливаа Хэлэлцэн тохирогч талын нутаг дэвсгэрт гарал үүслийг баримтаар нотлох талаар эрх бүхий байгууллагад хүсэлт гаргаж дараахь тохиолдолд хяналт тавихыг хүсч болно:

a. бичиг баримтын жинхэнэ эсэхэд эргэлзэх тодорхой үндэслэл байгаа бол;

b. эдгээр бичиг баримтад байгаа мэдээлэл үнэн зөв эсэхэд эргэлзэх тодорхой үндэслэл байгаа бол;

c. үе үе хянах байдлаар.

**4. Стандарт**

Үе үе хянах хүсэлтийг дээрх Практик зөвлөмж 3-ын "с"-д заасны дагуу гаргах бөгөөд тохирох хяналтыг шаардагдах хэмжээгээр аль болох багаар хийнэ.

**5. Стандарт**

Хяналт тавих хүсэлтийг гаргахдаа:

a. хүсэлт гаргаж байгаа гаалийн байгууллага бичиг баримтын жинхэнэ эсэхэд эргэлзэж байгаа шалтгаан, эсхүл үе үе хянах хүсэлт гарган тэнд байгаа мэдээллийн үнэн зөв эсэхийг шалгах шалтгааныг онцлон дурдах;

b. импортлогч улсад хэрэглэгдэж байгаа гарал үүслийн дүрэм болон тэрхүү улсын хүсэлтэд дурдсан аливаа нэмэлт мэдээллийг шаардлагатай бол зааж өгөх;

c. шалгавал зохих гарал үүслийг нотолж байгаа баримт, эсхүл түүний зургийг хавсаргасан байх, шаардлагатай бол шалгалтыг хөнгөвчлөхөд тустай холбогдох бусад баримт, нэхэмжлэх, захидал харилцааны материалыг хавсаргана.

**6. Стандарт**

Энэхүү Бүлгийг хүлээн зөвшөөрсөн Хэлэлцэн тохирогч талаас хүсэлт хүлээн авсан эрх бүхий байгууллага өөрөө шаардлагатай хяналтын арга хэмжээ авах буюу тэрхүү зорилгоор шаардагдах мөрдөн шалгалтыг хийсэн захиргааны байгууллага, албан тушаалтан хийсний дараагаар хүсэлтэд хариу өгнө.

**7. Стандарт**

Хяналт хийх хүсэлтийг хүлээн авсан байгууллага хүсэлт гаргаж байгаа гаалийн байгууллагын тавьсан асуултад хариулж холбогдох бусад мэдээллийг мөн гарган өгнө.

**8. Стандарт**

Хяналт тавих хүсэлтэд хариу өгөхдөө зургаан сараас хэтрэхгүй, тогтсон хугацааны дотор өгнө. Хүсэлт хүлээн авсан байгууллага зургаан сарын дотор хариу өгч чадахгүй бол хүсэлт гаргасан Гаалийн байгууллагад мэдэгдэнэ.

**9. Стандарт**

Хяналт тавих хүсэлтийг тусгайлсан нөхцөл байдлаас бусад тохиолдолд тогтоосон хугацаанд биелүүлэх бөгөөд энэ нь Хэлэлцэн тохирогч талын Гаалийн байгууллагад хүсэлт гаргах бичиг баримтыг хүргүүлснээс хойш нэг жилээс хэтрэхгүй байна.

**Барааг эзэнд нь олгох**

**10. Стандарт**

Хяналт тавих хүсэлт нь уг бараа импортын аливаа хориг, хязгаарлалтад хамааргдсан, эсхүл луйвар хийсэн гэж сэжиглэх үндэслэл байгаагаас бусад тохиолдолд барааг эзэнд нь олгоход татгалзах нөхцөл болохгүй.

**Бусад заалт**

**11. Стандарт**

Энэхүү Бүлгийн заалтын дагуу дамжуулсан аливаа мэдээллийг зөвхөн Гаалийн зорилгоор ашиглах бөгөөд нууцын зэрэглэлд хамаарна.

**12. Стандарт**

Эрх бүхий байгууллага болон зөвшөөрөл бүхий газрын олгосон барааны гарал үүслийг баримтаар нотлоход хяналт тавих бичиг баримт нь зохих хугацааны дотор хадгалагдах бөгөөд нотлох баримтыг олгосон өдрөөс хойш хоёроос доошгүй жил байна.

**13. Стандарт**

Энэхүү Бүлгийг хүлээн зөвшөөрсөн Хэлэлцэн тохирогч талууд нь хяналт тавих хүсэлт хүлээн авах эрх бүхий байгууллагыг томилон тэдний хаягийг Зөвлөлийн Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэх бөгөөд тэрээр энэхүү Бүлгийг хүлээн зөвшөөрсөн бусад Хэлэлцэн тохирогч талуудад энэ тухай мэдээллийг дамжуулна.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
**Хаяг: <<Төрийн мэдээлэл>>** эмхтгэлийн зөвлөл.
Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх хэсэгт хэвлэв.
Улаанбаатар- 12
Төрийн ордон
☎ 265958
Индекс 14003
☎ 329487
Хэвлэлийн хуудас 6,5